



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН



КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ОЮУ ТОЛГОЙН МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

УЛААНБААТАР
2021 он



КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ОЮУ ТОЛГОЙН МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

УЛААНБААТАР
2021

Энэхүү судалгааны ажил МУИС-ийн ЭЗХ-гийн байр суурийг бус,
харин тухайн судлаачийн байр суурийг илэрхийлэх болно.

СУДАЛГААНЫ БАГИЙН

Ахлагч:

Х.ЦЭВЭЛМАА, Эдийн засгийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор

Зөвлөх:

Ч.ХАШЧУЛУУН, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш, доктор, профессор

Гишүүд:

Б.СУВД, МУИС-ийн Эмирет профессор

Б.ЭНХ-АМГАЛАН, МУИС-ийн Санхүүгийн тэнхимийн багш, доктор

Д.ХИШИГТ, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш, доктор

Б.МЯГМАРСҮРЭН, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш, доктор

Ш.ЭНХТУУЛ, МУИС-ийн Менежментийн тэнхимийн багш

С.АМАРТҮВШИН, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш

Г.БОЛОРМАА, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш

Г.НЯМБАЯР, МУИС-ийн Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2018 онд хийгдсэн “ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН МОНГОЛЫН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА”-тай танилцахыг хүсвэл доорх QR холбоосоор ороорой.



МУИС-ИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

14201 Улаанбаатар хот, ш/х-46А-430, Сүхбаатар
дүүрэг, Бага тойруу-4,

Утас/Факс: (976)7730-7730 (1233)

И-хаяг: ei@num.edu.mn

АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	4
ТАЛАРХАЛ.....	7
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	8
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	9
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ.....	11
I. ЗЭС, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨНИЙ ХАРЬЦУУЛАЛТ	13
1.1. Зэсийн дэлхийн эрэлт хэрэглээ.....	13
1.2. Ковид-19 үеийн дэлхийн зэсийн хэрэглээ, өөрчлөлт – зэсийн шинэ эрин үе.....	15
1.3. Монгол Улс.....	19
II. ОЮУ ТОЛГОЙН МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ.....	24
2.1. ДНБ ба гадаадын шууд хөрөнгө оруулалтын уялдаа.....	24
2.2. Оюу Толгойн татвар, төлбөр хураамжийн Монгол Улсын ДНБ-д үзүүлсэн үзүүлсэн нөлөө ..	26
2.3. Оюу Толгойн татвар, төлбөр хураамжийн Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогод үзүүлсэн нөлөө.....	28
2.4. Оюу Толгойн экспортын Монгол Улсын экспортын орлогод үзүүлсэн нөлөө.....	31
III. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮНДЭСНИЙ БА АЙМГИЙН ХЭМЖЭЭН ДЭХ ТАТВАР БҮРДҮҮЛЭЛТ, НОГДУУЛАЛТ БА КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ.....	35
3.1. Ковид-19 цар тахлын үед үндэсний татвар, нийгмийн даатгалд үзүүлсэн нөлөө.....	35
3.2. Ковид-19 цар тахлын орон нутгийн татвар, нийгмийн даатгалд үзүүлсэн нөлөө.....	39
3.3. Цар тахлын үеийн татвартай холбоотой асуудал: олон улсын туршлага.....	43
IV. ОТ ТӨСЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ.....	48
4.1. ОТ-н хөдөлмөр эрхлэлт ба Ковид-19 цар тахлын нөлөө.....	48
4.2. ОТ-н Монгол Улсын хөдөлмөр эрхлэлт, боловсролын салбарт оруулж буй хувь нэмэр ба Ковид-19 цар тахлын нөлөө.....	55
4.3. Дэлхийн зэсийн салбарын хөдөлмөр эрхлэлтэд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөө ..	64
V. ОЮУ ТОЛГОЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ.....	70
5.1. Өмнөговь аймгийн ДНБ-д Оюу Толгойн үзүүлсэн нөлөөлөл.....	70
5.2. Оюу Толгойн бүс нутагт үзүүлсэн нөлөө.....	74
5.3. Цар тахлын үед ОТ-н орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө.....	76
VI. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ОТ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ.....	82
6.1. ОТ ханган нийлүүлэгчдэд Ковид-19 цар тахлын үзүүлсэн нөлөө.....	82
6.2. Үржүүлэгчийн нөлөөний шинжилгээ.....	93
СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....	100
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	102
ХАВСРАЛТУУД.....	104
Хавсралт 1. Ажиллагсдаас авсан санал асуулгын маягт.....	104
Хавсралт 2. Ханган нийлүүлэгчдээс авсан санал асуулгын маягт.....	108

ХУРААНГУЙ

Дэлхий даяар Ковид-19 цар тахал үргэлжилж байгаа өнөө үед МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны баг Оюу Толгойн Монголын эдийн засагт үзүүлж байгаа нөлөөг макро түвшинд буюу эдийн засгийн өсөлт, экспорт, татварын орлого, гадаадын хөрөнгө оруулагчид болон дотоодын үйлдвэрлэгчдийн хооронд үйлдвэрлэлийн холбоос үүсэх талаас харуулж, тус төсөл дотоодын ханган нийлүүлэгчидтэй хамтран ажилласнаар тэдгээрийн үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөө, Монгол Улсын эдийн засаг, нийгэм, ялангуяа хөдөлмөрийн зах зээл, ажиллагсдын чадавхид гарч буй өөрчлөлтүүд, орон нутгийн хөгжил, орон нутгийн төсвийн бүрдэлт, дэлхийн зэсийн зах зээлийн хандлага, Монгол Улсын өөрийн нөөц боломж, цаашдын хандлага гэсэн нилээд өргөн хүрээнд судалгааг хийлээ.

Ковид-19 цар тахлын манай эдийн засагт үзүүлэх нөлөө нь асар өндөр байгаа үед энэ судалгаа явагдаж, төслийн шууд, шууд бус болон далд нөлөөг гаргаж, анх удаа төслөөс гадна түүнтэй хамааралтай Монгол Улсад ажиллаж байгаа 154 ханган нийлүүлэгчдийн ажиллагсдаас онлайн хэлбэрээр судалгаа хийгдсэнээр урьд өмнө гарч байгаагүй төсөлтэй холбоотой нийгэм эдийн засгийн хөгжлийн үйл явц, нөлөөллийн дур зургийг тодорхой болгосон. ОТ ханган нийлүүлэгчдийг салбараар, хамтран ажилласан жилээр, хамтын ажиллагаанд гарсан өөрчлөлт гэх зэргээр дэлгэрэнгүй шинжилснээс гадна ажиллагсдын ажилласан жил, туршлага, аж ахуй эрхлэлтийн байдал, тэдгээрийн өөрчлөлт, мэргэжлийн хувьд ур чадвар өөрчлөгдсөнийг дэлгэрэнгүй судалснаар тус судалгаа онцгой ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

2011-2020 оны хооронд Монгол Улсын ДНБ-д уул уурхайн салбар дунджаар 21.7 хувийг эзэлсэн. Энэ хугацаанд Монгол Улсын нийт ГШХО-д уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 73.4 хувийг эзэлж байсан. Монгол Улсын ГШХО-ын өсөлтийн хурд саарсан нь дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас ГШХО-ын орох урсгал саарсантай давхцаж, уул уурхайн салбарын ГШХО 22.2 хувиар буурсан нь нийт ГШХО-ыг 18.5 хувиар буурахад нөлөөлсөн.

ОТ компани нь 2012-2020 оны хооронд улсын төсөвт 8.5 их наяд төгрөгийн татвар төлж, жил бүрийн төсвийн татварын орлогын 7.25-13.51 хувийг бүрдүүлж, улиралд дунджаар 188.26 тэрбум төгрөгийн татвар, төлбөр хураамжийг төлж байсан. ОТ компанийн төлсөн төлбөр хураамжийн хэмжээ 1 хувиар нэмэгдэхэд Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого дунджаар 0.81 хувиар нэмэгдэж байна. ОТ компани 2020 онд улсын төсвийн орлогын 9.72 хувийг бүрдүүлжээ. Цар тахлын өмнөх жилийнхээс ОТ компанийн улсын төсвийн татварын орлогод эзлэх хувь нь 0.95 пунктээр илүү болж, мөн Өмнөговь аймагт төлсөн нийт татвар, төлбөрийн хэмжээ Ковид-19 цар тахлын үед 2020 оныг 2019 онтой харьцуулахад 2.32 хувиар нэмэгдсэн. ОТ компанийн аймгийн төсөвт оруулсан татвар хураамжийн дүн жил болгон нэмэгдэж, эзлэх хувийн жин 2018, 2019, 2020 онд харгалзан 31 хувь, 43 хувь, 47 хувь болжээ. Энэ хэвээр үргэлжилбэл 2021 онд аймгийн төсвийн 50 хувийг ОТ дангаар бүрдүүлэх түвшинд хүрэхээр байна.

Монгол Улсын нийт экспортод ОТ-н экспорт 4 жилийн дунджаар авч үзэхэд 15.4 хувь байгаа бөгөөд 2018 оны 4 дүгээр улиралд хамгийн өндөр түвшинд буюу 20.4 хувьд, 2019 оны 3 дугаар улиралд хамгийн бага түвшинд буюу 10.4 хувьд тус тус хүрч, ОТ-н экспорт 1 нэгж хувиар өөрчлөгдөхөд Монгол Улсын экспорт дунджаар 0.47 нэгж хувиар өөрчлөгдөж байна.

Монгол Улсын зэсийн салбарт АМНАТ-ыг жишиг үнээр тооцсон борлуулалтын үнийн дүнгийн 5 хувиар ноогдуулж байгаа нь бусад хөгжиж буй орнуудын зэсийн салбарт ноогдуулж буй татварын хувьтай ижил түвшинд байгаа тул "өрсөлдөх хийгээд арилжааны үндсэн дээр харилцан ойлголцох түвшинд байна" гэж үзэж болно. 2019 онд Монгол Улсын зэсийн АМНАТ-ын орлого 22.4 хувиар өссөн бөгөөд энд зэсийн үнэ 25.7 хувиар өсөх, харин зэсийн борлуулалт 3.3 хувиар буурах нөлөө үзүүлсэн. Ковид-19 цар

тахлын үед ОТ компанийн эзсийн борлуулалтад өөрчлөлт ороогүй, 2019 онтой харьцуулахад эзсийн борлуулалт нь 10.6 хувиар өссөн. Борлуулалтын өсөлтөнд эзсийн үнэ 9.2 хувь, харин тоо хэмжээ нь 1.3 хувийн өсөх нөлөө үзүүлжээ. Борлуулалтад эзсийн үнийн үзүүлэх нөлөө өндөр байна.

Монгол Улсын уул уурхайн салбар нь 2020 оны 4-р улирлын байдлаар нийт ажиллагсдын 3.9 хувийг бүрдүүлж байна. Мөн үеийг авч үзвэл, Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй ажиллагсдын дундаж цалин 1328.1 мянга, Улаанбаатар хотын дундаж цалин 1423.2 мянга, Өмнөговь аймгийн 1395.0 мянган төгрөг байна. 2020 оны 12 дугаар сарын байдлаар ОТ компанид 12,364 ажилтан ажиллаж байна. Энд Өмнөговь аймгаас 2,852 иргэн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 26.8 хувийг бүрдүүлж байна. ОТ хөдөлмөр эрхлэлтэд Ковид-19 цар тахлын үзүүлэх нөлөөг илрүүлэх түүвэр судалгаанд үндсэн болон гэрээт компанийн 1720 оролцсон. Судалгаагаар нийт ажиллагсдын 86.2 хувь нь мэргэжилтэй, чадварлаг ажиллагсад байна. Газарзүйн байршлаар авч үзвэл, ажиллагсдын 73.3 хувь нь Улаанбаатар хот, 12.1 хувь нь Өмнөговь аймаг, 5.8 хувь нь Дархан-Уул аймаг, 4.1 хувь нь Орхон аймаг, үлдсэн нь бусад аймгийн харьяалалтай. Нийт ажиллагсдын 52.9 хувь нь дангаараа хөдөлмөр эрхэлж өрхөө ганцаараа тэжээж байна. Эдгээр ажиллагсад дунджаар өөрөөсөө гадна 3 хүнийг цалингийн орлогоороо тэжээж байна. ОТ-н нийт ажиллагсдын 73.9 хувь нь улсын дунджаас дээш буюу 1.5 сая төгрөгөөс дээш цалин авч байна. ОТ-д ажиллаж буй ажиллагсдын өрхийн орлого 2019 онтой харьцуулахад 2020 онд өссөн. Мөн байгууллагын зүгээс ажиллагсдын урамшуулал, дэмжлэг үзүүлсэн нь өрхийн орлого тогтвортой байхад нөлөөлсөн. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ОТ-д ажиллагсдын өрхийн бусад гишүүдийн 60.8 хувийн ажлын цаг багасаж, 25.3 хувийн цалин буурснаар өрхийн амьжиргааны түвшин буурсан. ОТ компанийн удирдах ажилтанд дээд удирдлага, гүйцэтгэх түвшний ажил, менежер, ахлахуудыг оруулан тооцвол Монгол ажиллагсдын эзлэх хувь 2013 онтой харьцуулахад 72.4-81 хувь болж өссөн. Инженер-техникийн ажилтанд мэргэжилтэн болон техникийн ажилтныг хамруулан авч үзвэл өнгөрсөн 7 жилийн хугацаанд 91.8-94.3 хувь болж өсжээ. ОТ-д ажиллаж буй 25-34 насны залуучуудын эзлэх хувийн жин уул уурхайн дундажтай харьцуулахад өндөр байна.

ОТ хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсаны дагуу боловсролын салбарт үе шаттай төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 120 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, уул уурхайн салбарын 1 сургууль, 4 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, 15649 хүн төслийн үр шимийг хүртэж, мэргэжил ур чадвараа сайжруулсан.

2020 оны байдлаар ОТ компанитай 770 гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллага хамтран ажиллаж байна. Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн судалгаанд 154 ханган нийлүүлэгч оролцсон. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ОТ ханган нийлүүлэгчдийн ажиллах горим, цагийн хуваарьт өөрчлөлт орсон боловч ханган нийлүүлэгчдийн 42.9 хувь нь ажлын байраа нэмэгдүүлсэн, 28.6 хувь нь ажлын байраа тогтвортой хадгалж чадсан. Ханган нийлүүлэгчдийн хувьд ОТ-той хамтран ажилласнаар 92.9 хувь нь ажиллагсдын ур чадвар ахисан гэж үзсэн бөгөөд 2020 онд ханган нийлүүлэгчдийн ажиллагсдын 77.3 хувь нь мэргэжлийн сургалт, 67.5 хувь нь аюулгүй ажиллагааны сургалт, 44.2 хувь нь чанарын стандартын сургалтад хамрагдсан нь дотоодын аж ахуй нэгж байгууллагын ажиллагсдын ур чадвар ахихад нөлөөлж байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд ОТ-гоос 100-500 сая болон 1-10 тэрбум төгрөгийн жилийн орлого олж буй ханган нийлүүлэгчид 60 орчим хувийг эзэлж байна. 100 сая хүртэлх борлуулалтын орлоготой ханган нийлүүлэгчдийн тоо сүүлийн 3 жилд өссөн. 2020 онд ОТ-гоос олох орлого нь буурсан 50 байгууллага байхад 68 байгууллагын орлого нь өмнөх жилийнхээсээ өссөн.

2019 онд ОТ ханган нийлүүлэгчид дунджаар 55.6 сая төгрөгийн НДШ, 2020 онд 41.9 төгрөгийн НДШ төлсөн ч 2020 онд байгууллагуудын төлсөн НДШ буурсан шалтгаан нь Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ буюу байгууллага болон ажиллагсдаас авах шимтгэлийг тус бүр 5 хувь болгон бууруулсантай холбоотой. 2020 онд 47 байгууллагын төлдөг НДШ-ийн хэмжээ өссөн. Харин

НӨАТ-ыг авч үзвэл 75 байгууллагын (49 хувь) 2020 онд төлсөн хэмжээ нэмэгджээ. ААНБ-ын орлогын албан татварын хувьд 66 ханган нийлүүлэгч байгууллагын төлсөн хэмжээ абсолют утгаараа өсжээ.

ОТ-н шууд, шууд бус болон дам нөлөөллөөр улсын төсөвт 2019 онд нийт 657.5 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлжээ. Харин цар тахалтай байсан 2020 оны хувьд ОТ компани болон ханган нийлүүлэгчид нийт 626.5 тэрбум төгрөгийн татвар төлжээ. ОТ-н манай улсын нийт эдийн засагт оруулж буй үржүүлэгчийн нөлөө нь 2019 онд 1.43 байсан бол 2020 онд үржүүлэгчийн нөлөө нь 1.39 болжээ. Харин ОТ-той хамтран ажилладаг ЖДҮ-ийн хувьд тооцсон үржүүлэгчийн нөлөө нь 2019 онд 1.292 байсан ба 2020 онд бага зэрэг бууран 1.288 болжээ.

Уул уурхайн болон түүний бүрэлдэхүүн хэсэг болох зэсийн салбар Монголын эдийн засагт маш чухал үүргийг гүйцэтгэж, уул уурхайн салбар үндэсний эдийн засагт оруулж байгаа хувь нэмрээр Монгол Улс дэлхийд 3-рт орж, Узбекистан (16), Казахстан (17), Гүрж (22), ОХУ (23) зэрэг орнуудаас уул уурхайн салбар нь илүү өндөр хувь нэмэртэй байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын судалгаагаар нийт хөдөлмөр эрхлэлтэд уул уурхайн салбарын ажлын байр бүтээж байгаа хувиар Монгол улс дэлхийд 2-рт эрэмбэлэгдсэн.

Дэлхийн зэсийн эрэлт хэрэгцээ нь цаашид сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон хайбрид машин, хотжуулалт, цахилгаанжуулалт, эрүүл мэндийн салбарын өсөлттэй уялдан тасралтгүй өсөх хандлагатай бөгөөд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр зэсийн шинэ эрин үе эхэлж байна гэж судлаачид үзжээ. Монгол Улсын хувьд цаашид Оюу Толгойн гүний уурхай, Цагаан Суварга болон хайгуулын шатанд байгаа бусад төслүүдийг авч үзэхэд, манай улсын зэсийн салбар дэлхийн чухал нийлүүлэгч болох боломж бүрдэж байна.

Цаашид уул уурхайн салбар манай улсад илүү эрчимтэй хөгжих нөөц, бололцоо их байгаа тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байруудыг өсгөхөд тус салбарын хувь нэмэр, ач холбогдол улам өсөх нь тодорхой байна.

ТАЛАРХАЛ

МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судлаачид бид ОТ компанийн статистик баримт, тоо мэдээлэл, холбогдох өгөгдөлд үндэслэн Монгол Улсад хэрэгжиж буй мега төслийн хөгжилд үзүүлж буй үр өгөөжийг гурван жилийн давтамжтайгаар шинжлэн олон нийтэд хүргэж байгаадаа баяртай байна. Өмнөх судалгаагаар Монгол Улсын хөгжилд үзүүлсэн нөлөөг үнэлсэн бол энэ удаагийн судалгаагаар Ковид-19 цар тахлын үед ОТ-н үзүүлсэн үр нөлөөг авч үзлээ. Эдийн засаг, нийгмийн асуудлын хувьсал, өөрчлөлт хурдацтай явагдаж байгаа үед динамик орчныг танин мэдэх нь хөгжлийн олон хэмжээст асуудлыг бодитой, тодорхой, нээлттэйгээр харуулахад тустай.

Монгол Улс хөгжлийнхөө шинэ мөчлөгт өнгөрсөн хагас жарныхаа түүхэн шинэ боломж, шинэ сорилтоо үнэлэн харж, Алсын хараагаар үнэт зүйлээ томъёолон Тогтвортой хөгжлийн зорилгоор хандах зүгийг барьж, ОТ-той хамтран эдийн засгийн шинжлэх ухааны хэрэглээний судалгаанд бодит хувь нэмэр оруулж байгаа энэ үед ОТ компанийн удирдлага, хамтран ажилласан нэгжүүдийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

Эрдэм судлалын энэ удаагийн ажлыг гурван үеийн залгамж холбоонд гүйцэтгэж байгааг тэмдэглэхийн сацуу хоёр удаагийн судалгаанд мөр зэрэгцэн ажилласан зөвлөхүүд, судлаачдадаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Бидний судалгааны өдөр тутмын үйл ажиллагаанд эмх цэгц, зохион байгуулалт, үүрэг хариуцлагатай хандан, гүйцэтгэлийг ханган ажилласан Ё.Лхамаадаа маш их баярлалаа.

Энэхүү судалгаанд хамтран ажилласан ВМЛ Уай энд Ар Монголиа компанийн хамт олон болон Б.Байгалмаад маш их баярлалаа.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмал, нөөц ашигласны татвар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
МБС	Мэргэжлийн боловсролын сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОАТ	Орлогын албан татвар
ОТ	Оюу Толгой
ОТ компани	Оюу Толгой ХХК
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТТАМ	Түгээмэл тархалттай ашигт малтмал
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Эрдэнэт УБУ	Эрдэнэт Уулын баяжуулах үйлдвэр
CAGR	Compound Annual Growth Rate
ICMM	International Council on Mining and Metals
LQ	Local Quotient
ILO	International Labor Organization
ISCG	iShares Morningstar Small-Cap Growth
OFHC	Oxygen-free high conductivity copper

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1.	Зэсийн эцсийн хэрэглээ, 2019 он	13
Зураг 1.2.	Зэсийн өсөлтийн макро тренд	17
Зураг 1.3.	Уул уурхайн салбар хөгжиж буй орнуудын эдийн засагт оруулдаг хувь нэмрийн харьцуулалт	20
Зураг 2.1.	ГШХО-д Уул уурхайн салбарын ГШХО-ын эзлэх хувь	24
Зураг 2.2.	ГШХО болон уул уурхайн салбарын ГШХО-ын өсөлт	25
Зураг 2.3.	Бодит ДНБ, бодит уул уурхайн салбар, ГШХО-ын өсөлтийн динамик	25
Зураг 2.4.	ДНБ ба Оюу Толгойн Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн динамик /тэрбум.₮/	27
Зураг 2.5.	Монгол Улсын ДНБ-д Оюу Толгойн төлсөн нийт төлбөрийн эзлэх хувь	27
Зураг 2.6.	ДНБ ба Оюу Толгойн Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн өөрчлөлт, улирлаар /хувиар/	28
Зураг 2.7.	Төсвийн орлого ба ОТ-н Монгол Улсад төлсөн нийт төлбөр /сая.₮/	29
Зураг 2.8.	Нэгдсэн төсвийн орлогод эзлэх ОТ-н Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн эзлэх хувь	30
Зураг 2.9.	Төсвийн орлогын өөрчлөлтийн хувь ба ОТ-н Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн өөрчлөлтийн хувь /улирлаар/	30
Зураг 2.10.	Монгол Улсын экспортын дүн ба Оюу Толгойн экспорт /сая ам.доллар/	32
Зураг 2.11.	Монгол Улсын нийт экспортод эзлэх Оюу Толгойн экспортын эзлэх хувь	32
Зураг 2.12.	Монгол Улсын нийт экспортын өөрчлөлт ба ОТ-н экспортын өөрчлөлт /улирлаар/	33
Зураг 3.1.	Улсын төсвийн татварын орлого болон ОТ компанийн төлсөн татвар, 2010-2020	36
Зураг 3.2.	АМНАТ, зэсийн үнэ, борлуулсан тоо хэмжээ, нийт дүнгээр, ХҮИ-ээр засварласан, 2015=100	37
Зураг 3.3.	ОТ компанийн төлсөн АМНАТ, зэсийн үнэ, борлуулсан тоо хэмжээ, нийт дүнгээр, ХҮИ-ээр засварласан, 2015=100	37
Зураг 3.4.	0-1 ОТ ба Эрдэнэтийн Ковид-19 цар тахлын үед (2020) төлсөн АМНАТ-ын өсөлтийн хувь, сараар	38
Зураг 3.5.	ОТ-н төлсөн НДШ ба Монгол Улсын ДНБ	38
Зураг 3.6.	ОТ компанийн төлсөн НДШ ба Улсын НДШ-ийн орлого	39
Зураг 3.7.	ОТ-н Өмнөговь аймагт төлсөн татвар, төлбөр	39
Зураг 3.8.	ОТ компанийн Өмнөговь аймагт төлсөн гол гол татвар, төлбөр (мян.төг) 2011-2020	40
Зураг 3.9.	Ковид-19 цар тахлын үед ОТ компанийн Өмнөговь аймагт төлсөн татвар, төлбөр 2019-2020	41
Зураг 3.10.	Өмнөговь аймаг болон Ханбогд сумын гол нэр төрлийн татварын хуримтлагдсан нөлөө, төлбөр (мян.төг) 2010-2020	41
Зураг 3.11.	ОТ компанийн Ханбогд суманд төлсөн татвар, төлбөр, төрлөөр (мян.төг)	42
Зураг 3.12.	Өмнөговь аймгийн Ханбогд болон Булган сумын татварын бүтэц, өөрчлөлт, 2010-2020	42
Зураг 4.1.	ОТ болон уул уурхайн салбарын ажиллагсад, насны бүлгээр	48
Зураг 4.2.	Ажиллагсад, боловсролын түвшингээр	49
Зураг 4.3.	Нийт болон ОТ-д ажилласан дундаж жил, цалингийн түвшингээр	49
Зураг 4.4.	Цалингийн өөрчлөлт, цалингийн интервалаар	50
Зураг 4.5.	Сургалтад хамрагдсан байдал, хувиар	50
Зураг 4.6.	2020 онд сургалтад хамрагдсан байдал, сургалтын төрлөөр	51
Зураг 4.7.	Өрхийн орлогын өөрчлөлт, хувиар	51
Зураг 4.8.	Өрхийн нэг жилд хийдэг хадгаламжийн хэмжээний өөрчлөлт, 2020/2019	52
Зураг 4.9.	Хадгаламж буурсан ажиллагсдын цалингийн орлогын өөрчлөлт, хувиар	52
Зураг 4.10.	Хадгаламж буурсан ажиллагсдын өрхийн бусад гишүүдийн орлогын өөрчлөлт, хувиар	52
Зураг 4.11.	Ковид-19 цар тахлын үе дэх цалингийн орлогын өөрчлөлт, 2020-2019	53

Зураг 4.12.	Цалингийн өөрчлөлтийн шалтгаан	53
Зураг 4.13.	Зөвхөн Ковид-19 цар тахлын нөлөөгөөр өрхийн бусад гишүүдийн орлогын өөрчлөлт, 2020/2019, хувиар.	53
Зураг 4.14.	Өрхийн бусад гишүүдийн орлого буурсан шалтгаан, хувиар	53
Зураг 4.15.	Орлого буурсан шалтгаан, өрхийн гишүүд болон ОТ-н ажиллагсдаар	54
Зураг 4.16.	Өрхийн худалдан авалтын өөрчлөлт, 2020/2019, хувиар.	54
Зураг 4.17.	Оюу Толгойн ажиллагсад	55
Зураг 4.18.	ОТ компанид Монгол ажиллагсдын эзлэх хувь, сараар	56
Зураг 4.19.	Монгол Улсын нийт ажиллагсад болон ОТ компанийн ажиллагсад, улирлаар.	56
Зураг 4.20.	Гэрээт компанийн ажиллагсад болон Монгол ажиллагсдын эзлэх хувь, сараар	57
Зураг 4.21.	Монгол Улсын нийт ажиллагсад болон ОТ-н гэрээт компанийн ажиллагсад, улирлаар.	57
Зураг 4.22.	Монгол ажиллагсдын эзлэх хувь, албан тушаалаар.	58
Зураг 4.23.	Аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан ажиллагсдын тоо.	62
Зураг 4.24.	Аюулгүй ажиллагааны сургалтын зардал, мянган ам.доллороор	62
Зураг 4.25.	Ил болон гүний уурхайн сургалтад хамрагдсан ажилтны тоо	62
Зураг 4.26.	Ил болон гүний уурхайн сургалтын зардал, мянган ам.доллар	63
Зураг 4.27.	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажиллагсдын тоо.	63
Зураг 4.28.	Монгол Улсын хүний хөгжлийн индекс, 1990-2019	64
Зураг 5.1.	Өмнөговь аймгийн ДНБ, сая төгрөг	71
Зураг 5.2.	Өмнөговь аймгийн ДНБ, ОТ нөлөөтэй, нөлөөгүй үеийн харьцуулалт	72
Зураг 5.3.	Өмнөговь аймгийн Төвийн бүсийн ДНБ-д эзлэх хувь	74
Зураг 5.4.	Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох ДНБ (мянган төгрөг).	75
Зураг 5.5.	Өмнөговь аймаг болон Монгол Улсын нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ, 2011-2019	76
Зураг 5.6.	Өмнөговь аймгийн ДНБ-ийг бүрдүүлэгч эдийн салбарын бүтэц, 2011-2019	77
Зураг 5.7.	Өмнөговь аймгийн ДНБ-ийг бүрдүүлэгч эдийн засгийн салбаруудын динамик өөрчлөлт, 2015-2019	78
Зураг 5.8.	Өмнөговь аймгийн эдийн засгийн салбаруудад ажиллаж буй ажиллагсдын жилийн нийлмэл өсөлтийн хувь, 2009-2019	79
Зураг 5.9.	Өмнөговь аймгийн эдийн засгийн төрөлжилт, кластерын шинжилгээ, 2000-2019	79
Зураг 6.1.	Ханган нийлүүлэгчдийн байгуулагдсан он	82
Зураг 6.2.	Ханган нийлүүлэгчдийн байгуулагдсан он, хамтран ажиллаж буй жил	82
Зураг 6.3.	Ханган нийлүүлэгчдийн татварын бүртгэлтэй газар /хувиар/.	83
Зураг 6.4.	Ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагааны төрөл /давхардсан тоон утгаар/.	84
Зураг 6.5.	Үйл ажиллагааны хүрээний төрөл	84
Зураг 6.6.	Бүтээгдэхүүний борлуулалтаа нэмэгдүүлэхээр өөр бусад компанитай холбоотой ажиллаж буй байдал /хувиар/	85
Зураг 6.7.	Сүүлийн 1 жилийн хугацаанд өөрийн салбарын бусад компанитай холбоотой ажилласан байдал /хувиар/	86
Зураг 6.8.	ОТ-гоос олсон борлуулалтын орлого, төгрөгөөр, хувиар /2018-2020/	87
Зураг 6.9.	Сүүлийн 2 жилийн хугацаанд хамгийн их өсөлттэй байсан зардлын төрөл /давхардсан тоон утгаар/	87
Зураг 6.10.	Ажиллагсдын тоо	88
Зураг 6.11.	ОТ ханган нийлүүлэгчдийн сарын дундаж цалингийн хэмжээ /төгрөгөөр/.	89
Зураг 6.12.	Цалингийн тархалт 2019, төгрөгөөр	89
Зураг 6.13.	Цалингийн тархалт 2020, төгрөгөөр	89
Зураг 6.14.	Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ОТ худалдан авалтад гарсан өөрчлөлт, хувиар	90
Зураг 6.15.	Ковид-19 цар тахлын үед бизнест хамгийн их нөлөө үзүүлсэн хүчин зүйлс /давхардсан утгаар/	91
Зураг 6.16.	Ковид-19 цар тахлын үед хамгийн их нэмэгдсэн зардлын төрөл /хувиар/.	91

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1.	Зэсийн том уурхайнууд 2018	18
Хүснэгт 1.2.	Монгол Улсын зэсийн шинэ төслүүд	19
Хүснэгт 1.3.	Уул уурхайн салбарын үндэсний эдийн засагт оруулдаг хувь нэмрийн олон улсын индекс, эхний 23 улсын жагсаалт	20
Хүснэгт 1.4.	Нийт хөдөлмөр эрхлэлтэд уул уурхайн хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувийн харьцуулалт, 2014	21
Хүснэгт 2.1.	ДНБ ба Оюу Толгойн Монгол Улсад төлсөн нийт төлбөр /сая.₮/	26
Хүснэгт 2.2.	Оюу Толгойн нийт төлбөр болон Монгол Улсын ДНБ-ий ерөнхий статистик (тэрбум₮)	26
Хүснэгт 2.3.	Төсвийн орлого ба ОТ-н Монгол Улсад төлсөн нийт төлбөр /сая.₮/	28
Хүснэгт 2.4.	Оюу Толгойн нийт төлбөр болон улсын нэгдсэн төсвийн ерөнхий статистик	29
Хүснэгт 2.5.	Монгол Улсын экспортын хэмжээ ба Оюу Толгойн экспортын хэмжээ /сая ам.доллар/	31
Хүснэгт 2.6.	Оюу Толгойн экспорт болон Монгол Улсын нийт экспортын ерөнхий статистик	31
Хүснэгт 4.1.	Өмнөх болон одоогийн сарын цалингийн өөрчлөлт, цалингийн интервалаар	50
Хүснэгт 4.2.	Өрхийн орлогын өөрчлөлт, орлогын интервалаар	52
Хүснэгт 4.3.	Мэргэжлийн боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалт	59
Хүснэгт 4.4.	Оюутан залууст зориулсан тэтгэлэгт хөтөлбөр	61
Хүснэгт 4.5.	Хүний хөгжлийн индексийн өөрчлөлтийн хувь, сонгосон улсаар	65
Хүснэгт 4.6.	Уул уурхайн компаниудын ажиллагсдын эрсдэлийн зураглал	66
Хүснэгт 5.1.	Өмнөговь аймгийн ДНБ-ий салбарын бүтэц, хувиар	70
Хүснэгт 5.2.	Өмнөговь аймгийн төсвийн орлогод ОТ компанийн оруулсан хувь нэмэр, сая төгрөг	72
Хүснэгт 5.3.	Оюу Толгойтой болон Оюу Толгойгүй үеийн эдийн засгийн өсөлт	73
Хүснэгт 5.4.	Төвийн бүсийн аймгуудын бүсийн ДНБ-д эзлэх хувь	74
Хүснэгт 5.5.	Төвийн бүсийн нэг хүнд ногдох ДНБ (мянган төгрөг)	75
Хүснэгт 5.6.	Өмнөговь аймгийн эдийн засгийн үйл ажиллагаа, 2019	80
Хүснэгт 6.1.	Ханган нийлүүлдэг бүтээгдэхүүн үйлчилгээ болон хамтран ажиллаж буй хугацаа	83
Хүснэгт 6.2.	Ханган нийлүүлэгчдийн хариуцлага болон хөрөнгө оруулалтын хэлбэр	84
Хүснэгт 6.3.	Ханган нийлүүлэгчдийн ОТ-гоос олсон борлуулалтын орлого	86
Хүснэгт 6.4.	Байгууллагын үйл ажиллагааны төрөл, ОТ-д нийлүүлдэг бараа үйлчилгээ, ажиллагсдын тоо	88
Хүснэгт 6.5.	Ханган нийлүүлэгчдийн ажиллагсдын цалингийн талаарх мэдээлэл /төгрөгөөр/	89
Хүснэгт 6.6.	Гэрээнд өөрчлөлт орсон шалтгаан /тоогоор/	91
Хүснэгт 6.7.	Улсын төсөвт төвлөрүүлж буй татвар, хураамж, сая төгрөгөөр	93
Хүснэгт 6.8.	Орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй татвар, хураамж, сая төгрөгөөр	93
Хүснэгт 6.9.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оруулсан төлбөр, хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр	94


Хүснэгт 6.10. Төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн дүн	94
Хүснэгт 6.11. ОТ компанийн шууд нөлөө	94
Хүснэгт 6.12. Ханган нийлүүлэгчдийн борлуулалтын орлого, сая төгрөгөөр, 2019	95
Хүснэгт 6.13. Ханган нийлүүлэгчдийн төлсөн татвар, шимтгэл, сая төгрөгөөр	95
Хүснэгт 6.14. Ханган нийлүүлэгчдийн цалингийн зардал, сая төгрөгөөр	96
Хүснэгт 6.15. ОТ компанийн шууд бус нөлөө	96
Хүснэгт 6.16. Ханган нийлүүлэгчдийн төлсөн НӨАТ, сая төгрөгөөр	96
Хүснэгт 6.17. Зөвхөн ОТ-д бүтээгдэхүүн үйлчилгээгээ нийлүүлдэг ханган нийлүүлэгчдийн төлсөн цалингийн зардал, сая төгрөгөөр	96
Хүснэгт 6.18. ОТ компанийн дам нөлөө	97
Хүснэгт 6.19. Эдийн засагт үзүүлэх нийт нөлөө	97
Хүснэгт 6.20. Монголын эдийн засагт ОТ-н үржүүлэгчийн нөлөө	97
Хүснэгт 6.21. Эдийн засагт үзүүлэх нийт нөлөө	98
Хүснэгт 6.22. ОТ-н үржүүлэгчийн нөлөө	98

I. ЗЭС, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

1.1. ЗЭСИЙН ДЭЛХИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЛЭЭ

Зэс нь хүний хэрэгцээний салшгүй чухал хэсэг болсон. Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн салбарт гарсаар буй шинэ нээлт, бүтээл бүрийн ард зэсийн хэрэглээ¹ эрс өсөж иржээ. Дэлхий даяар эрчим хүч, цахилгаан бараа, барилгын салбар, аж үйлдвэрийн машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, өргөн хэрэглээний болон бусад ахуйн хэрэглээний салбаруудад эрэлт хэрэгцээ сүүлийн 50 жилд дунджаар 3 дахин өсжээ². Олон улсын зэс судлалын группийн судалгаанаас үзэхэд тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн салбар хамгийн том эцсийн хэрэглэгч салбар бөгөөд дараа нь барилга ба дэд бүтцийн салбарууд зэсийг их хэрэглэдэг [ISCG, 2020].

Зураг 1.1. Зэсийн эцсийн хэрэглээ, 2019 он



Эх сурвалж: Олон улсын зэс судлалын байгууллагын тайлан, 2020

Эрэлтийн төрлийг нарийвчлан авч үзэхэд, зэсийг дараах бүтээгдэхүүнд өргөнөөр хэрэглэдэг:

- Цахилгаан машин
- Цахилгааны машинд зориулсан цахилгааны эх үүсвэр цэнэглэгч станцуудын төхөөрөмж
- Цахилгаан зай (Алкалин)
- Дотоод шаталтын моторын шинэ материалууд copper brass alloy'
- Oxygen-free high conductivity copper (OFHC) шинэ төрлийн эрчим хүч (nuclear fusion)-д зориулсан чухал материал
- Нарны зайны PV холбогч (алдагдал багатай бөгөөд нарны зайн хүчин чадлыг максимумчлах чадвартай)

1 7401 – Copper mattes; cement copper (precipitated copper)
 7402 – Unrefined copper; copper anodes for electrolytic refining
 7403 – Refined copper and copper alloys, unwrought
 7404 – Copper waste and scrap
 7405 – Master alloys of copper
 7406 – Copper powders and flakes
 7407 – Copper bars, rods and profiles
 7408 – Copper wire
 7409 – Copper plates, sheets and strip, of a thickness exceeding 0,15 mm
 7410 – Copper foil (whether or not printed or backed with paper, paperboard, plastics or similar backing materials) of a thickness (excluding any backing) not exceeding 0,15 mm
 7411 – Copper tubes and pipes
 7412 – Copper tube or pipe fittings (for example, couplings, elbows, sleeves)
 7413 – Stranded wire, cables, plaited bands and the like, of copper, not electrically insulated

2 Ч.Отгочулуу, 2020, диссертаци

- Цахилгаан галт тэрэгний кабель
- Агааржуулагчийн доторхи суваг (хоолой) нь илүү өр өгөөжтэй, байгальд ээлтэй
- Электрон барааны мейнбоардын холбогч замууд (copper pillar technology)
- Ковидын үеийн бактери нянгийн эсрэг гадаргуу
- Хүнсний салбарт хэрэглээ Copper-alloy mesh
- Ногоон барилга (зай), эрчим хүчний хэмнэлт
- Хүний биед зэсийн агууламж эрүүл мэндэд маш чухал
- Зэс нийтийн барилгад эрүүл мэндэд маш чухал - нян устгах чадвартай.

Олон улсын зэс судлалаар дагнасан байгууллагуудын судалгаанаас үзэхэд³ дэлхий нийтийн зэсийн хэрэглээ⁴ 2019 онд 24.4 сая тоннд хүрчээ. Сүүлийн жилүүдэд зэсийн хэрэглээ Ази тив рүү шилжиж байна, тухайлбал, 2019 оны байдлаар зэсийн нийт эрэлтийн 70 хувь нь Азид төвлөрчээ гэдгийг судлаачид тэмдэглэсэн байгаа. Энэхүү өсөлт нь хотжилт, эрчим хүчний салбарын хөгжил, цахилгаанжуулалттай салшгүй холбоотой юм.

Хэрэглээг авч үзвэл, зэсийн хэрэглээ их салбаруудыг онцгойлон, эцсийн хэрэглээгээр нь хэд хэдэн гол салбарт хувааж авч үзэж болно:

- Барилга угсралт–түүний дотор: усны хоолой сүлжээ, үйлдвэрийн барилга, архитектур, харилцаа холбоо, цахилгаан эрчим хүч,
- Дэд бүтэц – үүний дотор: цахилгаан, харилцаа холбоо
- Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл – үүнд: аж үйлдвэр, цахилгаан машин болон цахилгаан бус машин; тээвэр (цахилгаан автомашин; цахилгаан бус хөдөлгүүртэй автомашин; бусад тоноглол);
- Бусад төрлийн эд хэрэгсэл, тоноглол (өргөн хэрэглээний бараа; агааржуулалтын төхөөрөмж; электроник бараа).

Дээрх салбараар авч үзэхэд, эрчим хүчний салбарт зэсийг нилээд их хэмжээгээр, бас өргөнөөр ашигладаг. Бусад металлтай харьцуулахад цахилгааныг маш бага эсэргүүцэлтэйгээр дамжуулдаг онцлогтой тул өндөр, дунд, нам гэсэн хүчдэл бүхий гүйдлийг дамжуулах зорилгоор зэс кабелийг үйлдвэрлэдэг. Эрчим хүчний үр ашиг өндөртэй цахилгаан үүсгүүр, мотор, дамжуулагч болон сэргээгдэх эрчим хүчний аливаа тоног төхөөрөмжийн хувьд зэс нь орлуулашгүй чухал орц юм. Нар, салхи, газрын гүний дулаан болон бусад дэвшилтэт технологийн хувьд ч зэс нь өөрийн дамжуулах чадварын нөлөөгөөр хамгийн чухал түүхий эд нь болж өгдөг. Мөн зэс компьютер, харилцаа холбооны салбарын маш чухал бүтээгдэхүүн байгааг дурдсан байгаа.

Уламжлалт аж үйлдвэр, дэд бүтцэд зэс чухал материалын орц болдог. Тухайлбал, барилга, орон сууцны цэвэр ус дамжуулах суваг, хоолойг зэсээр хийж болдог. Хуванцар хоолойтой харьцуулахад зэс хоолойд давуу тал нь нянгийн эсрэг үйлчилгээтэй, хортой нэгдлийг ялгаруулдаггүй. Байгалийн гамшиг, гал түймрийн үед зэс хоолой нь галд тэсвэртэй учир гал унтраах системийн найдвартай ажиллагааг эрс өсгөдөг.

3 World Copper Factbook 2020, International Copper Study Group

4 Цэвэршүүлсэн зэсийн бүтээгдэхүүн

Зэсийн утас Copper wire – subdivided into eight categories: building wire; power cable; magnet wire; telecom cable (external); other communication cable (electronic / data / internal telecom); other LV energy cable (equipment wire, flexibles, etc.); automotive wire & cable; bare conductor

Зэсийн труба

Зэсийн хавтан Copper flat rolled products

Зэсийн нарийн хавтан

Зэсийн хольцтой бүтээгдэхүүн

16 end-use categories:

Building Construction – with five sub-divisions: Plumbing, Building plant, Architecture, Communications and Electrical power

Infrastructure – with two sub-divisions: Power utility and Telecommunications

Equipment manufacture – with four sub-divisions: Industrial (with two sub-divisions: Electrical and Non-electrical); Transport (with three sub-divisions:

Automotive electrical; Automotive Non-electrical; Other transport); Other equipment (with four sub-divisions: Consumer & general products; Cooling;

Electronic; Diverse)

Аж үйлдвэрийн машин механизм ба тоног хэрэгсэл үйлдвэрлэлийн салбарт ч улаан металлын эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байна. Хүнд даацын, том оврын машин механизмуудад араа, бэхэлгээ, турбины хавхлаг зэрэгт зэсийг их ашигладаг нь зэсийн насжилт, техникийн тэсвэржилт, маш нарийн хэмжээс бүхий хэлбэр дүрс олох байдал, анхны хэлбэрээ хадгалах чадвар сайн байдаг зэрэгтэй холбоотой. Ялангуяа өндөр халуун орчинд даралт тэсвэрлэх чанарыг нь ашиглаж тоормос ба моторын найдвартай байдлыг нэмэгдүүлдэг.

Зэсийг бараг бүхий л салбарт ашиглаж байгааг илэрхийлэх сонирхолтой өөр нэг жишээ бол фермерийн болон загаасны аж ахуйд тэжээвэр амьтдад өгөх хүнсэнд зэсийг хольдог практик юм. Учир нь эрдэс дутагдсанаас үүсэх тэжээлийн доройтлыг арилгахад зэс маш тохиромжтой байдаг.

Далайн тээврийн салбарт ч тус металлын эрэлт тасралтгүй нэмэгдсээр байх болно. Дэлхийн худалдаанд далайн тээвэр чухал үүрэг гүйцэтгэдэг. Тээвэрлэгч усан хөлгүүдийн ёроолыг зэсээр болон зэс-никелийн хайлшаар бүрддэг. Энэ нь үрэлтийн эрчийг эрс сааруулж, улмаар түлш зарцуулалтыг багасгана.

Суудлын автомашин, ачааны машин зэрэг тээврийн хэрэгслүүдэд зэсийн орц их байдаг. Тухайлбал, мотор, цахилгаан холболт, радиатор, холбогч, тоормос, тулгуур болон бусад хамгаалах эд ангиудыг зэсээр үйлдвэрлэдэг. Харин сүүлийн үед цахилгаан автомашин (Electric vehicles буюу EVs)–ыг үйлдвэрлэхэд жирийн буюу уламжлалт машинтай харьцуулахад 4 дахин их зэс ордог болсон байгаа. Үүнд цэнэг хураагуур буюу батарей, моторын сэнс ба эргүүлэг, цахилгаан холболтууд, цэнэглэх эд анги зэрэгт зэс ашиглах нь хамгийн оновчтой шийдэлд тооцогдож байна.

2019 оны байдлаар дэлхий даяар 3 сая орчим цахилгаан автомашин нийтийн хэрэгцээнд ашиглагдаж байгаа бөгөөд жил ирэх тусам энэ тоо огцом хурдтай өсөхөөр байна. Цахилгаан машины хэрэглээ нэмэгдэхэд гол хязгаарлалт нь цэнэглэгч станцууд байгаа юм. Цаашид цэнэглэгч станцуудын сүлжээ өргөжин тэлэх бөгөөд хурдан цэнэглэгч бүр 8 кг-ын зэсээс бүрдэх болно гэж үздэг.

Зэс зөвхөн цахилгаан цэнэг дамжуулахаас гадна дулааныг маш сайн дамжуулдаг. Мөн дахин боловсруулахад туйлын хялбар учир хүнд даацын ачааны машинуудын радиатор болон хөргүүрийн системийг зэсээр хийх нь элбэгшиж байна. Түлш бага зарцуулдаг нисэх онгоц ба төмөр замын салбарт зүтгүүрүүдийг үйлдвэрлэхэд ч зэсийн орц, найрлага хурдтай нэмэгдэж байна. Жишээ нь, өндөр хурдтай галт тэрэг үйлдвэрлэхэд 2-4 тонн зэс ордог.

1.2. КОВИД-19 ҮЕИЙН ДЭЛХИЙН ЗЭСИЙН ХЭРЭГЛЭЭ, ӨӨРЧЛӨЛТ – ЗЭСИЙН ШИНЭ ЭРИН ҮЕ

Ковид-19 цар тахал нь дэлхийн эдийн засагт, түүний дотор металл хүдрийн зах зээл, зэсийн зах зээлд томоохон нөлөө үзүүлж байна. Зэсийн хувьд коронавирсийн тархалт нь 3 чиглэлээр голдуу нөлөөлсөн гэж үзэж⁵ байна. Дэлхий даяар онлайн харилцаанд шилжиж, ажил, боловсрол зайны сувгуудаар явагддаг болсон нь эхний том нөлөө үзүүлэх хүчин зүйл болж, хоёрдугаарт, дэлхийн даяар явагдаж буй “ногоон” технологийн хөгжил ихээхэн нөлөөлж, гуравдугаарт, зэсийн эрүүл мэндийн салбар дах хэрэглээ, түүний анагаах ухааны талаас авч үзсэн онцлогууд судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байна⁶.

Харилцаа холбооны салбарт Ковид-19 цар тахлын үед дэлхий нийтээрээ үүрэн харилцаа холбооны хамгийн өндөр хурдтай, шинэ стандартын 5G сүлжээнүүдийг АНУ, Европын Холбоо, Япон, БНХАУ зэрэг улсууд эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү цахим хувьсгал нь зэсийн салбарт шууд эерэгээр нөлөөлж байгаа учраас ковидын үеийг “зэсийн шинэ үе” гэж судлаачид нэрлэж байна⁷. Жишээлбэл, БНХАУ-д 5G

5 <https://voxeu.org/article/covid-19-and-new-age-copper>

6 <https://blogs.iadb.org/energia/en/covid-19-precipitated-the-age-of-copper-are-producing-countries-prepared-to-supply-the-world-and-capture-greater-value/>

7 <https://www.cnbc.com/2020/06/24/coronavirus-why-the-pandemic-could-spark-a-copper-rally.html>

сүлжээ байгуулах нь дангаараа 72 мянган тонн зэсийн эрэлтийг үүсгэнэ гэж тооцжээ⁸. Үүнээс гадна 4G хурдны үүрэн холбооны салбар, бусад төрлийн харилцаа холбооны кабель, утасны хэрэглээ, угсралт дэлхий даяар идэвхтэй баригдаж байгаа бөгөөд нь зэсийн утас нь чухал болж байгаа.

Ногоон хөгжлийн хувьд голлох үүргийг цахилгаан автомашины салбарын тасралтгүй өсөлт, сэргээгдэх эрчим хүчний хөгжил гүйцэтгэж байна. Нарны зай, салхины сэнс өмнөх үеийн, уламжлалт цахилгаан үйлдвэрлэлтэй харьцуулахад 12 дахин их хэмжээний зэсийн орцыг шаардаж байгаа⁹. Гленкор компанийн судалгаанд цахилгаан машинууд 4 их хэмжээний зэс ашигладаг гэж тэмдэглэсэн (Glencore 2017).

Эрүүл мэндийн салбарт зэсийн хэрэглээ нь мөн тус металлын нян устгах чадвараас болж өсөх хандлагатай болжээ. Ковид-19 цар тахал гарахаас өмнө эрүүл мэндийн салбарын хөгжил дэлхийд дараагийн 20 жилд хэрэглээ нь 1 сая тонноор өсөх эрэлттэй болно гэж тооцсон байсан бол Ковид-19 цар тахлын үед түүний эрэлт эрс нэмэгдэх болж байна¹⁰.

Ийнхүү нэг талаас зэсийн хэрэглээ нэмэгдэж зэсийн шинэ эрин үе эхлэх гэж байхад, 2020 онд дэлхийн гол үйлдвэрлэгч 5 оронд зэсийн үйлдвэрлэл буурах хандлагатай болсон бөгөөд эдгээр 5 орон дэлхийн зэсийн баяжмалын ¾-ыг гаргадаг¹¹ (Chile, Peru, Indonesia, Australia, Canada). Үүний шалтгаан нь 2012 оноос дэлхийн зэсийн үйлдвэрлэл зогсонги байдалд орж, томоохон шинэ төслүүд ашиглалтад ороход бэлдээгүй байсан бөгөөд КОВИД-ын тархалтаас болж ашиглалтад орох гэж байсан шинэ уурхайнуудыг ажилд оруулах, өргөтгөх явц өөрөө ихээхэн удааширч, зарим уурхай, тухайлбал Чили улсын El Teniente, Chuquibambilla зэрэг хамгийн том уурхайд гүний уурхайн ажлыг бүрмөсөн зогсоож, Quebrada Blanca зэрэг 15 000 ажилчинтай уурхайг 6 сараар хаасан¹². Мөн Перу улсын Quellaveco уурхайн ажил коронавирусууд болж зогсонги байдалд орсон. Ийнхүү, судлаачдын тооцоогоор, Ковид-19 цар тахлын нөлөөнөөс болж 2020 оны эхэнд дэлхийн хамгийн том экспортлогчдын нэг, Перу улсын хувьд, зэсийн олборлолт 23%-иар буурч, ажиллагсдын 75% нь хөл хорионд орсон, шинэ төслүүд зогссон, өргөтгөлийн ажил завсарласан зэргээс болж зэсийн зах зээлд нийлүүлэлтийн дутагдал үүсэж, үнэ өсөж эхэлсэн. Тухайлбал, 2020 онд зэсийн үнэ өндөр түвшинд хүрсэн. 2021 он гараад зэсийн үнэ үргэлжлэн өсөж, Лондонгийн Металлын Зах дээр 1-р сарын эхээр гэхэд сүүлийн 8 жилд хамгийн өндөр түвшин буюу нэг тонн 8238 долларт хүрчээ. Судлаачдын үзэж байгаагаар, зэсийн үнийн өсөлтөд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлт, үйлдвэрлэлийн доголдол болон бусад холбогдох хүчин зүйл голчлон нөлөөлсөн¹³. Харин үнэ өсөхөд хүчтэй нөлөөлсөн нь БНХАУ-ын зах зээлийн сэргэлт юм. БНХАУ эдийн засагт аж үйлдвэр сэргэж, нөгөө талаас хаягдал зэсийн олдоц багассан, мөн зэсийн хаягдлыг боловсруулах процесст БНХАУ засгийн газраас тавьдаг хяналтыг хатуу болгосонтой холбоотой байна гэж үзжээ.

8 Mills, R (2020), "5G And Metals", 2020

9 Copper Development Association, 2020

10 Morrison, (2019), "Global copper market under supplied, demand on the rise – report".
Morrison, J (2020), "Copper's Virus-Killing Powers Were Known Even to the Ancients", Smithsonian.

11 COVID-19 and the new age of copper: Opportunities for Latin America, Karina Fernandez-Stark, Penny Bamber, Martin Walter, 07 October 2020.

12 Reuters 2020b, Fundacion Terram 2020, Jamasmie 2020

13 Are higher copper prices here to stay? Fastmarkets analysis, 2021

Зураг 1.2. Зэсийн өсөлтийн макро тренд



Эх үүсвэр: Copper Prices - 45 Year Historical Chart | MacroTrends

Зэсийн зах зээлд Ковид-19 цар тахалтай холбоотой эрэлт болон нийлүүлэлтийн өөрчлөлт, мөн бодлогын нөлөө гарч, зах зээлийн үнийг сүүлийн 8 жилд хамгийн өндөр түвшинд хүргэсэн. Зэсийн нийлүүлэлтийн хувьд цаашид зах зээлийн тодорхой бус байдал, нийлүүлэлтийн удаан өсөлт тодорхой хугацаанд хадгалагдах өндөр магадлалтай байна.

Олон улсын зэс судлалын группийн 2019 оны “Дэлхийн зэсийн 2020 оны тайлан”-д дурдсанаар АНУ-ын Геологийн алба нь дэлхийн зэсийн нөөцийн геологийн үнэлгээг (олон улсын стандартуудын онцлогийг харгалзан) хийсэн. Нээгдээгүй байгаа ч нөөц, баялагт нэмэгдэх боломжтой таамаг баялгийн хэмжээг 3.5 тэрбум тонн зэс гэж үзжээ. Дэлхий дээр нээгдэж болох нийт зэсийн хэмжээ (ашиглах боломжгүйг оролцуулаад) 5.6 тэрбум тонн байх боломжтой гэнэ.¹⁴ 2019 оны байдлаар Чили улсын эдийн засгийн үр ашигтай нөөц нь 210 сая тонн буюу нийт дэлхийн нөөцийн 23 хувийг, Австрали 88 сая тонн буюу 12 хувийг, Перу 82 сая тонн буюу 11 хувийг, Мексик 46 сая тонн буюу 6.4 хувийг эзэлж байна.

Олон улсын зэс судлалын группийн 2020 оны тайланд дурдсанаар дэлхий даяар 360 орчим зэсийн уурхай бүртгэлтэй ажиллаж бөгөөд тэдгээрийн нийт суурилагдсан хүчин чадал нь 22 сая тонн ба хүчин чадлын ашиглалт дунджаар 87-90 хувьтай байна. Уурхайгаар авч үзэхэд, Чили улс нь дэлхийн зэсийн үйлдвэрлэлийн гуравны нэгийг бүрдүүлдэг бөгөөд 2019 онд 5.8 сая тонныг олборложээ. Үйлдвэрлэлийн хэмжээгээр Чили улс дэлхийд тэргүүлдэг бөгөөд тус улсад үйл ажиллагаа явуулж буй зэсийн 9 том уурхай л гэхэд дэлхийн үйлдвэрлэлийн 25-30 хувийг бүрдүүлдэг. Эдгээрийн дараа нь Перугийн 2 том уурхай орж байна.¹⁵

14 Supporting studies, including documentation of the assessment methodology and descriptions of individual tracts, are available on the USGS Mineral Resources Program Web site, at <https://www.usgs.gov/energy-and-minerals/mineral-resources-program/science/global-mineral-resource-assessment>

15 Ч.Отгочлуу, 2020, диссертаци

Хүснэгт 1.1. Зэсийн том уурхайнууд 2018

Экспортлогч (нийт үйлдвэрлэл сая.тн)	Том уурхай, (нөөц, сая.тн) ба (үйлдвэрлэл, мян.тн)	Төсөл хэрэгжүүлэгч голлох компани ба үлдэж буй хугацаа
Чили (5.3)	Escondida (32), (1,100)	BHP, 30 жил
	Collahuasi (26), (282)	Anglo-American, 90 жил
	Andina (18.8), (250)	Codelco, 75 жил
	El teniente (15.2), (417)	Codelco, 36 жил
	Radomiro tomic (12.1), (427)	Codelco, 28 жил
	Los bronces (11.1), (365)	Anglo-American, 30 жил
	Los pelambres (...), (400)	Antofagasta
	Chuquicamata (...), (350)	Codelco
	Radomiro tomic (12), (330)	Codelco, 36 жил
Перу (2.4)*	Toquepala (17.65), (152)	Хувьцаат компани
	Cerro verde (12.9), (270)	Freeport
	Antamina (...), (450)	BHP
	Las bambas (7.2), (450)	MMG
	Toromocho (...), (250)	
Хятад (1.8)	Zijinshan (...), (210)	Jiangxi copper
	Shuguang (...), (230)	Jiangxi copper
АНУ (1.3)	Morenci (5), (520)	
	Bingham canyon (), (280)	РиоТинто,
Австрали (0.9)	Olympic dam (146), (225)	BHP, 50 жил
Индонези (0.7)	Grasberg (28), (0.4)	Freeport
Канад (0.6)	Highland valley (30), (100)	Teck resources

* Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалт: 28.3 тэрбум ам.доллар бөгөөд үр дүнд нь хүчин чадал нь эрс өснө.

Зэсийн эрэлт цаашид жилд байнга өсөх хандлагатай байгаа бөгөөд дэлхийн хэмжээнд томоохонд тооцогдож буй 2019 оноос үйл ажиллагаа нь эхлэх 30 томоохон төслүүдээс хамгийн эхэнд бүтээгдэхүүн олборлож эхлэх том төсөл нь Оюу Толгойн гүний уурхайн төсөл байна.

Оюу Толгой, МАК компани болон Эрдэнэт үйлдвэр нийлээд Монголын эдийн засагт улам их өндөр үүргийг гүйцэтгэх тодорхой болж байна. Одоогийн байдлаар Эрдэнэт үйлдвэрлэлээ өргөтгөж эхлээгүй, МАК-ийн төсөл эхлээгүй байхад, зэсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх цорын ганц боломж нь Оюу Толгойн гүний уурхай ашиглалтад орох явдал байгаа юм. Зэсийн салбар ийнхүү дэлхий даяар хөгжиж, үнэ, эрэлт нэмэгдэж байгаа нь Монголын эдийн засагт асар том шинэ боломжийг нээж байна. Харин Оюу Толгойн гүний уурхайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд гүний уурхайг аль болохоор шуурхай ашиглалтад оруулах хэрэгтэй тул үүнд улс төрийн нэгдмэл байр суурь, санхүүжилтийн хэлэлцээр амжилттай байгуулагдах нь чухал байгаа юм. Зэс бол өөрөө технологийн хувьд цахилгаан машины гол түүхий эд болж байгаа тул Монголын эдийн засаг зэсийн салбарыг хөгжүүлснээр дэлхийн технологийн шинэ үед жинтэй хувь нэмэр оруулж, дэлхийн тогтвортой хөгжилд өөрийн гэсэн үүргээ гүйцэтгэх болно гэсэн үг. Цаашид Монголын эдийн засаг зэсийг олборлох, баяжуулахын зэрэгцээ түүнийг боловсруулж шинэ нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн гаргах, хөгжлийн шинэ шатанд гарах нөхцөлүүд бүрдэж байна. Зэс нэг үгээр манай улсын эдийн засгийн ирээдүйн хөдөлгүүр болж байна.

1.3. МОНГОЛ УЛС

Монгол Улсын хувьд зэсийн хүдрээр 11,444 сая тонн, металлаар 79,548.6 сая тонны зэсийн нөөцтэй, түүний зах зээлийн үнэлгээ (2018 оны байдлаар) 529 орчим тэрбум долларын үнэ цэнэтэй байгаа бөгөөд хайгууллын ажил идэвхтэй явагдаж байгаа¹⁶. Одоогийн ашиглаж байгаа ордуудын хувьд Эрдэнэт, Оюу Толгой нь эхний ээлжинд ашиглаж байгаа бол дараагийн ээлжинд Цагаан Суваргын¹⁷ орд ашиглалтанд орохоор бэлдэж байгаа. Эрдэнэтийн УБУ дангаараа ажиллаж байсан 2013 онд зэсийн экспорт нь манай улсын нийт экспортын 22.2 хувийг бүрдүүлж байсан бол Оюу Толгойн үйлдвэр ашиглалтад орсон үед буюу 2014 оноос зэсийн экспорт нийт экспортод эзлэх хувь 44.5 хувь, 2015 онд 49 хувь болж өсжээ¹⁸. Гүний уурхайн бүтээн байгуулалтыг амжилттай дуусгаснаар 2022-2023 оноос эхлэн Оюу Толгойн үйлдвэрлэлийн хэмжээ гурваас дөрөв дахин өснө гэсэн хүлээлттэй байна. Мөн түүнээс гадна дараагийн төслүүд бэлтгэлийн шатанд байгаа: зэс олборлолтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн буюу ихэвчлэн хайгуулын шатанд байгаа бусад төслүүд:

Хүснэгт 1.2. Монгол Улсын зэсийн шинэ төслүүд

Компани	Орд	Тайлбар
Эрдэнэ	Зуун Мод	Хайгуулын төгсгөлийн шатанд
Занаду Майнз	Шарчулуут	Эрлийн шатанд
Занаду Майнз	Оюут Улаан	Өрөмдлөг ба дээж шинжилгээ
Монголын Алт Компани	Цагаан Суварга	Хүлээгдэж буй хүчин чадал: Жилд 14.6 сая тонн хүдэр олборлох
Занаду Майнз	Хармагтай	Өрөмдлөг ба хайгуулын шат
Занаду Майнз	Хутаг Уул	Эрлийн шатанд
Төв Азийн Металз	Алаг Баян	Эрлийн шатанд
Эрдэнэ	Хувьын хар	Олборлолтод бэлдэх үедээ орсон
Эрдэнэ	Алтан Нар	Хайгуулын шатанд

Эх сурвалж: Компаниудын веб хуудас, БиЭМАЙ компанийн Монголын уул уурхайн тайлан

Зэсийн баяжмалын экспорт нь ойрын 20-30 жилдээ гадаад худалдааны эргэлтэд чухал байр суурь эзлэхээр байна. Ийнхүү зэсийн салбар 2016-2018 оны байдлаар Монгол Улсын экспортын 40-50 хувь, төсвийн орлогын 15-20 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70-80 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 20 орчим хувийг шууд утгаар бүрдүүлж байна. Харин бусад улсуудтай харьцуулахад зэсийн салбарын хөгжил үндэсний эдийн засагтай хэр их холбоотой байна вэ?

Олон улсын металлын холбооноос гаргасан судалгаанаас (ICMM, 2014, MCI-3) харахад, уул уурхайн салбар дундаж болон бага орлоготой орнуудад оруулж байгаа хувь нэмрийг харьцуулж үзэхэд, уул уурхайн салбар нийт ГШХО 60-90 хувийг эзэлж, экспортын 30-60 хувь, төсвийн орлогын 3-25 хувийг тус тус бүрдүүлж байдаг. Монгол Улсын хувьд нийт ГШХО-ын дийлэнх нь уул уурхайн салбарт, эдгээрээс томоохон хувь нь зэсийн Оюу Толгойд орж байгааг харгалзан, уул уурхайн салбар Монголын эдийн засагт оруулж байгаа хувь нь дэлхийн дунджаас илүү өндөр байгаа нь ойлгомжтой. Үүнийг индексээр харьцуулан үзэх боломжтой.

16 МОНГОЛ УЛСЫН ДУНД ХУГАЦААНЫ (2018-2025) ХӨГЖЛИЙН ХҮРЭЭ, ҮХГ Тайлан

17 Цагаан суваргын орд нь Дорноговь аймагт, Оюу Толгойгоос зүүн хойд зүгт 110 км-ийн алслагд оршдог. Сайншанд хот хүртэл 250 км зайтай учир ирээдүйд түүхий эдийн экспортын тээврийн нэгдсэн сүлжээнд холбогдох боломжтой. Тус ордын хувьд МАК компани нь 2006-2007 онд JORC стандартаар хүдрийн нөөцийн тооцоог хийж, улмаар 2009 оны 9-р сард түүнийг ЭБМЗ-өөр батлуулсан. Гэвч тухайн үеийн (хуучны) албан ангиллын дагуу бол нийт нөөц нь 1.6 сая тонн зэс (металлаар), 66 мянган тонн молибден, 11 мянган тонн алттай гэж бүртгэгдсэн. Үйлдвэрлэлийн хүчин чадал нь жилд 14.6 сая тонн хүдэр боловсруулахаар төлөвлөгдсөн. Тухайлбал, зэсийн баяжмал нь жилд 316 мянган тонн (агуулга нь 25.7%), молибдений баяжмал 4.4 тонн (агуулга нь 52%) байна. Уурхайг 18 жил ашиглахаар төлөвлөсөн ажээ.

18 Ч.Отгочулуу, 2020, диссертаци

Зураг 1.3. Уул уурхайн салбар хөгжиж буй орнуудын эдийн засагт оруулдаг хувь нэмрийн харьцуулалт

Уул уурхайн салбарын Гадаадын шууд хөрөнгө оруулалт нийт гадаадын хөрөнгө оруулалтын 60-90 хувийг бүрдүүлдэг.
Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 30-60 хувийг бүрдүүлдэг.
Уул уурхайн салбарын татварын орлого Засгийн газрын орлогын 3-25 хувийг бүрдүүлдэг.
Уул уурхайн салбарын ажил эрхлэлт нийт ажил эрхлэлтийн ДНБ-ий 1-2 хувийг бүрдүүлдэг.

Эх сурвалж: ICMM, 2014

Үүнээс үзэхэд, Монголын эдийн засаг бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад, уул уурхайн хөдөлмөр эрхлэлтийн түвшин илүү өндөр, экспортын хувь мөн илүү өндөр, төсвийн орлогын болон ДНБ-ий хувь илүү өндөр байгаа нь харагдаж байна. Ийнхүү Монголын эдийн засагт уул уурхайн эзлэх хувь, нөлөөг дэлхийн улсуудтай харьцуулахад манай улсад уул уурхайн салбарын ач холбогдол нилээд өндөр гарч байгаа. Олон улсын металлын холбооноос¹⁹ гаргадаг Уул уурхайн хувь нэмрийн индексийг (MCI) 3 үндсэн үзүүлэлтээр хэмжиж үзэж болно. Тус индексэд:

- Экспортод эзлэх хувь
- ДНБ-д эзлэх хувь
- Уул уурхайн салбарын орлого ДНБ-д эзлэх хувь зэрэг орж байгаа.

Монгол Улсын уул уурхайн хувь нэмрийг тооцоход их өндөр хувьтай байгаа бөгөөд 2020 оны жагсаалтад Монгол Улс тус үзүүлэлтээр дэлхийд 3-рт эрэмбэлэгдсэн. Үзүүлэлт тус бүрээр харвал:

- Экспортод эзлэх хувь 85.6 хувь
- ДНБ-д эзлэх хувь 37.6 хувь
- Уул уурхайн салбарын орлого ДНБ-д эзлэх хувь 28.8 хувь гэж тооцжээ.

Хүснэгт 1.3. Уул уурхайн салбарын үндэсний эдийн засагт оруулдаг хувь нэмрийн олон улсын индекс, эхний 23 улсын жагсаалт

Жагсаалтын эрэмбэлэл	Улс	Индексийн үзүүлэлт	Металл, нүүрсийн экспортын хувь	Металл, нүүрсийн ДНБ-д эзлэх хувь	Уул уурхайн салбарын орлого (рент) ДНБ-д эзлэх хувь
1	Суринам	98.1	80.1	45.28	19.92
2	Конго	97.6	91.1	32.7	16.17
3	Монгол Улс	95.7	85.6	37.61	28.8
4	Замби	95.5	76.1	20.64	14.62
5	Гвиней	94.6	82.6	14.30	9.68
6	Буркина Фасо	94.4	76.6	16.0	9.4
7	Кыргызстан	91.3	54.4	11.89	11.18
8	Судан	91.3	40.6	12.15	12.70
9	Мали	90	75.6	16.03	8.19
10	Зимбабве	88.2	44.5	17	3.74
11	Перу	88	60.5	13.04	8.21

Жагсаалтын эрэмбэлэл	Улс	Индексийн үзүүлэлт	Металл, нүүрсийн экспортын хувь	Металл, нүүрсийн ДНБ-д эзлэх хувь	Уул уурхайн салбарын орлого (рент) ДНБ-д эзлэх хувь
12	Боливи	87.8	43.3	6.66	4.11
13	Мозамбик	87.6	67.2	11.13	0.62
14	Намиби	86.7	50.6	6.61	4.19
15	Гана	85.5	38.3	8.48	5.65
16	Узбекистан	82.7	27.1	9.50	7.37
17	Казахстан	79.2	13.2	11.57	4.18
18	Сенегал	78.4	24.2	2.55	1.11
19	Колумби	77.2	22.8	3.13	0.52
20	Гуана	77.1	59.2	19.99	15.13
21	Ямайка	76.7	47.9	0.62	1.17
22	Гүрж	74.7	19.7	1.06	0.48
23	ОХУ	73.9	11	3.27	1.01

Эх сурвалж: ICMM 2014

Энэ индексийн үзүүлэлт нь сүүлийн жилүүдэд өсөж байгаа үзүүлэлт юм. Монгол Улс тус индексэд 2016 онд 20-р байранд байсан бол 2018 оны байдлаар 17 байраар ахиж, дэлхийн эхний гурван орны нэгэнд орсон. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр олон аж ахуйн нэгж хүнд байдалд орж, экспорт, үйлдвэрлэл нийтдээ буурч, ДНБ 5.3 хувиар 2020 онд буурсан үед уул уурхайн салбарын манай эдийн засаг дах гүйцэтгэх үүрэг, ач холбогдол улам өндөр болох нь тодорхой болж байна. Үүнд экспорт, ДНБ, төсвийн орлогыг дурдсан бол өөр нэг чухал үзүүлэлт нь тус салбарын хөдөлмөр эрхлэлтийн нийт хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувь байгаа юм. Тус үзүүлэлт буюу нийт хөдөлмөр эрхлэлтэд уул уурхайн хөдөлмөр эрхлэлт эзлэх хувийн хувьд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын судалгаанаас үзэхэд Монгол Улс судалгаанд хамрагдсан орнуудын дотор 2-рт орсон (3.7%, Перу 1-р байранд 4.3%).

Хүснэгт 1.4. Нийт хөдөлмөр эрхлэлтэд уул уурхайн хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувийн харьцуулалт, 2014

Улс	Он	Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлт	Нийт хөдөлмөр эрхлэлт	Нийт хөдөлмөр эрхлэлтэд уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлт эзлэх хувь %
Peru	2013	198,000	4,598,800	4.3%
Mongolia	2014	40,900	1,110,700	3.7%
Kazakhstan	2013	249,300	8,570,600	2.9%
South Africa	2014	428,000	15,317,000	2.8%
Ukraine	2015	399,100	16,443,200	2.4%
Namibia	2013	13,600	685,700	2.0%
Bolivia	2014	100,300	5,082,000	2.0%
Zambia	2012	90,000	5,386,100	1.7%
Liberia	2010	17,000	1,091,000	1.6%
Zimbabwe	2014	92,300	6,265,900	1.5%
Madagascar	2012	126,800	10,441,900	1.2%
Ghana	2010	112,700	10,243,500	1.1%
Senegal	2011	41,200	3,777,900	1.1%
Guinea	2012	53,300	4,982,500	1.1%
Bulgaria	2015	25,700	3,031,900	0.8%
Iran	2014	159,500	21,304,300	0.7%

Улс	Он	Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлт	Нийт хөдөлмөр эрхлэлт	Нийт хөдөлмөр эрхлэлтэд уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлт эзлэх хувь %
Armenia	2015	8,000	1,072,600	0.7%
Philippines	2015	234,500	38,740,800	0.6%
Turkey	2015	118,800	26,618,500	0.4%

Эх үүсвэр: ILO Тайлан, судалгаа

Зэсийн нөөц ихтэй улсуудтай харьцуулахад, уул уурхайн хөдөлмөр эрхлэлт нийт хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувиар хэмжихэд Монгол Улс Перу улсын дараа, Казахстанас илүү өндөр үзүүлэлттэй байна. Зэсийн нөөцөөр тэргүүлдэг Чили улстай харьцуулахад, тус улсад²⁰ зэсийн үйлдвэрлэл ДНБ-ий 5-20 хувийг эзэлж байсан бөгөөд энэ нь Монголоос илүү өндөр үзүүлэлт юм. 2003-2016 оны хооронд зэсийн экспорт Чили улсын нийт экспортын 51 хувийг дунджаар эзэлж, жилд 31 тэрбум долларт хүрч байсан. Монгол Улсын хувьд нийт экспортын дотор зэсийн эзлэх хувь тийм өндөр биш бөгөөд манай улсын нийт экспортын хэмжээ одоогийн байдлаар 6-7 тэрбум доллар байгаагаас үзэхэд Чили зэсээс илүү их экспортын орлого олдог. Чили улсын зэс олборлодог голлох бүсийн цалин бусад бүсүүдээс 2 дахин өндөр байна (дунджаар 16 мянган долларын орлоготой байхад, 2015 онд зэсийн бүсийн дундаж нэг хүнд ногдох дундаж ДНБ 30 мянган доллароос илүү байж, бүсийн цалингийн хэмжээ 80-110 хувь байгаа нь бусад бүсүүдийн дунджаас өндөр байсан. 1990-2006 оны хооронд дунджаар Чили улс зэсээс нийт төсвийн орлогын 7.8 хувийг бүрдүүлж байсан. Энэхүү үзүүлэлт ихээхэн хэлбэлздэг байсан тул Чили улс төсвийн тогтворжуулалтын тухай хуулийг баталж, хожим манай улс Чилийн туршлагыг хэрэглэж төсвийн тогтворжуулалтын санг байгуулсан. 1990 онд Чили улсын ядуурлын түвшин 40 хувь хүрч байсан бол 2015 онд 8.5 хувь болж буурч, зэсийн салбар 400 мянган ажлын байртай болж, 20 тэрбум долларын ханган нийлүүлэгчдийн салбарт нөлөөлжээ. Чили улсад зэсийн салбарт 350 доктор зэрэгтэй судлаачид ажиллаж, энэ нь нийт докторын зэрэгтэй судлаачдын 6 хувийг бүрдүүлсэн. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд ийнхүү Чили улс зэсийн салбарыг хөгжүүлснээр ядуурлыг 30 хувиар бууруулж, нэг хүнд ногдох ДНБ-ийг 4 дахин өсгөжээ.

Перу улсын хувьд жилд 1 сая орчим тонн зэсийг олборлож нийт экспортын 23 хувийн орлогыг олдог байна. 1990-2000 оны хооронд тус улсын ашигт малтмалын экспортын хэмжээ 15 дахин өсөж, зэсийн экспортоор дэлхийд 3-рт ордог бөгөөд уул уурхайн өрсөлдөх чадварын индексээр дэлхийд Чили дараа 2-рт орж байна. Перу улсад уул уурхай ДНБ-ий 12 хувийг эзэлж бөгөөд нийт экспортын 50 орчим хувийг бүрдүүлдэг. Энэ талаас харахад манай улсын хувьд Перу шиг дэлхийд нөөцөөрөө тэргүүлдэггүй, гэхдээ манайд уул уурхай экспорт болон ДНБ-д илүү өндөр хувийг бүрдүүлж байгаа. Перу улсад уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлтийн бусад салбаруудын шууд бус үржүүлэгч 3.2 байсан. Харин уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ 14 тэрбум долларт хүрч байсан. Судалгаанаас харахад, Перугийн ДНБ-ий өсөлтийн 1/3-ийг уул уурхайн салбар²¹ эзэлж, мөн төсвийн орлогын 13-17 хувийг уул уурхай бүрдүүлдэг юм.

Бүлгийн дүгнэлт

Дэлхийн зэсийн эрэлт хэрэгцээ нь цаашид сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон гибрид машин, хотжуулалт, цахилгаанжуулалт, эрүүл мэндийн салбарын өсөлттэй уялдан тасралтгүй өсөх хандлагатай байна.

Дэлхийн нөөцтэй харьцуулахад, Монгол Улсын нөөц нь тийм их биш боловч цаашид Оюу Толгойн гүний уурхай, Цагаан Суварга болон хайгуулын шатанд байгаа бусад төслүүдийг авч үзэхэд манай

20 The Impacts of Copper Mining in Chile Economic and Social Implications for the Country, Copper Alliance, 2017

21 McKinsey, Assessment of Copper industry in Peru, 2013

улсын зэсийн салбарт чухал нийлүүлэгч болох боломж нь бүрдэж байна.

Уул уурхайн болон түүний бүрэлдэхүүн хэсэг болох зэсийн салбар Монголын эдийн засагт маш чухал үүргийг гүйцэтгэж, уул уурхайн салбар үндэсний эдийн засагт оруулж байгаа хувь нэмрээр Монгол Улс дэлхийд 3-рт орж, Узбекистан (16), Казахстан (17), Гүрж (22), ОХУ (23) зэрэг орнуудаас уул уурхайн салбар нь илүү өндөр хувь нэмэртэй байна. Мөн зэсийн хувьд манайхаас илүү нөөцтэй Перу, Чили зэрэг орнуудаас манай улсын хувьд уул уурхайн салбарын хувь нэмэр өндөр байна. Энэ нь манай улс зөвхөн зэс бус, нүүрс зэрэг бусад төрлийн ашигт малтмал харьцангуй ихтэй байгаатай холбоотой, мөн бусад салбарын хөгжил эдгээр орнуудаас харьцангуй доогуур байгаатай холбоотой.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд уул уурхайн салбар манай улсад маш чухал бөгөөд нийт хөдөлмөр эрхлэлтэд уул уурхайн салбар нь ажлын байр бүтээж байгаа хувиар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын судалгааны дагуу дэлхийд 2-рт оржээ. Цаашид уул уурхайн салбар манай улсад илүү эрчимтэй хөгжих нөөц, бололцоо их байгаа тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шинэ ажлын байруудтай болоход тус салбарын хувь нэмэр, ач холбогдол нь улам өсөх нь тодорхой байна.

Цаашид үндэсний эдийн засагт уул уурхайн салбарын оруулж байгаа хувь нэмрийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлт, хөгжлийн хөдөлгүүр болж ашиглах нь чухал бөгөөд тус хувь нэмрийг ашиглан эдийн засгийн бусад салбаруудыг мөн хөгжүүлж, Чили зэрэг улстай адил олон салбарын төрөлжилтийн (диверсификаци) бодлого нэн чухал байгаа юм.

Цаашдын хандлага

Өнгөрсөн 25 жилд зэсийн эрэлт хоёр дахин нэмэгдсэн бөгөөд McKinsey компанийн дэргэдэх Дэлхийн хүрээлэнгийн судалгаагаар 2035 онд эрэлт нь одоогийн түвшнээс 43 хувиар өсөх хандлагатай ажээ. Fitch Solutions компанийн хийсэн дэлхийн зэсийн судалгааны тайлан²²-г үзвэл, 2021 оноос эхлэн дэлхийн эрэлт нь нийлүүлэлтээс давна. Тухайлбал, Олон улсын зэс судлалын группийн таамаглаж буйгаар бол 2025 онд зэсийн зах зээлд 5 сая тонн зэсийн нийлүүлэлтийн хомсдол (30 орчим Оюу Толгойн үйлдвэрлэлтэй тэнцэхүйц) үүснэ. Учир нь, технологийн хөгжил, хотжилт, цахилгаанжуулалт, эрчим хүчний хувьсгал, дэлхийн хүн амын өсөлт, хөгжиж буй орнуудын орлого нэмэгдэх, сэргээгдэх эрчим хүчний салбарт гарч буй хувьсгал зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр дэлхийн эрэлт жил бүр дунджаар 3.4-4.0 хувиар өсөх болно.

БНХАУ-ын хувьд 2000-2010 оны хооронд зэсийн хэрэглээ нь дунджаар 8-12 хувиар өсөж ирсэн боловч сүүлийн жилүүдэд 4.5-5.0 орчим хувьд хүрч саарч ирлээ. Олон улсын валютын нээлттэй цахим сангийн статистик мэдээллээс үзэхэд, БНХАУ-ын нэг хүнд оногдох ДНБ хэмжээ 10 мянган америк доллар, харин нэг хүнд оногдох зэсийн хэрэглээ нь 8 кг (Тайваньд 30 кг, Өмнөд Солонгост 22 кг) байгаа юм. Хятадын хүн ам өсөх хэрээр зэсийн нийт хэрэглээ нь өсөж 2025 он гэхэд 11 сая тоннд хүрэхээр байна. Нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ нь өсөх учир нэг хүнд оногдох зэсийн хэрэглээ нь өнөөдрийн найман кг-аас өсөж, Өмнөд Солонгосын түвшин рүү ойртох боломжтой.

Нийлүүлэлтийн хувьд байдал өөр байгаа юм. Америк ба Чили дэх зэсийн уурхайнууд хурдтай өвгөрч, нөөц нь шавхагдах бөгөөд үйлдвэрлэл нь буурч эхлэх юм.


II. ОЮУ ТОЛГОЙН МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

2.1. ДНБ БА ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УЯЛДАА

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг тэтгэх үндсэн салбар нь одоогоор уул уурхайн салбар гэдгийг өмнөх бүлэгт дурдсан. ДНБ-ий өсөлт бууралт нь энэхүү салбарын өсөлт хөгжлөөс шууд хамаарч, энэ салбараас олсон орлого нь эдийн засгийг тэтгэх суурь болж байна. Уул уурхайн салбарын Монгол Улсын ДНБ-д эзлэх хувьд 2011-2020 оны хооронд дунджаар 21.7 хувийг эзэлж байна.

Уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай ба Монгол Улсын хувьд дангаараа дотоодын хөрөнгө оруулалт хийх боломж бага тул гадаадын шууд хөрөнгө оруулалтад тулгуурлана. 2011-2020 оны хооронд Монгол Улсад хийгдэж байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын дунджаар 73.4 орчим хувь нь зөвхөн уул уурхайн салбарт ноогдож байна.

Зураг 2.1. ГШХО-д Уул уурхайн салбарын ГШХО-ын эзлэх хувь




Эх сурвалж: ҮСХ, Монгол банк

Монголбанкны тайлангаас харвал ГШХО 2019 онд 3133 сая доллар байсан бол 2020 онд 2548 сая ам.доллар болж 22.8 хувиар буурсан нь дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотой гэж харагдаж байна. Энэхүү цар тахлын нөлөөгөөр нийт ГШХО-д уул уурхайн салбарын эзлэх хувийн жин хэлбэлзэж, 2020 оны 1 дүгээр улиралд 78.4 хувь байсан бол 2020 оны 3 улиралд 62.1% болж буурсан. Энэ нь Оюу Толгой төслийн хөрөнгө оруулалт саатсан 2016 оны 2 дугаар улирлаас хойш бүтцэд гарсан хамгийн том өөрчлөлт хэдий ч 2020 оны 4 дүгээр улирлаас төслийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн.

Нийт ГШХО-д уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын эзлэх хувь 73.4 хувь байгаагийн хувьд ГШХО-ын өөрчлөлт нь уул уурхайн салбарын ГШХО-ын өөрчлөлтөөр бүрэн тодорхойлогдож, өөрөөр хэлбэл, динамик өөрчлөлт нь адил хэлбэртэй байна.

Зураг 2.2. ГШХО болон уул уурхайн салбарын ГШХО-ын өсөлт




Эх сурвалж. ҮСХ

Оюу Толгойн гүний уурхайн хөрөнгө оруулалттай холбоотой 2017 оноос огцом өсөлт гарсан нь нийт ГШХО-ыг өсгөхөд хүргэжээ. Хэдийгээр өсөлтийн хурд саарсан боловч дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас ГШХО-ын орох урсгал мөн саарч, уул уурхайн салбарын ГШХО 22.2 хувиар буурсан нь нийт ГШХО-ыг 18.5 хувиар буурахад нөлөөлсөн.

Монгол Улсын бодит ДНБ-ий динамик өөрчлөлт, бодит Уул уурхайн салбарын динамик өөрчлөлттэй холбон авч үзье.

Зураг 2.3. Бодит ДНБ, бодит уул уурхайн салбар, ГШХО-ын өсөлтийн динамик



Эх сурвалж: ҮСХ, Монгол банк

ГШХО-ын өсөлт буурсан жилүүдэд ДНБ болон уул уурхайн салбар өсөлттэй гарч байгаа мэт харагдавч энэ нь Оюу Толгойн ил уурхайн хөрөнгө оруулалт үндсэндээ хийгдэж, олборлох үйл ажиллагаа эхэлсэнтэй холбон тайлбарлаж болох юм. Харин 2017 оноос гүний уурхайн бүтээн байгуулалттай холбоотойгоор хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж эхэлсэн ч энэ нь бодит байдалд ДНБ болон уул уурхайн салбарын өсөлтийг бүрэн дэмжиж чадаагүй байна. Мөн 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөө ГШХО, ДНБ болон уул уурхайн салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлсөн болох нь харагдаж байна.

2.2. ОЮУ ТОЛГОЙН ТАТВАР, ТӨЛБӨР ХУРААМЖИЙН МОНГОЛ УЛСЫН ДНБ-Д ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

ДНБ-ийг үйлдвэрлэл, зардлын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог. Үүний нэг болох ДНБ-ийг орлогын аргаар тооцоход үйлдвэрлэлийн болон импортын татвар, хураамжийг оруулдаг тул ОТ компанийн төлсөн төлбөр хураамжаар дамжин ДНБ-ийг өсгөхөд нөлөөлдөг.

Хүснэгт 2.1. ДНБ ба Оюу Толгойн Монгол Улсад төлсөн нийт төлбөр /сая.₮/

	Оюу Толгойн нийт төлбөр	ДНБ оны үнээр	Хувийн жин
2016Q4	121,269.1	6,845,296.0	1.8%
2017Q1	122,121.8	5,563,338.5	2.2%
2017Q2	135,468.2	7,607,596.2	1.8%
2017Q3	146,722.1	6,985,786.8	2.1%
2017Q4	196,556.0	7,719,575.7	2.5%
2018Q1	185,189.9	6,642,626.1	2.8%
2018Q2	183,907.5	8,517,119.7	2.2%
2018Q3	205,432.0	8,181,737.7	2.5%
2018Q4	222,322.6	9,069,740.6	2.5%
2019Q1	226,500.4	7,658,989.4	3.0%
2019Q2	208,608.3	9,795,506.9	2.1%
2019Q3	217,915.3	9,725,215.5	2.2%
2019Q4	202,318.5	10,212,917.3	2.0%
2020Q1	201,720.7	7,181,928.3	2.8%
2020Q2	168,131.3	9,697,166.3	1.7%
2020Q3	188,991.6	9,927,940.1	1.9%
2020Q4	267,238.7	10,522,511.0	2.5%

Эх сурвалж: YCX, Оюу Толгой ХХК

Оюу Толгойн төлсөн татвар, хураамж, төлбөрийн хэмжээ нь оны үнээр өгөгдсөн тул Монгол Улсын ДНБ-ийг мөн оны үнээр авч үзсэн болно. Монгол Улсын ДНБ-ий оны үнээр 2020 онд бага зэргийн өсөлттэй гарсан боловч бодит ДНБ-ээр авч үзвэл 5.4 хувиар агшсан байна.

Ерөнхий статистик үзүүлэлтээс харвал 2020 оны 4 дүгээр улирлыг дуусталх хугацаанд Оюу Толгой улиралд дунджаар 188.3 орчим тэрбум төгрөг төлж байсан нь Монгол Улсын ДНБ-ий 2.25%-ийг эзэлсэн.

Хүснэгт 2.2. Оюу Толгойн нийт төлбөр болон Монгол Улсын ДНБ-ий ерөнхий статистик (тэрбум ₮)


	N	Дундаж	Медиан	Стандарт хазайлт	Далайц	Хамгийн бага утга	Хамгийн их утга
Оюу Толгойн нийт төлбөр	17	188.26	196.56	39.29	145.97	121.27	267.24
МУ-ын ДНБ, оны үнээр	17	8,344.4	8,181.7	1,471.5	4,959.2	5,563.3	10,522.5

Эх сурвалж: YCX, Оюу Толгой ХХК

Энэ хугацаанд хамгийн багадаа 121.27 тэрбум төгрөг /2016.04 улирал/ буюу тухай үеийн ДНБ 1.7 хувь байсан бол хамгийн ихдээ 267.24 тэрбум /2020.04 улирал/ буюу тухайн үеийн ДНБ-ий 2.5 хувь болж байна. Энэ хугацааны хамгийн их болон бага утгын зөрүү нь 145.97 тэрбум төгрөг байна.

Дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын өмнөх жил болох 2019 онд Монгол Улсын ДНБ-д Оюу Толгойн төлсөн төлбөр 855.34 сая төгрөг буюу ДНБ-ий 2.29 хувь байсан бол 2020 онд 826.02 сая төгрөг буюу ДНБ-ий 2.21 хувь болж 0.08 пункт (percentage point)-ээр буурсан.


Зураг 2.4. ДНБ ба Оюу Толгойн Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн динамик /тэрбум.₮/



Эх сурвалж: УСХ, Оюу Толгой ХХК

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор ДНБ-ий хамгийн бага байдаг жил бүрийн 1 дүгээр улиралд Оюу Толгойн Монгол Улсад төлж байсан төлбөр хураамжийн эзлэх хувийн жин хамгийн өндөр гарч байна. Үүнийг зургаар харуулбал:

Зураг 2.5. Монгол Улсын ДНБ-д Оюу Толгойн төлсөн нийт төлбөрийн эзлэх хувь




Эх сурвалж: УСХ, Оюу Толгой ХХК

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2019 онтой харьцуулахад эхний 3 улирал бууралттай байсан нь ДНБ-ий эзлэх хувийг хамгийн бага түвшинд хүргэсэн боловч 2020 оны 4 дүгээр улиралд хамгийн өндөр төлбөр хураамж төлсөн нь 2017, 2018 оны 4 дүгээр улирлын түвшинд хүргэсэн.

Өөрчлөлтийг авч үзвэл, Ковид-19 цар тахалтай холбоотой өндөржүүлсэн болон хатуу хөл хорионы арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энд хил гаалийг хаасантай холбоотойгоор Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 2020 оны 1 дүгээр улиралд өмнөх улиралтай харьцуулахад хамгийн өндөр бууралттай байжээ.

Зураг 2.6. ДНБ ба Оюу Толгойн Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн өөрчлөлт, улирлаар /хувиар/



Эх сурвалж: ҮСХ, Оюу Толгой ХХК

Оюу Толгойн хувьд 2019 онд Монгол Улсад төлсөн төлбөр хураамжийн өөрчлөлт харьцангуй өсөлт бууралтын хэлбэлзэл бага байсан ч 2020 оны 2 дугаар улиралд хамгийн өндөр хувиар буюу 18.2 хувиар буурсан бол 3 дугаар улиралд 11.7 хувь, 4 дүгээр улиралд хамгийн өндөр өсөлтийн хувь болох 34.6 хувьд хүрч өссөн.

ДНБ болон Оюу Толгойн Монгол Улсад төлсөн төлбөрийн хураамж хооронд урт хугацааны хамаарал байгаа эсэхийг коинтеграцийн шалгуурыг ашиглан тодорхойлж үзлээ. Энд ДНБ улирлаар өгөгдсөн тул улирлын хэлбэлзлийг засварлаж шинжилгээнд ашигласан болно. Хоёр хувьсагчийн хувьд тогтвортой бус бөгөөд эрэмбийн ялгавар авч тогтвортой болж байна. Шинжилгээний үр дүнгээс харвал урт хугацааны тогтвортой хамааралтай байна. Урт хугацаанд Оюу Толгойн төлсөн төлбөр хураамжийн хэмжээ 1 хувиар нэмэгдэхэд Монгол Улсын ДНБ дунджаар 0.52 хувиар нэмэгдэж байна. Коэффициентын хувьд 1 хувийн түвшинд статистик ач холбогдолтой байна. Гранжерийн учир шалтгааны шалгуурын 1 хугацааны хоцрогдол бүхий утгаар авч үзэхэд Оюу Толгойн төлбөр хураамж болон Монгол Улсын ДНБ нь харилцан нөлөөлдөг гэж гарлаа.

2.3. ОЮУ ТОЛГОЙН ТАТВАР, ТӨЛБӨР ХУРААМЖИЙН МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, түүнд эзэлж буй Оюу Толгойн Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн хэмжээг 2016 оны 4 дүгээр улирлаас 2020 оны 4 улирлыг дуусталх хугацаанд нийт 17 улирлын байдлаар авч үзлээ.

Хүснэгт 2.3. Төсвийн орлого ба ОТ-н Монгол Улсад төлсөн нийт төлбөр /сая.₮/

Улирал	Оюу Толгойн нийт төлбөр	Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого	Хувийн жин
2016Q4	121,269.1	1,822,367.2	6.7%
2017Q1	122,121.8	1,616,090.	7.6%
2017Q2	135,468.2	1,970,746.6	6.9%
2017Q3	146,722.1	1,904,162.7	7.7%
2017Q4	196,556.0	2,467,265.5	8.0%
2018Q1	185,189.9	1,993,794.2	9.3%
2018Q2	183,907.5	2,557,638.3	7.2%
2018Q3	205,432.0	2,630,230.	7.8%
2018Q4	222,322.6	2,871,965.1	7.7%
2019Q1	226,500.4	2,433,092.8	9.3%

2019Q2	208,608.3	3,115,675.7	6.7%
2019Q3	217,915.3	3,107,893.9	7.0%
2019Q4	202,318.5	3,279,975.9	6.2%
2020Q1	201,720.7	2,224,565.1	9.1%
2020Q2	168,131.3	2,134,139.5	7.9%
2020Q3	188,991.6	2,958,008.3	6.4%
2020Q4	267,238.7	3,085,362.7	8.7%

Эх сурвалж: Оюу Толгой ХХК, ҮСХ

Хүснэгт 2.4. Оюу Толгойн нийт төлбөр болон улсын нэгдсэн төсвийн ерөнхий статистик

	N	Дундаж	Медиан	Стандарт хазайлт	Далайц	Хамгийн бага утга	Хамгийн их утга
Оюу Толгойн нийт төлбөр	17	188.26	196.56	39.29	145.97	121.27	267.24
МУ-ын нэгдсэн төсвийн орлого	17	2'480.76	2'467.26	524.93	1'663.88	1'616.09	3'279.97


Эх сурвалж: Оюу Толгой ХХК, ҮСХ

Оюу Толгой нь Монгол Улсад улиралд дунджаар 188.26 тэрбум төгрөгийн татвар, төлбөр хураамжийг төлж байсан бөгөөд энэ хугацаанд хамгийн багадаа 121.27 тэрбум /2016 оны 4 улиралд/, хамгийн ихдээ 267.24 /2020 оны 4 улирал/-д төлжээ.

Монгол Улсын төсөвт төлж байгаа Оюу Толгойн татвар, төлбөр хураамжийн улирал бүрийн дундаж дүн нь 2019 оныг дуустал нэмэгдэх хандлагатай байсан бол Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хэдийгээр 2020 оны 4 дүгээр улиралд хамгийн өндөр татвар, төлбөр хураамж төлсөн боловч улирлын дунджаар өмнөх 2019 онтой харьцуулахад 3.4 хувиар буурсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг улирлаар авч үзэхэд өсөлт бууралттай харагдаж байгаа ч энэ нь улирлын шинж чанартай байгаа нь харагдаж байна.


Зураг 2.7. Төсвийн орлого ба ОТ-н Монгол Улсад төлсөн нийт төлбөр /сая.₮/



Эх сурвалж: Оюу Толгой ХХК, ҮСХ

Нэгдсэн төсвийн орлого болон Оюу Толгойн төсөвт төлж буй татвар хураамжийн дүн богино хугацаанд өсөлт, бууралт ажиглагдаж байгаа ч урт хугацаандаа өсөх хандлагатай байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор улсын нэгдсэн төсвийн орлого 2020 оны 1, 2 дугаар улиралд ихээхэн буурсан боловч 3 дугаар улирлаас нэмэгдсэн. Оюу Толгойн хувьд хэдийгээр төсөвт төлсөн татвар хураамжийн дүн бага хэмжээгээр буурсан ч 2020 он 3, 4 дүгээр улиралд нэмэгдэж, энэ нь Ковид-19 цар тахалгүй байх үеийн дүнгээс давж гарсан нь Монголын эдийн засгийн хүндрэлийг даван туулахад зохих нөлөөг үзүүлж чадсан.


Зураг 2.8. Нэгдсэн төсвийн орлогод эзлэх ОТ-н Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн эзлэх хувь



Эх сурвалж: Оюу Толгой ХХК, УСХ

Нэгдсэн төсөвт эзлэх хувийн жингээс харвал Оюу Толгой, Монгол Улсын төсөвт төлж буй байдлаараа жил бүрийн 1 дүгээр улиралд хамгийн өндөр хувьтай, 4 дүгээр улиралд бага жин эзлэх хандлагатай явж ирсэн ч 2020 оны 4 дүгээр улиралд энэ дүн өмнөх жилүүдтэй харьцуулахад өндөр гарсан. Ковид-19 цар тахлаас улбаатайгаар Монгол Улсын төсөвт төвлөрүүлэх дүн буурсан боловч хувийн жин буураагүй бөгөөд 2020 оны 4 дүгээр улиралд төлсөн дүн нь өмнөх жилүүдийн 4 дүгээр улиралтай харьцуулахад 8.7 хувь болж өмнөх жилийн мөн үеийнхээс 2.5 нэгж хувиар өндөр гарсан.

Зураг 2.9. Төсвийн орлогын өөрчлөлтийн хувь ба ОТ-н Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн өөрчлөлтийн хувь /улирлаар/



Эх сурвалж: Оюу Толгой ХХК, УСХ

Төсвийн орлогын өөрчлөлт болон Оюу Толгойн төсөвт төлсөн төлбөр хураамжийн өөрчлөлтийг авч үзвэл 2018 оны 1 дүгээр улирал, 2019 оны 2 болон 4 дүгээр улирал, 2020 оны 2 улиралд тус тус буурсан. Бусад улирлуудад нэмэгдэж байгаа ч 2020 оны 3, 4 дүгээр улиралд өөрчлөлтийн хувьд Ковид-19 цар тахал гарснаас үл хамааран өндөр гарчээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого болон Оюу Толгойн Монгол Улсад төлсөн нийт төлбөрийн хооронд урт хугацааны хамаарал байгаа эсэхийг коинтеграцийн шалгуур ашиглан тодорхойлж үзлээ. Үр дүнгээс харвал урт хугацааны хамаарал тогтвортой гарсан бөгөөд Гранжерийн учир шалтгааны шалгуураар шалгаж үзэхэд Оюу Толгойн төлсөн төлбөр нь Монгол Улсын төсвийн орлогод нөлөөтэй гэж гарлаа. Энэ шинж чанарт тулгуурлан Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогод үзүүлж буй Оюу Толгойн төлсөн нийт төлбөрийн нөлөөг шугаман регрессийн загвар ашиглан тодорхойлж үзэв. Шинжилгээний үр дүнгээс харвал Оюу Толгойн төлсөн төлбөр хураамжийн хэмжээ 1 хувиар нэмэгдэхэд Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого дунджаар 0.81 хувиар нэмэгдэж байна. Коэффициентын хувьд 1 хувийн түвшинд статистик ач холбогдолтой (statistically significant at 1% level) гарсан.

2.4. ОЮУ ТОЛГОЙН ЭКСПОРТЫН МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ОРЛОГОД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Оюу Толгойн нийт экспортын Монгол Улсын экспортын орлогод үзүүлж буй нөлөөг харуулахдаа нийт экспортын орлого болон түүнд эзэлж буй Оюу Толгойн экспортын дүнг 2016 оны 4 дүгээр улирлаас 2020 оны 4 улирлыг дуусталх нийт 17 улирлын байдлаар авч үзлээ.

Хүснэгт 2.5. Монгол Улсын экспортын хэмжээ ба Оюу Толгойн экспортын хэмжээ /сая ам.доллар/

Улирал	Монгол Улсын экспорт	Оюу Толгойн экспорт	Хувийн жин
2016Q4	1583.90	224.5	14.17
2017Q1	1299.80	237.5	18.27
2017Q2	1805.90	203.7	11.28
2017Q3	1477.10	246.9	16.72
2017Q4	1617.80	251.7	15.56
2018Q1	1482.44	245.6	16.57
2018Q2	2098.90	341.7	16.28
2018Q3	1701.40	246.5	14.49
2018Q4	1728.90	346.2	20.02
2019Q1	1771.70	352.7	19.91
2019Q2	2167.30	382.7	17.66
2019Q3	2007.10	209.2	10.42
2019Q4	1673.70	221.4	13.23
2020Q1	1035.80	130.7	12.61
2020Q2	1792.60	285.6	15.93
2020Q3	2318.90	283.0	12.20
2020Q4	2429.30	405.0	16.67

Эх сурвалж: ҮСХ, Оюу Толгой ХХК

ҮСХ-ны мэдээллийн санд эрдэс бүтээгдэхүүн буюу уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байгаа тул Оюу Толгойн экспортод үзүүлэх нөлөөллийг судлахдаа нийт экспортыг доллароор илэрхийлсэн дүнгээр авч үзлээ. Учир нь Монгол Улсын нийт экспортод эрдэс бүтээгдэхүүн экспорт сүүлийн дөрвөн жилийн дунджаар 80 хувийг эзэлж байгаа нь нийт экспортоор авахад шинжилгээний үр дүнд нөлөөлөхөөргүй байна гэж үзлээ.


Хүснэгт 2.6. Оюу Толгойн экспорт болон Монгол Улсын нийт экспортын ерөнхий статистик

	N	Дундаж	Медиан	Стандарт хазайлт	Далайц	Хамгийн бага утга	Хамгийн их утга
Оюу Толгойн экспорт	17	271.45	246.90	72.51	274.39	130.66	405.05
МУ-ын нийт экспорт	17	1764.27	1728.90	358.95	1393.50	1035.80	2429.30

Эх сурвалж: ҮСХ, Оюу Толгой ХХК

Ерөнхий статистик үзүүлэлтийг 2016 оны 4 дүгээр улирлаас 2020 оны 4 дүгээр улирал хүртэлх нийт 17 улирлын мэдээний хувьд тооцсон. Оюу Толгойн хувьд экспортын хэмжээ 2020 оны 1 дүгээр улиралд хамгийн бага дүн буюу 130.66 сая долларын экспорт хийсэн бол 2020 оны 4 дүгээр улиралд хамгийн их буюу 405.5 сая долларын экспортыг хийсэн нь Монгол Улсын нийт экспортын хамгийн бага болон хамгийн их экспорт хийсэн үетэй тохирч байна. Үүнийг зурагт үзүүлсэн сүүдэртүүлсэн хэсгээс тодорхой харж болно. Оюу Толгойн улирлын дундаж экспортын хэмжээ 271.45 сая доллар байгаа бол МУ-ын хувьд 1764.7 сая доллар, стандарт хазайлт нь харгалзан 72.51 болон 358.95 байна.

Зураг 2.10. Монгол Улсын экспортын дүн ба Оюу Толгойн экспорт /сая ам.доллар/




Эх сурвалж: ҮСХ, Оюу Толгой ХХК

Оюу Толгойн экспорт нь Монгол Улсын экспорттой хамааралтай, 2017 оны 3 дугаар улирлаас эхлэн өсөлт бууралтын чиг хандлага нь ижил байна. Хоёр үзүүлэлтийн хоорондын хамаарлын хүчийг корреляцийн коэффициентээр тодорхойлж үзвэл буюу 70.6 хувийн хамааралтай байна.

Экспортын бууралт 2019 оны 2 дугаар улирлаас буурч, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор, хил хаагдах, түүхий эдийн үнэ буурах гэх мэт тодорхой шалтгааны улмаас 2020 оны 1 дүгээр улиралд доод 4 жилийн хамгийн доод түвшиндөө хүрсэн. Энэ нь эргээд Монгол Улсын төсвийн орлого болон Оюу Толгойн Монгол улсад төлөх татвар, төлбөр хураамжийн бууралтад шууд нөлөөлсөн.

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан зарим улс оронд хөл хязгаарлалтын нөхцөлийг бууруулах, эдийн засгаа сэргээх бодлого явуулсны үр дүнд хил хориог сулруулах, түүхий эдийн үнэ сэргэх нөхцөл бүрдэж эхэлсэн нь Оюу Толгой болон Монгол Улсын хувьд экспортоо нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Үүний үр дүнд 2020 оны 4 дүгээр сар гэхэд экспортын хэмжээ аль аль нь өмнөх 4 жилийн хамгийн өндөр түвшиндээ хүрсэн. Гэсэн хэдий ч Монгол Улсын нийт экспортод эзлэх хувийн жингээр нь авч үзвэл өмнөх 2018 оны 4 болон 2019 оны 1 дүгээр улирлын хувийн жинд хүрээгүй байна.


Зураг 2.11. Монгол Улсын нийт экспортод эзлэх Оюу Толгойн экспортын эзлэх хувь



Эх үүсвэр: ҮСХ, Оюу Толгой ХХК

Монгол Улсын нийт экспортод Оюу Толгойн экспортын эзлэх хувийг 4 жилийн дунджаар аваад үзэхэд 15.4 хувь байгаа бөгөөд 2018 оны 4 дүгээр улиралд хамгийн өндөр түвшиндөө буюу 20.4 хувьд, 2019 оны 3 дугаар улиралд хамгийн бага түвшиндөө буюу 10.4 хувьд тус тус хүрч байжээ.

Зураг 2.12. Монгол Улсын нийт экспортын өөрчлөлт ба ОТ-н экспортын өөрчлөлт /улирлаар/



Эх үүсвэр: ҮСХ, Оюу Толгой ХХК

Экспортын өөрчлөлтийг аваад үзвэл Монгол Улсын хувьд жил болгоны хоёрдугаар улиралд хамгийн өндөр байна. Оюу Толгойн хувьд өөрчлөлт харьцангуй жигд байдаг.

Монгол Улсын экспорт болон Оюу Толгойн экспортын хоорондын урт хугацааны хамаарал байгаа эсэхийг коинтеграцийн шалгуурыг ашиглан тодорхойлж үзлээ. Хоёр хувьсагчийн хувьд тогтвортой бус бөгөөд эрэмбийн ялгавар авч тогтвортой болж байна.

Шинжилгээний үр дүнгээс харвал урт хугацааны тогтвортой хамаарал байхгүй. Богино хугацааны хамаарал хоёр хувьсагчийн хувьд тодорхойлогдож байгаа бөгөөд богино хугацаанд Оюу Толгойн экспорт 1 нэгж хувиар өөрчлөгдөхөд Монгол Улсын экспорт дунджаар 0.47 нэгж хувиар өөрчлөгдөж байна. Коэффициентын хувьд 5 хувийн түвшинд статистик ач холбогдолтой гарсан. Гранжерийн учир шалтгааны шалгуураар шалгаж үзэхэд Оюу Толгойн экспорт нь богино хугацаанд Монгол Улсын экспортод нөлөөлдөг бөгөөд эсрэгээрээ Монгол Улсын экспортын өөрчлөлт нь Оюу Толгойн экспортын өөрчлөлтөд нөлөөгүй гэж гарлаа.

Бүлгийн дүгнэлт

Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур болсон уул уурхайн салбарт гарч буй өөрчлөлт нь Монгол Улсын ДНБ-ий өсөлт, улсын төсвийн орлого, экспорт, ГШХО, ажиллах хүч зэрэг макро эдийн засгийн өөрчлөлтөд голлох нөлөөг үзүүлсээр иржээ.

Уул уурхайн салбар нь 2011-2020 оны хооронд Монгол Улсын ДНБ-ий 21.7 хувь, уг салбарт хийгдэж буй гадаад шууд хөрөнгө оруулалт нь дээрх хугацаанд нийт гадаад шууд хөрөнгө оруулалтын 73.4 хувийг эзэлж байна.

Дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ГШХО, ДНБ болон уул уурхайн салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлсөн.

Оюу Толгойн Монгол улсад төлсөн төлбөр, татвар хураамж жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд хэдийгээр 2020 оны хоёрдугаар улиралд өмнөх улирлуудтай харьцуулахад буурсан боловч 4 дүгээр улиралд төлсөн дүн нь түүхэн дээд амжилтыг тогтоожээ.

Монгол Улсын ДНБ болон Оюу Толгойн Монгол Улсад төлсөн татвар, төлбөр, хураамжийн хооронд урт хугацааны тогтвортой хамааралтай байна. Үүнийг тоон шинжилгээний утгаар илэрхийлбэл урт хугацаанд Оюу Толгойн төлсөн төлбөр хураамжийн хэмжээ 1 хувиар нэмэгдэхэд тухайн улирлын Монгол Улсын ДНБ-ийг дунджаар 0.52 хувиар нэмэгдүүлж байна.

Төсвийн орлогын тухайд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын төсвийн орлого 2019 оны 4 дүгээр улирлаас 2020 оны 2 дугаар улирлуудад буурсан Оюу Толгойн Монгол улсад төлсөн төлбөр хураамжийн бууралттай адил динамиктай байна. Энэ төсвийн орлогын бууралт болон Оюу Толгойн төлбөрийн өсөлт аль аль нь 3 дугаар улирлаас нэмэгджээ.

Оюу Толгойн төлсөн төлбөр хураамжийн хэмжээ 1 хувиар нэмэгдэхэд Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого дунджаар 0.81 хувиар нэмэгдэж байна гэсэн урт хугацааны тогтвортой хамаарлыг илэрхийлсэн.

Төсвийн орлого нь томоохон уул уурхайн компаниудын экспортын хэмжээтэй нягт холбоотой байдаг. Энэ утгаараа уул уурхайн салбарын тэр дундаа Оюу Толгойн экспорт нь дээр дурдсан хугацаанд бууралттай байсан нь төлбөр хураамжийн хэмжээ бага байх үүнээс үүдэлтэй төсвийн орлого бага байхад хүргэсэн гэж үзэж байна.

Оюу Толгойн хувьд экспортын хэмжээ 2020 оны 1 дүгээр улиралд хамгийн бага дүн буюу 130.66 сая долларын экспорт хийсэн бол 2020 оны 4 дүгээр улиралд хамгийн их буюу 405.5 сая долларын экспортыг хийсэн нь Монгол Улсын нийт экспортын хамгийн бага болон хамгийн их экспорт хийсэн үетэй тохирч байна. Үүнийг зурагт үзүүлсэн сүүдэртүүлсэн хэсгээс тодорхой харж болно. Оюу Толгойн улирлын дундаж экспортын хэмжээ 271.45 сая доллар байгаа бол МУ-ын хувьд 1764.7 сая доллар, стандарт хазайлт нь харгалзан 72.51 болон 358.95 байна.

Оюу Толгойн экспорт нь богино хугацаанд Монгол Улсын экспортод нөлөөлдөг бөгөөд эсрэгээрээ Монгол Улсын экспортын өөрчлөлт нь Оюу Толгойн экспортын өөрчлөлтөд нөлөөгүй гэж гарлаа. Богино хугацаанд Оюу Толгойн экспорт 1 нэгж хувиар өөрчлөгдөхөд Монгол Улсын экспорт дунджаар 0.47 нэгж хувиар өөрчлөгдөж байна.

III. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮНДЭСНИЙ БА АЙМГИЙН ХЭМЖЭЭН ДЭХ ТАТВАР БҮРДҮҮЛЭЛТ, НОГДУУЛАЛТ БА КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

3.1. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ҮНДЭСНИЙ ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Монгол Улсын Засгийн газар нь нийгэм рүү чиглэсэн хөтөлбөрүүдийг тасралтгүй, тогтвортой санхүүжүүлэх төдийгүй газарзүйн байршлаарх эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжихээр төсвийн хөрөнгө оруулалтыг сүүлийн жилүүдэд их хурдацтай өрнүүлсэн, цаашид илүү тэлэх хандлагатай болж байна. Өсөн нэмэгдэж буй төсвийн хөрөнгө оруулалтад том татвар төлөгчдийн үзүүлсэн нөлөө их, тэр хэмжээгээр орон нутаг, бүс нутаг, үндэсний хөгжилд ч нөлөөлсөөр байна.

Монгол Улсын төсвийн орлого бүрдүүлэлтэд том татвар төлөгчид их чухал байр суурийг эзэлдэг. Ийм том татвар төлөгчид нь гол төлөв уул уурхайн салбарт хамаарч байна. Уул уурхайн салбарт хэрэглэж буй татварын арга хэрэгслүүд нь тогтмол төлбөр, нэгжид ноогдуулах татвар, ашигт ноогдуулах татвараас²³ бүрдэж байгаа.

ОТ ХХК бол Монгол Улсын том татвар төлөгчдийн нэг. Түүний төсвийн орлого бүрдүүлэлтэд үзүүлэх нөлөө өсөн нэмэгдэж байна. Өнөөгийн нөхцөлд хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд ОТ компани нь:

- ААНОАТ нь татвар ноогдох орлогын 25 хувь,
- Алдагдлыг дараагийн 8 жил хүртэлх жилээр шилжүүлэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцно.
- АМНАТ буюу роялти нь нийт орлогын 5 хувь, татвар ногдох орлогоос хасагдана.
- НӨАТ нь импортлосон, боловсруулсан, худалдсан бараа, гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд 10 хувь,
- Суутган татвар, зээлийн хүү, баталгааны төлбөр, роялтийн орлого, санхүүгийн түрээсийн орлого, удирдлагын зардал болон менежментийн үйлчилгээний төлбөр, түрээсийн төлбөр 20 хувь,
- Бусад татварын хувьд ноогдол ашиг, роялтигийн хүүгийн орлогод 10 хувь, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод 2 хувь, эрх шилжүүлсэн орлогод 3 хувийг тус тус төлдөг.

Зэсийн АМНАТ-ын тухайд жишиг үнээр тооцсон борлуулалтын үнийн дүнгийн 5 хувь²⁴, хэрвээ зах зээлийн жишиг үнэ 5000 ам.доллараас давбал зэсийн хүдрийн тн тутамд нэмэлт 22-30 хувийн АМНАТ (1000 ам.дол-ын нэмэгдэл тутамд нэмэлт 2 хувь), зэсийн баяжмалын тн тутамд 11-15 хувийн нэмэгдэл АМНАТ, зэсийн эцсийн бүтээгдэхүүний хувьд тн тутамд 1-5 хувийн татвар төлөх зохицуулалттай.

Оюу Толгой бол Монгол Улсын ДНБ-ий өсөлтийг хангахад чухал нөлөөтэй байгаагаас гадна төсвийн орлого бүрдүүлэлтийг тогтвортой хадгалж, нийгмийн хөгжлийн хөтөлбөрүүдийг тасралтгүй хэрэгжүүлэх нөөцийг хуримтлуулахад чухал ач холбогдолтой. Монгол Улсын ДНБ 2013-2014 онд 14.9 болон 15.9 хувь, 2017-2019 онуудад 16.4, 16.3, 15.0 хувийн өсөлттэй байсан ч Ковид-19 цар тахлын нөлөөгөөр буурсан.


ОТ компани нь 2012-2020 оны хооронд улсын төсөвт 8.5 их наяд төгрөгийн татвар төлж, жил бүрийн

23 Тогтмол төлбөр - төслийн хэмжээ, үр ашиг, үйлдвэрлэлийн үнэ, тоо хэмжээнээс үл хамааран тогтмол байна: лиценз, гэрээний урамшуулал; нэгжид ноогдуулах татвар – бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалд суурилна: АМНАТ, импортын тариф, НӨАТ, газрын түрээс, хөрөнгийн татвар гэх мэт; ашигт ноогдуулах татвар – бүх төрлийн зардлыг хассан орлогын тодорхой хувьд суурилна: ашгийн татвар, ноогдол ашиг, ашгийн хувь, бүтээгдэхүүн хуваах гэрээ, нөөцийн түрээсийн татвар, гэнэтийн ашгийн татвар гэх мэт.

24 Тоо хэмжээнд үндэслэсэн роялти оногдуулбал энэ нь биет хэмжээнд (хэмжээ, жин, тонн тутамд ногдох ам.дол, куб метр тутамд ногдох ам.дол) тулгуурлана. Үйлдвэрлэлийн өртөгт үндэслэн роялтийг хуулиар тогтоож болно. Роялти тогтмол байгааг хуулиар зохицуулна, инфляци, эрсдийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөд прогрессив тохируулга хийхэд тустай, мөн роялти орлого тогтвортой байхад захиргааны хувьд үр ашигтай байхаас гадна аудит хийхэд илүү хялбар байна.

төсвийн татварын орлогын 7.25-13.51 хувийг бүрдүүлдэг байжээ. 2013 онд хамгийн доогуур буюу 7.25 хувийг бүрдүүлж байсан бол 2015 онд хамгийн өндөр хувь болох 13.51 хувийг бүрдүүлсэн. Ковид-19 цар тахлаас өмнөх 8 жилд буюу 2012-2019 оныг хүртэл нэг жилийн улсын төсвийн татварын орлогын 9.51 хувийг бүрдүүлж байжээ.

Зураг 3.1. Улсын төсвийн татварын орлого болон ОТ компанийн төлсөн татвар, 2010-2020




Эх сурвалж: ҮСХ, ТЕГ, ОТ ХХК, 2021

Ковид-19 цар тахлын өмнөх 2019 онд улсын төсвийн татварын орлого хамгийн өндөр буюу 9.75 их наяд төгрөг, ОТ компанийн төлсөн нийт татварын дүн 855.34 тэрбум болж, төсвийн орлогын 8.77 хувийг бүрдүүлсэн. Харин цар тахлын үе 2020 онд улсын төсвийн орлого 8.5 их наяд төгрөг болж өмнөх оноос буурсан үед ОТ компанийн төлсөн татварын хэмжээ 826.08 тэрбум болж багассан ч улсын төсвийн орлогын 9.72 хувийг бүрдүүлсэн. Хэдийгээр өмнөх оныхоос буурсан дүн хэдий ч улсын төсвийн татварын орлого нь 2019 оныхоос 13 орчим хувиар буурсан байхад ОТ компанийн төлсөн татварын орлого дөнгөж 3.4 хувиар буурсан байгаагаас харахад, Ковид-19 цар тахлын үеийн төсвийн тогтвортой байдлыг хангахад ОТ компани гол үүрэгтэй оролцжээ. Ковид-19 цар тахлаас өмнөх жилүүдэд төсөвт төлсөн татвар болон нийт татварын тренд ижил байгаа нь үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж байсантай холбоотой. Харин цар тахлын үед буюу 2020 онд олборлолт буурсантай холбоотойгоор улсын төсөвт төлсөн татварын хэмжээ багассан бол харин орон нутагт төлдөг бусад ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой татварын хэмжээ буураагүй тул нийт татварын хэмжээ өссөн хандлагатай гарсан. Цар тахлын өмнөх жилийнхээс улсын төсвийн татварын орлогод эзлэх хувь нь 0.95 пунктээр илүү байна.

Уул уурхайн салбарын татварын хэлбэр олон янз²⁵ байдаг ч ОТ-н хувьд тогтмол төлбөр болон нэгжид ноогдуулах татварыг хэрэглэж байна. Зэсийн борлуулалтаас тогтмол төлбөр төлж байгаа тул зэсийн үнийн үзүүлэх нөлөөг Ковид-19 цар тахлын өмнөх үеэр харья. 2016-2020 оны хоорондох зэсийн үнэ, борлуулалт, төлсөн АМНАТ-ын өөрчлөлтийг харуулахдаа 2015 оноор зэрэгцүүлсэн индексийг ашигласан.

25 Уул уурхайн татварын хэлбэр (Pietro Guj, 2005): тоо хэмжээнд үндэслэсэн роялти: ийм татвар нь биет тулгуурладаг, жишээлбэл, хэмжээ, жин, нэгжид ноогдох ам.дол, куб метрт ноогдох ам.дол (1); ad valorem royalties – үйлдвэрлэлийн өртөгт үндэслэнэ (2); ашигт үндэслэсэн роялти буюу ашгийг тооцоолж, ноогдуулах татвар (3); эдийн засгийн рент – эдийн засгийн ашгийг шууд хэмжиж татвар ноогдуулна (4); хайбрид татвар ноогдуулалт – ашиг ба рентыг хослуулсан роялти (5); бусад арга – янз бүрийн татварын суурийг авч үзнэ, жишээлбэл, бүтээгдэхүүн хуваах гэрээ (6)


Зураг 3.2. АМНАТ, зэсийн үнэ, борлуулсан тоо хэмжээ, нийт дүнгээр, ХҮИ-ээр засварласан, 2015=100



Эх сурвалж: ТЕГ, ОТ ХХК, 2021

2016 онд АМНАТ-ын орлогын 35.1 хувийн өсөлтөд үнэ 26.5 хувийн нөлөө үзүүлсэн бол зэсийн борлуулалт 5.6 хувийн нөлөөтэй байжээ. 2017 онд ОТ компанийн төлсөн АМНАТ-ын хэмжээ 42.3 хувиар өсөхөд зэсийн үнэ 37.5 хувь, борлуулалт 4.8 хувийн нөлөөтэй байжээ. 2018 онд ОТ компанийн төлсөн АМНАТ 11 хувиар буурсан бөгөөд энэ онд зэсийн борлуулалт нь 0.6 хувиар өссөн ч зэсийн үнэ 11.3 хувиар буурсан нь АМНАТ-ын төлөлт буурахад нөлөөлжээ. 2019 онд зэсийн АМНАТ-ын орлого 22.4 хувиар өссөн бөгөөд зэсийн үнэ нь 25.7 хувиар өсөх, харин зэсийн борлуулалт 0.6 хувиар буурах нөлөө үзүүлсэн. Эндээс харахад, зэсийн АМНАТ-т дэлхийн зэсийн зах зээлийн үнийн үзүүлэх нөлөө их байна.

Зураг 3.3. ОТ компанийн төлсөн АМНАТ, зэсийн үнэ, борлуулсан тоо хэмжээ, нийт дүнгээр, ХҮИ-ээр засварласан, 2015=100




Эх сурвалж: ТЕГ, ОТ ХХК, 2021

Ковид-19 цар тахлын үед ОТ компанийн зэсийн борлуулалтад өөрчлөлт ороогүй, 2019 онтой харьцуулахад зэсийн борлуулалт нь 10.6 хувиар өссөн. Борлуулалтын өсөлтөд зэсийн үнэ 9.2 хувь, харин тоо хэмжээ нь 1.3 хувийн өсөх нөлөө үзүүлжээ. Борлуулалтад зэсийн үнийн үзүүлэх нөлөө өндөр байсан.

Ковид-19 цар тахлын үед уул уурхайн салбар, тэр дотроос зэсийн салбарын төсвийн орлого бүрдүүлэлтэд үзүүлэх нөлөөг авч үзвэл, 2020 оны туршид АМНАТ-ын төлөлтийн хэмжээ эхний хагаст буурсан ч сүүлийн хагас жилд эргээд өссөн.


Зураг 3.4. 0-1 ОТ ба Эрдэнэтийн Ковид-19 цар тахлын үед (2020) төлсөн АМНАТ-ын өсөлтийн хувь, сараар



Эх сурвалж: ТЕГ, ОТ ХХК, 2021

2020 онд зэсийн хоёр том компанийн АМНАТ-ын төлөлтийг Ковид-19 цар тахлын өмнөх 2019 онтой харьцуулж, өсөлтийн хувийг сараар тооцож үзэхэд, ОТ-н 2020 онд төлсөн АМНАТ нь 2020 оны 9 дүгээр сард хамгийн өндөр өсөлттэй байжээ. 2020 онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан хил хаах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ОТ-н зэсийн баяжмалын экспорт буурах хандлага ажиглагдсан ч төлсөн АМНАТ-ын хэмжээ жилийн туршид багасаагүй байна. 2020 оны 8 дугаар сараас хойш зэсийн АМНАТ-ын төлөлтөөрөө Эрдэнэтээс илүү байжээ. Зэсийн АМНАТ-ын төлөлт буураагүй нь Ковид-19 цар тахлын үед Монгол Улсын төсвийн орлогыг тасралтгүй бүрдүүлсэн.


Зураг 3.5. ОТ-н төлсөн НДШ ба Монгол Улсын ДНБ



Эх сурвалж: ҮСХ, ОТ ХХК

Ковид-19 цар тахлын үед ОТ-н төлсөн НДШ өндөр өсөлттэй байсан. 2020 онд 83,451.7 сая төгрөгийн шимтгэл төлсөн нь 2019 онтой харьцуулахад 26.1 хувиар өсөлт үзүүлэлт юм. Монгол Улсын ДНБ 2020 онд бууралттай байсан хэдий ч НДШ-ийн хувьд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр НДШ-ийн төлөлт буураагүй байна. 2020 онд Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахалтай холбоотойгоор НДШ-ийн хүрээнд зохицуулалтын олон арга хэмжээг авч хэрэгжүүлсний нэг нь НДШ-ийн төлөлтийн хувийг бууруулсан зохицуулалт байлаа.

Зураг 3.6. ОТ компанийн төлсөн НДШ ба Улсын НДШ-ийн орлого



Эх сурвалж: УСХ, ОТ ХХК


Улсын НДШ-ийн орлого 2020/2019 онтой харьцуулахад өссөн ч аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх нөлөөллийн хүрээ өргөн байсан. Ажлын цагийг дийлэнх нь хорогдуулсан ч уул уурхайн компаниудад үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэвийн горимыг хангахын тулд өвөрмөц зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүрсэн.

3.2. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ОРОН НУТГИЙН ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Монгол Улсад гуравдагч хөршийн хөрөнгө оруулалттай мега төсөл хэрэгжсэнээс хойшхи хугацаанд үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн төсвийн бүрдүүлэлт, татвар хураалтыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж буй төсөл бол Оюу Толгой юм.

ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээ хэрэгжиж эхэлснээс хойш Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн бүрдүүлэлт сайжирч, байгаль, эдийн засаг, нийгмийн хөгжлийн хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх сан бүрдсэн гэж үзэж болно. Энэ хэрээр аймгийн хөгжлийн үзүүлэлт дээшилж, аймгийн захиргаа, татварын хэлтэс болон ОТ компанийн хамтын ажиллагаа нь уул уурхайн салбарын татварын глобал орчинд гарч буй өөрчлөлтийг харуулах бодит жишээ болох юм.

Зураг 3.7. ОТ-н Өмнөговь аймагт төлсөн татвар, төлбөр




Эх сурвалж: ОТ ХХК, Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс

2011-2020 онд төлсөн гол гол татвар, төлбөрөөс харахад, ОТ нь орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн хувьд хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, ус ашигласны төлбөр гэх зэрэг татвар, төлбөрийг илүү төлөх байдалтай. 2019 онтой харьцуулахад 2020 онд Өмнөговь аймгийн ДНБ 191700.7 сая төгрөгөөр буурсан ч татвар төлөлтийн хэмжээ харьцангуй тогтвортой байсан.

ОТ компани нь 2010-2020 оны хооронд Өмнөговь аймагт нийтдээ 656227.63 сая төгрөгийн татварын орлого оруулсан нь Ковид-19 цар тахлын өмнөх жилийн буюу 2019 оны аймгийн ДНБ-ийх нь 80 хувьтай тэнцэхээр байна. Татвар төлөлтийн явцыг аймгийн ДНБ-тэй нь харьцуулан харвал цар тахлын өмнөх жилд ОТ компанийн төлсөн татварын хэмжээ болон ДНБ-ий тренд нь давхцаж гарсан. 2019 онд Өмнөговь аймаг нь сүүлийн 10 жилийн хугацаан дахь хамгийн өндөр ДНБ-ий хэмжээнд хүрсэн. Энэ хэрээр татвар төлөлтийн хэмжээнд ч өөрчлөлт орсон бөгөөд ОТ төслийн зогсонги үед татвар төлөлт өндөр байжээ. 2020 оны цар тахлын үед авч хэрэгжүүлсэн хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор аймгийн ДНБ эрс буурах төлөвтэйгөөр үнэлэгдсэн хэдий ч ОТ компанийн татвар төлөлт буураагүй байна.

Уул уурхайн салбар төвлөрсөн аймагт аж үйлдвэрийн салбарын хэлбэлзэл янз бүрийн нөлөөтэй байна. Салбарын хөгжлийн төрөлжилтийн талаар дараагийн бүлэгт авч үзнэ. ОТ-н Өмнөговь аймагт төлсөн нийт татвар, төлбөрийн динамик хэмжээг харахад сүүлийн 10 жилд өсөх трендтэй байна. Ковид-19 цар тахлын үед ОТ-н Өмнөговь аймагт төлсөн нийт татвар, төлбөрийн хэмжээ буураагүй.

Зураг 3.8. ОТ компанийн Өмнөговь аймагт төлсөн гол гол татвар, төлбөр (мян.төг) 2011-2020




Эх сурвалж: ОТ ХХК, 2021

Сүүлийн 10 жилийн хугацаанд Өмнөговь аймгийн хэмжээнд ХХОАТ-ын төлөгдсөн хэмжээ эрс өсөж, 2011 онтой харьцуулахад 2020 онд бараг 7 дахин нэмэгдсэн. Энэ хэрээр орон нутагт эдийн засгийн үйл ажиллагаа бэхжиж байна.

Ковид-19 цар тахлын үед хувь хүний орлогын албан татвар ба үл хөдлөх хөрөнгийн татварын төлөлтийн хэмжээ буураагүй, харин ус ашигласны төлбөр бага зэрэг буурсан. ОТ-н Өмнөговь аймагт төлсөн нийт татвар, төлбөрийн хэмжээ Ковид-19 цар тахлын үед 2020 оныг 2019 онтой харьцуулахад 2.32 хувиар нэмэгдсэн. Эндээс харахад, цар тахлын үед Өмнөговь аймгийн эдийн засгийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж байна.

Зураг 3.9. Ковид-19 цар тахлын үед ОТ компанийн Өмнөговь аймагт төлсөн татвар, төлбөр 2019-2020




Эх сурвалж: ОТ ХХК, Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс, 2021

ОТ-н Өмнөговь аймаг болон Ханбогд суманд төлсөн гол нэр төрлийн төлбөр, татварын сүүлийн 10 жилийн хуримтлагдсан дүнгээс харахад, Өмнөговь аймгийн татварын суурийг хуримтлагдсан дүнгээр харвал, хүний орлогын албан татвар (1), үл хөдлөх хөрөнгийн татвар (2), ус ашигласны төлбөр (3) голлон нөлөөлсөн бол Ханбогд сумын татварын суурьд ус ашигласны төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар (2), газрын төлбөр (3) нөлөөтэй байжээ. Ковид-19 цар тахлын үед ОТ компанийн Өмнөговь аймагт төлсөн ХХОАТ болон үл хөдлөх хөрөнгийн татварын хэмжээ өссөн, харин ус ашиглалтын төлбөр бага зэрэг буурсан. Бусад татвар, төлбөрийн хэмжээ ч 2019 онтой харьцуулахад 2020 онд бууралттай байжээ. Голлох татвар, төлбөрийн хэмжээ буураагүйгээс харахад, ОТ компанийн төлсөн татвар, төлбөр нь Өмнөговь аймгийн төсвийн орлого бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлсэн.

ОТ-н нөлөөгөөр аймаг дотор сумдын, тухайлбал, Ханбогд сумын төсвийн орлогын бүрдүүлэлт сайжирсан. Ханбогд сумын төсвийн орлогын бүрдүүлэлтэд ОТ компанийн ус ашигласны төлбөр зонхилох хувийг эзэлдэг. Сүүлийн 10 жилийн хугацаанд Ханбогд суманд үл хөдлөх хөрөнгийн хэмжээ өсөж, тэр хэмжээгээр үл хөдлөх хөрөнгийн татварын хэмжээ хуримтлагдсан дүнгээрээ нэмэгдсэн.

Зураг 3.10. Өмнөговь аймаг болон Ханбогд сумын гол нэр төрлийн татварын хуримтлагдсан нөлөө, төлбөр (мян.төг) 2010-2020




Эх сурвалж: ОТ ХХК, Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс, 2021

Сүүлийн 10 жилийн хугацаанд Ханбогд сумын төсвийн орлого бүрдүүлэлтэд ус ашигласны төлбөр өндөр хувь эзэлж байгаа хэмжээгээрээ аймгийн төсвийн орлогод 61.8 хувийн хувь нэмэр оруулсан.

Түүнчлэн сүүлийн 10 жилийн хугацаанд Ханбогд сум нь аймгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн 1/5-ийг үл хөдлөх хөрөнгийн татвараар оруулсан.

Ковид-19 цар тахал нь Ханбогд сумын төсвийн орлого бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлсэн. 2019 онтой харьцуулахад ТТАМ ашигласны төлбөрөөс бусад татвар, төлбөр бүгд буурсан.


Зураг 3.11. ОТ компанийн Ханбогд суманд төлсөн татвар, төлбөр, төрлөөр (мян.төг)



Эх сурвалж: ОТ ХХК, Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс, 2021

2019 онтой харьцуулахад 2020 онд ОТ компанийн төлсөн ТТАМ ашигласны төлбөр нь Ханбогд сумын төсвийн нийт орлогод бусад татвар, төлбөрийг бодвол 26 хувиар өсөх нөлөө үзүүлсэн. Харин ХХОАТ нь 9.8 хувь, ус ашигласны төлбөр 0.1 хувь, бусад төлбөр нь 16.2 хувиар нийт төсөвт эзлэх хувь нь тус тус буурчээ.

Зураг 3.12. Өмнөговь аймгийн Ханбогд болон Булган сумын татварын бүтэц, өөрчлөлт, 2010-2020



Эх сурвалж: ОТ ХХК, Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс, 2021

Сумын эдийн засгийн үйл ажиллагаа харьцангуй хязгаарлагдмал боловч ОТ-н үйл ажиллагааны нөлөөгөөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын төсвийн орлогын бүрдүүлэлтэд сүүлийн 10 жилийн хугацаанд газрын төлбөр, усны төлбөр, ТТАМ ашигласны төлбөрийн эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн.

Уул уурхайгүй Өмнөговь аймгийн Булган сумын төсвийн орлогыг бүрдүүлэхэд ХХОАТ, өмчийн албан татвар, бусад төлбөр хураамжаас бүрдэж байна. Эндээс харахад, татварын суурь ялгаатай байгаагаас гадна татан төвлөрүүлж буй хэмжээний ялгаа их байна.

3.3. ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ТАТВАРТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Зэсийн салбар нь эдийн засгийн хөгжилд гол нөлөөтэй болохынхоо хувьд улс орныхоо хөгжил цэцэглэлтэд хоёр гол үүргийг хүлээж байдаг.

1. Улсын төсөвт орлого бүрдүүлж, түүгээр нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тэнцвэртэй байдлыг ханган, хүн ам болон нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ.
2. Зэсийн салбарын үйлдвэрлэл, борлуулалт, өсөлтийн үр дүнд эдийн засгийн бусад салбаруудын тэлэлт, өргөжилт явагддаг.

Төсвийн орлого бүрдүүлэлт нь улс орнуудын хөгжлийн суурь нөхцөл, хүрсэн түвшнээс хамааран харилцан адилгүй зохицуулалттай байдаг.

Олон улсад хийгдсэн судалгааны гол үр дүнгээс харахад: "... засгийн газар, татварын байгууллагууд нь том татвар төлөгчид болон татварын зуучлагчидтай харьцахдаа: нэгдүгээрт, арилжааны үндсэн дээр харилцан ойлголцох; хоёрдугаарт, шударга бус байдал гаргахгүй байх; гуравдугаарт, пропорциональ байх; дөрөвдүгээрт, нээлттэй байх; тавдугаарт, хариуцлагатай байх гэсэн нийтлэг зарчмыг баримтлахад илүү үр өгөөжтэй, илүү үр дүнтэй харилцаанд хүрнэ. Эдгээр зарчим нь том татвар төлөгчидтэй хийх бүх харилцааны үндэс суурь байж, эрсдэлийн менежментийн үр дүнтэй процессыг хэрэгжүүлж байгаа бол томоохон аж ахуйн нэгжийн татвар төлөгчдөд хамтын ажиллагаа, итгэлцэлд суурилсан харилцаанд орох магадлал өндөр байна" гэжээ. Ийм харилцаа цар тахлын дараах хэвийн нөхцөл байдал руу шилжихэд ч хэвээр хадгалагдах байх.

Олон улсын байгууллагуудын уул уурхайн салбарын татвар ногдуулалтын талаарх зөвлөмжөөр, роялтийн түвшин өрсөлдөөнтэй, үр ашигтай байхыг²⁶ санал болгож байгаа. Энэ нь олон улсын татвар хураалт, ногдуулалтын институцийн орчин хийгээд бизнесийн орчны хурдтай өөрчлөлтийг танин мэдэхүйд чухал нөлөөтэй. Роялтид суурилсан урамшууллыг ашиглахдаа: ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тодорхой хугацаагаар бууруулж (хасах), роялти төлбөрийг хойшлуулах хугацааг сунгах (ихэвчлэн гурван сараас илүүгүй), борлуулалт, үйлдвэрлэл, үнэ эсвэл өртгөөс хамааран хувь хэмжээ харилцан адилгүй байх гэх зэрэг зохицуулалтыг хэрэглэж байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бүрэн чөлөөлөх нь ерөнхийдөө ховор байдаг (Hartley & Otto, 2008). Борлуулалтын орлогод суурилсан роялти бол АМНАТ-ын хамгийн түгээмэл хэлбэр, олон улсын жишиг үнийг баримтлах нь хялбар, компаниуд нөхөн сэргээгдэхгүй нөөц олборлосныхоо төлөө улсын, эсвэл орон нутгийн төсөвт нэмэлт төлбөр төлж байгаа юм. Тухайлбал, Чили, Грийнланд, Мексик, Швед, Зимбабве, АНУ-ын Невада, Аризона гэх зэрэг улс орон болон газар нутагт роялти ноогдуулдаггүй. Лаост борлуулалтын нийт орлогын 1-7 хувь, Австралид борлуулалтын нийт орлогод: хүдэр – 7.5 хувь, баяжмал – 5 хувь, металл – 2.5 хувийг тус тус ноогдуулдаг. Харин зарим оронд АМНАТ-ын өөр бусад хэлбэрийг ашиглаж байна. Канадын Саскатчеванд цэвэр ашигт 5 хувь, Чилид цэвэр ашигт 5-14 хувь, Перуд цэвэр ашигт 1-6.28 хувийг ноогдуулж байна.

Зэсийн салбарт засгийн газрууд татвар оногдуулахдаа олон арга хэлбэрийг ашиглаж байгаагаас экспертүүд: "... элэгдлийн түргэвчилсэн схем, хөрөнгө оруулалтын тэтгэмж", "зардалд суурилсан урамшуулалд хамаарах хөрөнгө оруулалтын зардлыг тодорхой болгох, ... тэтгэмж авах боломжтой уул уурхайн зардлын төрлүүд, эдгээр зардлыг ирээдүйн жилүүдэд, хэр удаан үргэлжлүүлэх боломжтой эсэхийг тодорхой зааж өгөх шаардлагатай" гэдгийг санал болгох нь илүү үр дүнтэй арга байж болох юм гэсэн.

Хэрвээ өөрчлөлт зайлшгүй бол хүлээцтэй, шилжилтийн хугацаатай, гол олборлогч, үйлдвэрлэгчидтэй зөвшилцсөн, баялгийн аливаа эрсдэлээс зайлсхийх рүү хандах нь уул уурхайн татварын хэрэгжилтийг ойлгомжтой, тогтвортой байхад нөлөө үзүүлэхээр байна. Татварын урамшуулал нь дангаараа хөрөнгө оруулалт татахгүй, уул уурхайн салбарын татварын урамшууллын үр ашиг, үр ашгийг тооцохгүйгээр гарах зардал, үр ашгийг тооцоогүй үед болзошгүй, төлөвлөгдөөгүй орлогод үндэслэсэн нөхцөлд татварын урамшууллын хяналт бүрэн хийгддэггүй байна.

Уул уурхайн салбарт татварын үр ашигтай түвшинг тогтоох, татварын оновчтой хослолыг гаргах, татварын төрөл нь онцлог, эсвэл онцгой байх, эрсдэлийн улмаас татварын дараах зохицуулалт нийцтэй байх гэх зэрэг нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй татварын дэглэмийг тогтворжуулахад чиглэдэг. Татварын орлогын хуваарилалт, ашиглалтын хувьд уул уурхайд түшиглэсэн хөгжлийн хандлага нь эхлээд үндэсний хэмжээнд илүү анхаарч байсан бол одоо бүс нутаг, орон нутгийн хөгжил рүү илүү анхаарал хандуулах болсон. Тиймээс татварын тогтолцоог илүү дэвшилтэт төсвийн бодлоготой уялдуулан хуваарилалтын бодлогын шалгуур үзүүлэлтүүдийн²⁷ дагуу шинэчлэхийг санал болгодог. Энэ нь нэг талаас, өрсөлдөхүйц татварын бодлоготой байхыг санал болгож байгаа хэрэг; нөгөө талаас, ялгаатай эрдсийн бүтээгдэхүүн ялгаатай роялти/татварын хувийг хэрэглэх, өртгийн сүлжээний хөрөнгө оруулалтын дараа янз бүрийн эрдсийн бүтээгдэхүүнийг борлуулж байгаагаас үүдэн өртөг нэмсэн бүтээгдэхүүний роялти/татварын өөрчлөлтийн хувийг бууруулах, пропорциональ, дэвшилтэт шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд торгууль ноогдуулах, татварын хууль, дүрэм зохицуулалтад үл нийцэл үүсвэл үүнийг ашиглан татвараас зайлсхийхийг хязгаарлах, ашиг орлогыг зохиомлоор бага буюу татваргүй байршилд шилжүүлэх стратеги гэх зэрэг асуудлыг нухацтай авч үзэхэд чиглэх юм.

Өсөлт рүү чиглэсэн татварын дэглэм, горим нь зах зээлээс хүлээн авах аливаа өөрчлөлтийг аль болох бага түвшинд байлгах, аж ахуйн нэгжүүдийн нийлүүлэлт, хөрөнгө оруулалтын үр чадварыг дэмжиж байх учиртай. Гэсэн хэдий ч засгийн газруудын өмнө ГШХО хийж буй компаниудад дотоодын компаниудаас бага татварын түвшин тогтоох уу үгүй юу гэсэн хэцүүхэн сонголт тулгарсан хэвээр л байна.

Засгийн газар, татварын байгууллага нь уул уурхайн компаниудын арилжаагаа удирдах байдлыг дутуу авч үзвэл үйл ажиллагаа, эсвэл гүйлгээний илүү өргөн хүрээг буруу ойлгож, өртөг өндөртэй маргаан, тодорхойгүй байдалд хүргэх хариу арга хэмжээг авахад хүргэж болзошгүй байдаг. Ийм өөрчлөлт нь татварын хууль, нягтлан бодох бүртгэлийн стандарт мэдлэгээс хавьгүй илүү их зүйлийг шаарддаг. Глобал бизнесийн орчинд, үндэстэн дамнасан компанийн хууль эрх зүй, үйл ажиллагааны бүтэц, олон улсын харилцаа, өмчлөл; түүний эрсдэлийн менежментийн стратеги ба татварын талбар дахь эрсдэл; татварын чиг үүрэг, татварын хяналтын тогтолцоо, татварын шийдвэр гаргах үйл явц; татварын чиг үүрэг ба компанийн бизнесийн нэгжүүдийн хоорондын уялдаа холбоог илүү нарийвчлан авч үзэх болно. Тиймээс аль аль талд шаардлагатай арилжааны мэдлэгийн түвшин ижил байх сорилт тулгарна. Нэгдүгээрт, татвар оногдуулах, хураах байгууллагууд томоохон татвар төлөгчдийн “бизнес эрхлэхүй”-г гүнзгийрүүлэн танин мэдэх хэрэгтэй: компаниудын дотоод, бүс нутгийн болон дэлхийн зах зээлд ажиллаж буй байдал; компаниудын өрсөлдөх стратеги, бизнес төлөвлөлтийн үзэл баримтлал; гадаадын, тухайлбал, Рио Тинто гэсэн олон нийтийн компанийн (public company) санхүүжилт; олон нийтийн компанийн санхүүгийн тайлан, санхүүгийн тодруулга, санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн асуудлууд, эдгээрийн Монгол Улс дахь компаниудын зохицуулалттай харьцуулахад үүсэж буй ялгаа, давуу ба сул тал. Хоёрдугаарт, засгийн газар, татварын байгууллагууд тухайн том татвар төлөгчдийн үйл ажиллагаа явуулдаг салбарын онцлог шинж чанарыг ойлгох хэрэгтэй: салбарын хэмжээний чиг хандлага, хэм хэмжээ; бүтээгдэхүүн ба маркетинг; оюуны өмч; өрсөлдөөн ба зохицуулалт; арилжааны эрсдэл. Гуравдугаарт, засгийн газар, татварын байгууллагууд нь том татвар төлөгчдийн бизнесийн өвөрмөц шинж чанарыг ойлгох хэрэгтэй: салбарын дээр дурдсан асуудлын хэлбэлзэл; компанийн засаглал, түүний менежментийн бүтэц, шийдвэр гаргах үйл явц. Эндээс харвал, уул уурхайн том татвар

төлөгчдийн үйл хөдлөл эдийн засгийн ба эдийн засгийн бус эрсдэл ихтэй байгаа тул олон улсын татвар хураалт, ногдуулалтын эрх зүйн орчин үндэсний татварын эрх зүйн орчинд ихээхэн нөлөө үзүүлэх талтай.

Дэлхийн хөгжиж буй орнууд хөгжлийнхөө туршлагаас харилцан суралцаж байгаа ч татварын зохицуулалтын ялгаатай орчныг харгалзан үзэхээс аргагүй. Сүүлийн 45 жилийн хөгжлийн туршлагаас харахад, жишээлбэл, Чилийн либералчлалын бодлогыг²⁸ хамрах хүрээ, нөөц, чадамж, газарзүйн байршлаарх зах зээлээ тодорхойлсон байдлаар нь хөгжлийн багц бодлого гэж үздэг. Чилийн эдийн засгийн бодлогын шинэчлэл нь улс орныхоо хөгжлийн бараг бүх талыг хамарсан (энд эрдсийн бүтээгдэхүүний үнэ, татвар, худалдаа, валютын ханш, санхүүгийн сектор, хөдөлмөрийн зах зээл, хувьчлал, эрчим хүчний зохицуулалт, нийгмийн хамгаалал багтана), орон нутаг болон бүс нутгийн хөгжилд зохицуулалттай, хамгаалалттай засгийн газрын удирдан чиглүүлсэн орчинтой. Чили нь уул уурхайн салбараас төсвийн орлого бүрдүүлэхдээ борлуулалтын орлогын татвар (ад валорем роялти) бус, ашгийн татварт төвлөрсөн байх жишээтэй, уул уурхайн компаниуд ашгийн татвар төлдөг. Татварын байгууллагад нь улс орны хөгжлийн төлөвлөлтийн хүрээ ойлгомжтой, мөн уул уурхайн компаниудын татварын асуудлын хүрээ тодорхой байжээ. Тиймээс Монгол Улсын хувьд зэсийн салбарын татварын зохицуулалтыг авч үзэхдээ энэхүү ялгаатай байдлыг анзаарахгүй байхын аргагүй.

Үүний зэрэгцээ Монгол Улс бол зэсийн үйлдвэрлэгч орон бус, харин үйлдвэрлэгч орнуудад, тэр дотроос өмнөд хөршийн нэг бэлтгэн нийлүүлэгч юм. Монгол Улсын хөгжилд зэсийн салбарын үзүүлэх нөлөө цар тахлын дараа хэвийн нөхцөл байдал руу шилжсэн ч хэвээр хадгалагдах төлөвтэй. Иймд зэсийн салбарт төвлөрсөн эдийн засгийн хөгжлийн загварыг үндэсний, бүс нутгийн, орон нутгийн түвшинд бусад улс орнуудын хөгжлийн туршлагаас харилцан суралцаж, өөрийн орны хөгжлийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх боломж нээлттэй.

ОТ-н үйл ажиллагаа явагдаад 10 гаруй жил үргэлжилж байгаа ч ашигтай ажиллах түвшинд хүрээгүй, гүний уурхайн бүтээн байгуулалтын үйл явц ид явагдаж байгаа юм. Тиймдээ ч өнөөг хүртэл зэсийн борлуулалтын орлогын татварыг ноогдуулан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газар нь зэсийн АМНАТ-ын татвар хураалт болон ногдуулалтын зохицуулалтын хяналтыг хэвийн үргэлжлүүлж байгаа гэж хэлж болно. Гол нь, Чилийн хөгжлийн туршлагаас харахад, Монгол Улс нь уул уурхай төвлөрсөн аймгийн хөгжлийн бодлогод санхүүгийн сектор, хөдөлмөрийн зах зээл, эрчим хүчний зохицуулалтын бодлогыг цогцоор нь авч үзэж, нотолгоонд суурилсан хөгжлийн загварыг хэрэгжүүлэх боломжтой жишээ юм.

ОТ том татвар төлөгч болохынхоо хувьд хөгжлийн олон талт оролцогсдын (компаниуд, иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн иргэд гэх мэт) татварын бодлогыг дэмжихдээ Монгол Улсын засгийн газрын хариуцлагыг дээшлүүлээд зогсохгүй, татвар бүрдүүлэлт, ногдуулалтыг нийгмийн сайн сайхныг хангах зорилгод илүү ойртуулахад дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд цаашид ч бодитой хэрэгжүүлэхэд эерэг дам нөлөө үзүүлэх талтай.

Ерөнхийдөө, ОТ төсөл хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсын татварын байгууллага нь олон улсын татвар ногдуулалтын талаарх нэгдсэн хандлагад нийцэх чадвараа бэхжүүлэхэд анхаарах болсон. Олон улсын татвар ногдуулалтын хувьсан өөрчлөгдөх орчинд өөрийн орны тогтолцооны асуудалтай талыг ерөнхийлөн тодорхойлж, татварын тогтолцоондоо нийцсэн зохистой, үр нөлөөтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх, тухайлбал, олон улсын татвар ногдуулалттай холбоотой үнэ шилжилт (transfer pricing), төлөөний газар (permanent establishment), татварын хөнгөлөлт, гадаадын охин компаниас авсан ноогдол ашгийг ашигт тооцохгүй байх, гадаад улсад төлсөн татварын дүнг хасалт хийх, хүүгээр ашиг бууруулах нимгэн капиталжихыг авч үзэх, байнгын бус оршин суугчдад татвар ноогдуулах, гадаадын ААНБ-д татвар ноогдуулах, улс дамнасан татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх, олон улсын

28 1975 онд эхэлсэн, 1990 оноос Латин Америкийн хэмжээнд ГШХО-д нөлөө үзүүлсэн.

ажил гүйлгээний гэрээ, татварын гэрээг хянах гээд глобал татварын орчинд суралцах шаардлагатай болсон. Түүнчлэн мега төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш ийм том төслийн макро эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх чадавхиа дээшлүүлж, төсвийн орлогоор дамжуулан үр өгөөж хүртэх, өрсөлдөхүйц татварын түвшинг санал болгоход анхаарал хандуулах болсон. Улмаар олон улсын татвар ногдуулалт болон хураалттай холбоотойгоор татварын удирдлагыг улам бэхжүүлэх сорилттой тулгараад байгаа билээ. Ковид-19 цар тахлын дараа хэвийн нөхцөл байдал руу шилжихэд эдгээр асуудлын хүрээ хэвээр хадгалагдах л болно.

Бүлгийн дүгнэлт

Монгол Улсын зэсийн салбарт олон улсын жишиг татвар, төлбөрийг ноогдуулан хэрэгжүүлж байна.

Зэсийн АМНАТ-ын тухайд жишиг үнээр тооцсон борлуулалтын үнийн дүнгийн 5 хувь байгаа нь бусад хөгжиж буй орнуудын зэсийн салбарт ноогдуулж буй татварын хувьтай ижил түвшинд байгаа тул “өрсөлдөх хийгээд арилжааны үндсэн дээр харилцан ойлголцох түвшинд байна” гэж үзэж болно.

Зэсийн салбарын төсвийн орлогод бүрдүүлэлтэд оруулж буй хувь нэмэр нь өсөх хандлагатай, Ковид-19 цар тахлын үед тогтвортой хадгалагдсан. Монгол Улсын Засгийн газрын нийгэм рүү чиглэсэн хөтөлбөрүүдийг тогтвортой санхүүжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтыг тасралтгүй нэмэгдүүлэхэд том татвар төлөгчдийн үзүүлэх нөлөө их гэдгийг харуулж байна.

ОТ компани нь том татвар төлөгчдийн нэг болохынхоо хувьд Монгол Улсын төсвийн орлого бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлсээр ирсэн. ОТ компани нь 2012-2020 оны хооронд улсын төсөвт 8.5 их наяд төгрөгийн татвар төлсөн нь жил бүрийн төсвийн татварын орлогын 7.25-13.51 хувийг бүрдүүлж байжээ. Ковид-19 цар тахлаас өмнөх 2019 онд 8.75 хувийг бүрдүүлсэн бол 2020 онд 9.72 хувийг бүрдүүлжээ. Цар тахлын өмнөх жилийнхээс улсын төсвийн татварын орлогод эзлэх хувь нь 0.95 пунктээр илүү байна.

2019 онд Монгол Улсын зэсийн АМНАТ-ын орлого 22.4 хувиар өссөн бөгөөд энд зэсийн үнэ 25.7 хувиар өсөх, харин зэсийн борлуулалт 3.3 хувиар буурах нөлөө үзүүлсэн. Ковид-19 цар тахлын үед ОТ компанийн зэсийн борлуулалтад өөрчлөлт ороогүй, 2019 онтой харьцуулахад зэсийн борлуулалт нь 10.6 хувиар өссөн. Борлуулалтын өсөлтөд зэсийн үнэ 9.2 хувь, харин тоо хэмжээ нь 1.3 хувийн өсөх нөлөө үзүүлжээ. Борлуулалтад зэсийн үнийн үзүүлэх нөлөө өндөр байна.

Ковид-19 цар тахлын үед Өмнөговь аймгийн төсвийн орлого нийт дүнгээрээ өөрчлөгдөөгүй нь ОТ-н төлөлттэй шууд холбоотой, аймгийн хэмжээнд хувь хүний орлогын албан татвар ба үл хөдлөх хөрөнгийн татварын төлөлтийн хэмжээ буураагүй, харин ус ашигласны төлбөр бага зэрэг буурсан. ОТ-н Өмнөговь аймагт төлсөн нийт татвар, төлбөрийн хэмжээ Ковид-19 цар тахлын үед буюу 2020 онд 2019 онтой харьцуулахад 2.32 хувиар нэмэгдсэн.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Өмнөговь аймгийн хэмжээнд ХХОАТ-ын төлөгдсөн хэмжээ эрс өсөж, 2011 онтой харьцуулахад 2020 онд бараг 7 дахин нэмэгдсэн.

Ханбогд сумын төсөвт газрын төлбөр, усны төлбөр, ТТАМ ашигласны төлбөр нь зонхилох хувийг бүрдүүлж байна. 2019 онтой харьцуулахад 2020 онд ОТ компанийн төлсөн ТТАМ ашигласны төлбөр нь Ханбогд сумын төсвийн нийт орлогод бусад татвар, төлбөрийг бодвол 26 хувиар өсөх нөлөө үзүүлсэн. Харин ХХОАТ нь 9.8 хувь, ус ашигласны төлбөр 0.1 хувь, бусад төлбөр нь 16.2 хувиар нийт төсөвт эзлэх хувь нь тус тус буурах нөлөөтэй байжээ.

Уул уурхайтай ба уул уурхайгүй сумын төсвийн орлого бүрдүүлэлтийг авч үзвэл, орон нутгийн төсвийн орлогыг цуглуулах, хуваарилах, ашиглах боломж харилцан адилгүй байгаа бөгөөд Өмнөговь аймгийн Ханбогд сум, аймгийн төсвийн уул уурхайгаас хүртэх үр өгөөж их байна.

Цаашдын хандлага

Монгол Улсын зэсийн салбар бол олон улсын туршлагаас суралцаж буй салбар. Энэ салбар Ковид-19 цар тахлын нөлөөг бусад орнуудын нэгэн адил даван туулах сорилттой тулгарсан ч ОТ компанийн Монгол Улсын төсвийн орлого бүрдүүлэлт болон аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөрийн хэмжээ буураагүй, тогтворжих хандлагыг үзүүлсэн. Иймд цар тахлын дараа хэвийн нөхцөл байдал руу шилжихэд эдийн засгийн бусад салбарт эерэг дам нөлөөгөө хадгалсаар байх төлөвтэй.

Гагцхүү уул уурхайн салбарт төвлөрсөн Монгол Улсын хөгжлийн загвар нь олон нийтэд илүү тодорхой, ойлгомжтой, нээлттэй байх нь чухал юм.

Оюу Толгойн гүний уурхайн бүтээн байгуулалт амжилттай хэрэгжихэд уул уурхайн салбарт хэрэглэж буй тогтмол төлбөр болон нэгжид ноогдуулах татварын арга хэрэгслийг өргөтгөж, ашигт ноогдуулах татварыг хэрэглэх боломж хангагдана.

Зэсийн салбарт ноогдуулж буй татвар, төлбөрийн түвшин өрсөлдөөнт түвшиндээ хадгалагдаж, илүү хариуцлагатай байх үйл ажиллагаа руу шилжин төсвийн татварын орлогын бүрдүүлэлтэд эзлэх хувийг бууруулахгүй байх боломжтой.

ОТ-н үйл ажиллагаатай холбоотойгоор олон улсын татварын зохицуулалтаас үндэсний эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн шинэчлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байгаа нь цаашид үргэлжлэх хандлагатай.

Олон нийтийн компанийн татварын эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын үндэсний татварын эрх зүйн шинэчлэлт сорилт авчрах хэдий ч суралцах боломжийг тэлнэ.

IV. ОТ ТӨСЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

4.1. ОТ-Н ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ

Ковид 19 цар тахлын Оюу Толгойн ажиллагсад, тэдгээрийн амьжиргаанд үзүүлж буй нөлөөллийг үнэлэхээр түүвэр судалгааг онлайнаар явуулсан. Судалгаанд ОТ-н үндсэн болон гэрээт компанийн 1720²⁹ ажиллагсад хамрагдсанаас 1718 ажиллагсдын мэдээлэлд үндэслэн боловсруулалтыг хийхдээ SPSS 26 программыг ашиглав.


ОТ-н судалгаанд хамрагдсан ажиллагсдын 80.6 хувь нь эрэгтэй, үлдсэн 19.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Уул уурхайн салбарын хувьд 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт ажиллагсдын 85.1 хувь нь эрэгтэйчүүд бүрдүүлж байна. ОТ-н хувьд уул уурхайн салбарын ажиллах хүчний бүрэлдэхүүнтэй харьцуулахад эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь 4.5 пунктээр их байна. ОТ ажиллагсдын ажилласан дундаж хугацаа 11.4 жил, үүнээс ОТ-д 5.5 жил ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан ажиллагсдын өрхийн гишүүдийн тоо хамгийн багадаа 1, хамгийн ихдээ 9 гишүүнтэй буюу нэг өрх дунджаар 3.95 буюу 4 гишүүнтэй байна. Өрхөд буй хөдөлмөрийн насны гишүүдийн тоо хамгийн ихдээ 6, нэг өрхөд дунджаар хөдөлмөрийн насны 2 хүн амьдарч байна. Хөдөлмөр эрхэлж буй өрхийн гишүүдийн тоог харвал 52.9 хувь нь дангаараа хөдөлмөр эрхэлдэг буюу ОТ-д ажиллан ганцаараа гэр бүлээ тэжээж байна. ОТ төсөлд ажилласнаараа өрхийн орлого нэмэгдэж, өөрийн цалингаар өрхийн хэрэгцээгээ бүрэн хангаж байна гэж үзсэн. Өрхөө ганцаараа тэжээж буй эдгээр 908 ажиллагсдын 77.1 хувь нь 3-5 ам бүлтэй, дунджаар 3.82 буюу 4 ам бүлтэй байна.

ОТ-н хөдөлмөр эрхлэлтийг байршлаар авч үзвэл, 73.3 хувь нь Улаанбаатар хот, 12.1 хувь нь Өмнөговь аймаг, 5.8 хувь нь Дархан-Уул аймаг, 4.1 хувь нь Орхон аймгийн ажиллагсад байна. Үлдсэн 4.7 хувь буюу 81 ажиллагсад Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дорноговь, Дундговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн иргэд ажиллаж байгаа нь Монгол улсын өнцөг булан бүрээс чадварлаг ажиллагсдыг ажиллуулж байна.

Монгол Улсын уул уурхайн салбарын ажиллагсдын 39.7 хувийг 25-34 насны залуучууд бүрдүүлж байгаа бол ОТ-н нийт ажиллагсдын 55.9 хувийг 25-34 насны залуучууд эзэлж, ОТ төсөлд уул уурхайн салбарын дундажтай харьцуулбал залуучуудын эзлэх хувь өндөр байна.

Зураг 4.1. ОТ болон уул уурхайн салбарын ажиллагсад, насны бүлгээр



Эх сурвалж: www.1212.mn

29 Ажиллагсдын түүвэр судалгааны зайлшгүй шаардагдах түүврийн хэмжээ 1625 байв. Энд жингийн дисперс хамгийн их, асуулгад хариулахгүй байх магадлалыг 20 хувь байхаар тус тус тооцож, 99 хувийн итгэх магадлалтайгаар алдааны хязгаар 3.5 хувиас хэтрэхгүй байхаар тооцоог хийсэн.

Боловсролын түвшингээр харвал бакалаврын боловсролтой ажиллагсдын эзлэх хувь хамгийн их буюу 58.03 хувь, үүний дараа магистр, доктор болон техникийн болон мэргэжлийн/тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажиллагсад хамрагдаж байна. Эндээс харахад ОТ-н ажиллагсдын 86.2 хувь нь мэргэжилтэй, чадварлаг хүмүүс байна.

Зураг 4.2. Ажиллагсад, боловсролын түвшингээр




Судалгаанд хамрагдсан ажиллагсдын 86.2 хувь буюу 1480 ажилтан МСҮТ, коллеж болон их, дээд сургууль төгссөн мэргэжил эзэмшсэн бөгөөд эдгээр ажиллагсдын 64.4 хувь нь өөрийн мэргэжлээрээ ажиллаж байгаа бол үлдсэн 35.6 хувь өөр мэргэжлээр ажиллаж байна. Боловсролын түвшингээр авч үзвэл Техникийн болон мэргэжлийн/тусгай мэргэжлийн дунд түвшний боловсролтой ажиллагсад бусад боловсролын түвшинтэй харьцуулахад мэргэжлээрээ ажиллах нь давамгайлж байна.

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй ажиллагсдын дундаж цалин 1328.1 мянга, Улаанбаатар хотын дундаж цалин 1423.2 мянга, Өмнөговь аймгийн 1395.0 мянган төгрөг байна. ОТ хэрэгжиж эхэлснээр Өмнөговь аймгийн ядуурлын түвшин багасаж, хүмүүсийн орлого нэмэгдсэн. ОТ-н ажиллагсдын цалингийн түвшинг харвал нийт ажиллагсдын 73.9 хувь нь улсын дунджаас дээш буюу 1.5 сая төгрөгөөс дээш цалин авч байна.


ОТ-д ажилласан жил болон цалингийн хооронд хамаарлын хүчийг корреляцийн коэффициентээр тодорхойлж үзвэл 0.378 буюу эерэг, сул хамааралтайгаар үнэлэгдэж, ажилласан жил болон цалин нь 37.8 хувийн хамааралтай байна.

Зураг 4.3. Нийт болон ОТ-д ажилласан дундаж жил, цалингийн түвшингээр



Судалгаанд хамрагдсан нийт ажиллагсдын 87 хувь нь ОТ-д ажиллахаасаа өмнө өөр байгууллагад ажиллаж байсан. Эдгээр ажиллагсдын өмнөх болон одоогийн цалинг харьцуулбал 41.9 хувь нь өмнөх ажилдаа 1 сая хүртэлх төгрөгийн цалин авдаг байсан бол ОТ-д ажилд орсноор тэдгээрийн цалингийн тархалтад өөрчлөлт орж, эдгээр ажиллагсдын 38.9 хувь нь 1.5-3.5 сая хүртэлх төгрөгийн цалин авдаг болжээ.

Зураг 4.4. Цалингийн өөрчлөлт, цалингийн интервалаар



Өмнөх ажлын цалинг одоогийн цалинтай харьцуулахад 1 сая хүртэлх төгрөгийн цалинтай байсан ажиллагсдын 84.7 хувь, 1.1-1.5 сая хүртэлх цалинтай байсан ажиллагсдын 75.7 хувь, 1.5-3.5 сая хүртэлх цалинтай байсан ажиллагсдын 51.7 хувь, 3.5-5.5 сая хүртэлх төгрөгийн цалинтай байсан ажиллагсдын 48.8 хувь, 5.5-8.0 сая хүртэлх цалинтай байсан ажиллагсдын 40 хувь нь өмнөх ажлаасаа өндөр цалин авч байна.


Хүснэгт 4.1. Өмнөх болон одоогийн сарын цалингийн өөрчлөлт, цалингийн интервалаар

	Одоогийн цалин					
	<1.0	1.1 - 1.5 сая	1.5 - 3.5 сая	3.5 - 5.5 сая	5.5 - 8.0 сая	>8.0
Өмнөх ажлын цалин <1.0	15.3%	24.8%	33.4%	18.2%	7.2%	1.1%
Өмнөх ажлын цалин 1.1 - 1.5 сая	6.0%	18.3%	48.6%	20.0%	6.2%	0.9%
Өмнөх ажлын цалин 1.5 - 3.5 сая	1.8%	4.9%	41.6%	38.8%	9.8%	3.1%
Өмнөх ажлын цалин 3.5 - 5.5 сая	3.2%	3.2%	14.3%	36.5%	31.7%	11.1%
Өмнөх ажлын цалин 5.5 - 8.0 сая	10.0%		10.0%		40.0%	40.0%
Өмнөх ажлын цалин >8.0		25.0%			50.0%	25.0%

ОТ-д ажиллахаасаа өмнө ажиллаж байсан 1495 ажиллагсдын өмнөх ажлын цалин болон одоогийн ажлын цалингийн хамаарлыг шалгахад корреляцийн коэффициент 0.349 буюу эерэг, сул хамааралтай байна.


ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээнд Монгол ажиллагсдыг сургах заалт байдаг. Энэ хүрээнд ОТ компани 2012 онд сургалтын нэгжийг байгуулан ажиллагсдын ур чадварыг сайжруулах олон хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан ажиллагсдын 65.3 хувь буюу 1121 ажилтан мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагджээ.

Зураг 4.5. Сургалтад хамрагдсан байдал, хувиар



2020 онд эдгээр ажиллагсдын 76.7 хувь нь аюулгүй ажиллагааны сургалт, 42.2 хувь нь мэргэжлийн сургалт, 38.4 хувь нь гүний уурхайн үйл ажиллагааны сургалт, 18.6 хувь нь ил уурхайн үйл ажиллагааны сургалтад хамрагджээ. Сургалтад хамрагдсан эдгээр ажиллагсдын 1111 ажилтан 1 сургалтад, 341 ажилтан 2 сургалтад, 268 ажилтан 3 сургалтад, 56 ажилтан 4 төрлийн сургалтад тус тус хамрагджээ.

Зураг 4.6. 2020 онд сургалтад хамрагдсан байдал, сургалтын төрлөөр




ОТ компани нь ажиллагсдын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр олон сургалт зохион байгуулахаас гадна хэлний чадвар сайжруулах сургалт, харилцааны ёс зүй, хувь хүний хөгжил, эрүүл мэнд, багаар ажиллаж чадварын талаар сургалтуудад хамрагдаж, ажиллахын хажуугаар суралцан ур чадвараа сайжруулсаар байна.

Ковид-19 цар тахлын нөлөө

Ковид-19 цар тахлын үед компаниуд ажлын байрны шинэ зохион байгуулалт руу шилжих, ажлын цагийн хуваарилалтанд өөрчлөлт оруулах, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдалд халдваргүйжүүлэлт, ариутгал, дархлаажуулалтыг дэмжих гээд олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх, цаашид дасан зохицож ажиллах нөхцөл байдалтай тулгарсан. Том компаниудын ийм үйлдэлд хариу үзүүлэх байдал дунд, жижиг компаниудтай харьцуулахад илүү хурдтай явагдсан. Үүнийг ажиллагсдын цалин, орлого, өрхийн амьжиргааны өөрчлөлт, түүний тогтвортой байдал хадгалагдсан эсэхээр харуулж болох юм.

2019 оныг 2020 онтой харьцуулахад 3.5 сая төгрөг хүртэлх орлоготой өрхийн орлого буурсан бол түүнээс дээш орлоготой өрхийн орлого өссөн.

Зураг 4.7. Өрхийн орлогын өөрчлөлт, хувиар



2019 оныг 2020 онтой харьцуулахад ажиллагсдын 63-92 хувийнх нь орлого тогтвортой байна. Харин 1.5 сая хүртэлх орлоготой байсан өрхийн 37 хувь, 1.5-3.5 сая хүртэлх орлоготой байсан өрхийн 27.7 хувь, 3.5-5.5 сая хүртэлх орлоготой өрхийн 20.6 хувь, 5.5-8.0 сая хүртэлх орлоготой өрхийн 14.1 хувь,


8.0-11.0 сая хүртэлх орлоготой байсан өрхийн орлого 19.4 хувиар тус тус нэмэгджээ. 2019 онд 1.5-3.5 сая төгрөгийн орлоготой байсан өрхийн хувьд 2020 онд өрхийн орлого 68.3 хувь нь тогтвортой байсан бол 26.5 хувийнх нь орлого өсөж 3.5-5.5 сая болжээ.

Хүснэгт 4.2. Өрхийн орлогын өөрчлөлт, орлогын интервалаар

		2020 онд					
		1.5 <	1.5 - 3.5 сая	3.5 - 5.5 сая	5.5 - 8.0 сая	8.0 - 11.0 сая	11.0 >
2019 онд	1.5 <	63.0%	33.1%	3.5%	0.2%		0.2%
	1.5 - 3.5 сая	4.1%	68.3%	26.5%	1.0%		0.2%
	3.5 - 5.5 сая	0.3%	2.6%	76.5%	20.1%	0.5%	
	5.5 - 8.0 сая		0.6%	10.4%	74.8%	12.9%	1.2%
	8.0 - 11.0 сая			6.5%	6.5%	67.7%	19.4%
	11.0 >			4.0%	4.0%		92.0%


Ковид-19 цар тахлын нөлөөгөөр өрхийн хадгаламжийн хэмжээнд гарсан өөрчлөлтийг тодруулахад 39.4 хувь нь хадгаламжаа өсгөж чадсан, 33.2 хувь нь хадгаламжаа өөрчлөөгүй, 21.6 хувь нь хадгаламж буурсан гэж хариулжээ.

Зураг 4.8. Өрхийн нэг жилд хийдэг хадгаламжийн хэмжээний өөрчлөлт, 2020/2019




Хадгаламж буурсан ажиллагсдын хувьд ажлын цаг (60.8 хувь) болон цалин (25.3 хувь) буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн. Эдгээр өрхийн гишүүдийн (65.4 хувь) орлого 2019 онтой харьцуулахад 2020 онд буурсан нь хадгаламжид сөрөг нөлөө үзүүлжээ.

Зураг 4.9. Хадгаламж буурсан ажиллагсдын цалингийн орлогын өөрчлөлт, хувиар




Зураг 4.10. Хадгаламж буурсан ажиллагсдын өрхийн бусад гишүүдийн орлогын өөрчлөлт, хувиар




Ковид-19 цар тахлын нөлөөгөөр судалгаанд хамрагдсан ажиллагсдын 52.2 хувийнх нь цалинд өөрчлөлт орсон бол 39.4 хувь нь өөрчлөлт ороогүй, үлдсэн 8.4 хувь нь хэлж мэдэхгүй гэжээ. Цалингийн өөрчлөлтийг тодруулахад 36.9 хувь ажлын цаг багассан, 18.4 хувь нь цалин буурсан нь нөлөөлсөн. Харин цаг үеийн нөхцөл байдалтай зохицон ОТ компанийн зүгээс ажиллагсдад урамшуулал, дэмжлэг үзүүлсэн бөгөөд нийт ажиллагсдын 27 хувь нь хамрагдсан.

Зураг 4.11. Ковид-19 цар тахлын үе дэх цалингийн орлогын өөрчлөлт, 2020-2019




Зураг 4.12. Цалингийн өөрчлөлтийн шалтгаан




Ковид-19 цар тахлын нөлөөгөөр өрхийн бусад гишүүдийн хувьд 48.1 хувийн орлого буурсан бол харин 35.7 хувьд орлогын өөрчлөлт ороогүй.

Зураг 4.13. Зөвхөн Ковид-19 цар тахлын нөлөөгөөр өрхийн бусад гишүүдийн орлогын өөрчлөлт, 2020/2019, хувиар




Өрхийн бусад гишүүдийн орлого буурсан шалтгааны тодруулбал 47.8 хувь нь ажлын цаг багассан, 29 хувь нь хувийн бизнес зогссон, ашиг буурсан, 28.8 хувь нь цалин буурсан шалтгаан голлон нөлөөлсөн.

Зураг 4.14. Өрхийн бусад гишүүдийн орлого буурсан шалтгаан, хувиар




ОТ-н ажиллагсад болон өрхийн бусад гишүүдийн орлогын бууралтын шалтгааныг харьцуулан харахад ОТ-н хувьд ажлын цаг болон цалингийн бууралт нь бусад салбарт ажиллаж буй ажиллагсадтай харьцуулахад бага байна. Эндээс харвал, бусад салбартай харьцуулахад ОТ-н ажиллагсдад Ковид-19 цар тахлын үед ажлын байрны зохион байгуулалттай холбоотой эрсдэл харьцангуй багатайгаар ажилласан.

Зураг 4.15. Орлого буурсан шалтгаан, өрхийн гишүүд болон ОТ-н ажиллагсдаар



Ковид-19 цар тахлын нөлөөгөөр өргөн хэрэглээний бараа 25.7 хувь, эрүүл мэндийн бараа 24.6 хувь, боловсролд зарцуулах зардал 29 хувь буурч, өрхийн хэрэглээ, худалдан авалт багассан.

Зураг 4.16. Өрхийн худалдан авалтын өөрчлөлт, 2020/2019, хувиар



ОТ компанид ажиллаж эхэлснээс хойшхи хугацаанд ажиллагсдын амьжиргаанд гарсан эерэг өөрчлөлтүүдээс онцолбол:

- Тогтмол орлоготой болсон, цалин өссөн, амьдрал ахуй сайжирсан, хадгаламжтай болсон;
- Ажиллангаа сурч боловсорч, мэдлэгээ дээшлүүлж, ахиж дэвших боломжтой;
- Аюулгүй ажиллагааны зөв дадалтай болсон;
- Ёс зүй, төлөвлөгөө, хүндлэлийг илүү танин мэдсэн;
- Найрсаг хамт олонтой болсон гэж үзсэн.

4.2. ОТ-Н МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ОРУУЛЖ БҮЙ ХУВЬ НЭМЭР БА КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ


Хөдөлмөр эрхлэлтэд оруулж буй хувь нэмэр

Монгол Улсын Засгийн газар 2009 оны 10 дугаар сарын 6-нд ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурж, 2010 оноос эхлэн уурхайн бүтээн байгуулалтын ажил эхэлснээр ажиллах хүчний эрэлт нэмэгдэж, тэр дундаа уул уурхайн салбарт мэргэжилтэй боловсон хүчин, шинэ ур чадвар бүхий ажиллагсдыг бэлтгэх хэрэгцээ үүссэн. Энэхүү гэрээний 8 дугаар бүлэгт хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт болон сургалттай холбоотой заалтыг оруулж өгснөөр дэлхийд өрсөлдөх чадвартай Монгол ажиллагсдыг бэлтгэх ажлын эхлэл тавигдсан.

ОТ компани 2015 онд алсын хараагаа шинэчлэн “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ” гэж тодорхойлсон нь ажиллах хүчний хөгжилд ихээхэн анхаарал хандуулж, ажиллах хүчний авьяас, ур чадварыг тогтвортой хөгжүүлэх талаарх компанийн үндсэн зорилгыг тусгасан.

2020 оны 12 дугаар сарын байдлаар ОТ-д 12,364 ажилтан ажиллаж байна. Энд Өмнөговь аймгаас 2,852 иргэн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 26.8 хувийг бүрдүүлж байна. ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээний 8.4 дэх заалтыг давуулан биелүүлж, нийт ажиллагсдын 95.42 хувийг Монгол Улсын иргэд бүрдүүлж байна.

Зураг 4.17. Оюу Толгойн ажиллагсад



Эх сурвалж: ОТ ХХК


ОТ компани нь улс орны нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хянах талаар тодорхой үүргүүдийг хүлээсэн байдаг. Эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд нэн тэргүүнд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, урт хугацааны хөгжлийн тогтвортой байдлыг хангахаар зэс, алт бусад ашигт малтмалыг олборлон боловсруулж, олон улсын зах зээлд нийлүүлснээр нэмүү өртөг, үр ашгийг хангахын зэрэгцээ Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулсаар ирсэн.

ОТ компани нь 2010 оны 7 дугаар сарын 28-ны өдөр 1.2 тэрбум ам.долларын өртөгтэй зэс, алт баяжуулах үйлдвэрийн суурийг тавьж, 2013 оны 1 дүгээр сарын 31-нд зэсийн анхны баяжмалаа үйлдвэрлэн, 2013 оны 7 дугаар сарын 9-ны өдрөөс зэсийн баяжмалаа экспортолж эхлэв. Энэхүү бүтээн байгуулалтын оргил үед ОТ компанийн ажиллагсад 2955, гэрээт компанийн ажиллагсад 17426 хүрч, барилгын ажиллагсдын тоо 2011 оны 11 дүгээр сарын байдлаар 14760 болж байв.

ОТ компанийн ажиллагсдын ажлын байр нь харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 2013 оны 9 дүгээр

сараас эхлэн хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсаны дагуу нийт ажиллагсдын 90 болон түүнээс дээш хувийг Монгол Улсын иргэд бүрдүүлж эхлэв. Үүнээс хойш тасралтгүй өсөж, 2020 оны байдлаар нийт ажиллагсдын 95.17 хувь буюу 2877 Монгол Улсын иргэн амжилттай ажилласаар байна.

Зураг 4.18. ОТ компанид Монгол ажиллагсдын эзлэх хувь, сараар



Эх сурвалж: ОТ ХХК

Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн мэдээллээр 2019 оны 1 дүгээр улиралд огцом буурч, Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 оны 3 дугаар улиралд дахин огцом буурчээ. 2019 оны 1 дүгээр улирлаас эхлэн ОТ компанийн ажиллагсдын тоо нэмэгдэж байгаа бөгөөд Ковид-19 тахлын нөлөөнд автахгүйгээр 2020 онд тогтвортой ажиллаж, өөрсдийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн.

Зураг 4.19. Монгол улсын нийт ажиллагсад болон ОТ компанийн ажиллагсад, улирлаар




Эх сурвалж: YCX, ОТ 2021

ОТ-н гэрээт компанийн ажиллагсдын хувьд бүтээн байгуулалтын ажлаас хамааран ажлын байр нь тогтворгүй байна. Монгол Улсын Засгийн газраас 2013 онд ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах, цаашдын бүтээн байгуулалттай холбоотой явц сунжирснаар 2013-2016 оны хооронд гэрээт компаниудын ажлын байр 3158 хүртэл буурсан.

2015 оны 5 дугаар сарын 16-нд ОТ-н гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн гэрээнд гарын

үсэг зурснаар ОТ-н бүтээн байгуулалтын 2 дахь үе шат эхэлсэн. Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил эхэлснээр дэлхийн цөөн тооны уурхайд ашигладаг блокчлон олборлох технологийг нэвтрүүлэн Монгол Улсын ажиллагсдыг сурган дэлхийд өрсөлдөх, ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэн ажиллуулсаар байна. 2020 оны байдлаар нийт гэрээт компанийн ажиллагсдын 95.5 хувийг Монгол Улсын иргэд бүрдүүлж байна.


Зураг 4.20. Гэрээт компанийн ажиллагсад болон Монгол ажиллагсдын эзлэх хувь, сараар



Эх сурвалж: ОТ ХХК

2019 оны 4 дүгээр улирлаас эхлэн Оюу Толгойн гэрээт компаниудын ажиллагсдын тоо буурч байгаа бөгөөд Ковид-19 тахлын нөлөө болон төслийн гүйцэтгэх ажлын нөхцөлөөс хамааран 2020 оны 2 улирал хүртэл тасралтгүй буурсан. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр гэрээт компанийн ажиллагсад бусад түвшний ажиллагсадтай харьцуулахад эрсдэлд өндөр байгаа нь харагдаж байна.

Зураг 4.21. Монгол улсын нийт ажиллагсад болон ОТ-н гэрээт компанийн ажиллагсад, улирлаар




Эх сурвалж: ҮСХ, ОТ ХХК

ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээний 8.11, 8.12, 8.13 дугаар заалтад тусгагдсанаар инженер-техникийн ажиллагсдын тоог нэмэгдүүлэх, энэ чиглэлийн ажиллагсдыг сургаж бэлтгэх төлөвлөгөө гарган ажиллахыг тусгасан.

ОТ-н нийт ажиллагсдыг албан тушаалаар нь авч үзвэл өнгөрсөн 7 жилийн хугацаанд дээд удирдлага болон гүйцэтгэх түвшний ажилд монголчуудын эзлэх хувь 14.1 пунктээр нэмэгдсэн нь Монгол ажиллагсдын удирдах чадвар сайжирч байгааг илтгэж байна.

Удирдах ажилтанд дээд удирдлага, гүйцэтгэх түвшний ажил, менежер, ахлах (supervisor/superintendent)-уудыг оруулан тооцвол Монгол ажилтнуудын эзлэх хувь 2013 онтой харьцуулахад 72.4 хувиас 81 хувь болж өссөн. Инженер-техникийн ажилтанд мэргэжилтэн (specialist/professional) болон техникийн/худалдааны ажилтан (technical/trade)-ыг хамруулан авч үзвэл өнгөрсөн 7 жилийн хугацаанд 91.8 - 94.3 хувь болж өсжээ. Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу инженер техникийн ажиллагсдын 70 гаруй хувь нь Монгол Улсын иргэн байх шаардлагыг давуулан биелүүлсэн.

Зураг 4.22. Монгол ажиллагсдын эзлэх хувь, албан тушаалаар



Эх сурвалж: ОТ ХХК

Ковид-19 цар тахлын нөлөө нь эдийн засгийн бусад салбаруудын адилаар уул уурхайн салбарт сөргөөр илэрсэн. Орон нутаг болон олон улсын нислэгүүд саатсанаас үүдэн уртасгасан цагаар ажиллах, гадаад ажиллагсдын хувьд гэр бүлээсээ олон сараар хол байх эсвэл ажилдаа очиж чадахгүй байх зэрэг хүндхэн сорилтууд ажилчдад тулгамдаж байсан ч ОТ компани өөрсдийн үйл ажиллагаагаа амжилттай төлөвлөн 2020 оны зэс, алтны үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлж чадсан.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр бүх нийтийг хамарсан хөл хорионы үеэр ажиллагсдыг гэрээр ажиллуулахыг шаардаж байгаа энэ үед уул уурхайн жижиг, том гээд бүх компаниудын үйл ажиллагаа удааширч, зогсонги байдалд орсон. Шинэ дэвшилтэт технологи, интернэт сүлжээ хөгжсөний ачаар олон ажиллагсад алсын зайнаас ажиллах боломжтой болсон ч эдийн засгийн бүх салбарт тэгш үйлчлэхгүй байгаа төдийгүй бүх ажлын байранд тохирохгүй байсан. Харин гүний уурхайн барилгын төслүүдийг хариуцдаг “Ворлей” компанийн технологийн дэвшлийг ашиглан ашиглалтад оруулах үйл явцыг алсын зайнаас гадаад



мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэх аргачлал нэвтрүүлсэн. Барилгын ашиглалтад оруулах үйл явц бол цахилгааны утас, хавхалга бүрийг стандартын дагуу ажиллаж байгаа эсэхийг нарийн шалгаж туршдаг, мэргэжлийн хариуцлага ихтэй ажил бөгөөд мэргэжилтэн заавал байлцаж үйл явцыг хянах шаардлагатай байдаг. Тиймээс гүний уурхайн төслийн баг хамт олон VuzixM400 камертай шил ба iPad таблет дээр цахим хурлын Zoom, Vuforia Chalk аппликэйшнууд ашиглаж шууд хуралдан, ашиглалтад оруулах ажлуудыг амжилттай хийж туршсан. Талбай дээр байгаа ажилтан, дэлхийн өөр өнцөгт байгаа мэргэжилтнүүдтэй шууд харилцаж, бодит орчинд зааварчилгаа авах боломжтой болсон бөгөөд олон мянган долларын хэмнэлтийг бодитоор хийж чадсан.

ОТ компани Монгол ажиллагсдын ур чадварыг сайжруулах чиглэлээр олон хөтөлбөр хэрэгжүүлж байсны үр дүнд Ковид-19 цар тахлын үед гүний уурхайн бүтээн байгуулалт тасалдалгүй үргэлжилж чадсан. Үүний үр дүнд монгол залуус удирдлагын түвшинд шилжиж, гүний уурхайн чухал байгууламжууд болох 1300 метрийн гүнд байрлах бутлуурын байгууламж, гүний уурхайгаас хүдэр гадарга руу тээвэрлэх, материал зөөвөрлөх туузан дамжуургын байгууламжуудын барилга угсралтын ажил, гүний уурхайн олборлолтын малтлага, бэхэлгээний ажлууд гэх зэрэг олон чухал хэтдээ Монгол улсын эдийн засагт том хувь нэмэр оруулах ажлууд эрчээ алдалгүй урагшилсан. Хамгийн гол нь Монгол залуус хүнд цаг үед хэрхэн бие даан шийдвэр гаргах, чухал төслүүдийг хэрхэн аюул осолгүй амжилттай үргэлжлүүлэх талаар арвин туршлага хуримтлуулж чадлаа. Мөн Баяжуулах үйлдвэрийнхээ ээлжит засвар үйлчилгээг аюул осолгүй, чанартай, хугацаанд нь гүйцэтгэх чимхлүүр ажлыг анх удаагаа монгол мэргэжилтнүүдийн баг амжилттай хийж гүйцэтгэсэн нь Монгол инженер, техникийн ажиллагсдын ур чадвар, дадлага туршлага сайжирсныг илтгэж байна.

Боловсролын салбарт оруулсан хувь нэмэр

ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсаны дагуу боловсролын салбарт үе шаттай төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хуримтлагдсан дүнгээр 120 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.

Хөрөнгө оруулалтын гэрээний 8.13 дугаар заалтад зааснаар 2010 оноос хойш Оюу Толгой мэргэжлийн боловсролын салбарт 79.809 сая ам.долларын дэмжлэг үзүүлснээр уул уурхайн салбарын 1 сургууль, 4 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, 15,649 хүн төслийн үр шимийг хүртэж мэргэжил ур чадвараа сайжруулан Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулахаар ОТ болон бусад байгууллагуудад ажиллаж байна.

Хүснэгт 4.3. Мэргэжлийн боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалт

№	Хөрөнгө оруулалтын төрөл	Санхүүжилт, сая ам.доллороор	Төслийн үр шимийг хүртсэн хувь хүн, байгууллага
1	Сургуулийн барилга	27.0	Даланзадгад, Дархан, Дорнод, Чойр Политехникийн коллеж, Монгол Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургууль, Ханбогд МСҮТ
2	Тоног төхөөрөмжийн хандив	3.9	МСҮТ
3	3300 мэргэжилтэй ажилтан бэлтгэх	36	13000 гаруй ажилгүй иргэд мэргэжлийн сургалтад хамрагдаж, чадамжийн гэрчилгээ авсан
4	Дадлагажигч ажилтан хөтөлбөр	3.5	298 иргэд хамрагдсан
5	МБС-ын багш нарыг мэргэшүүлэх	5.4	1900 багш Австралийн мэргэшил эзэмшсэн. Үүнээс 120 багш, удирдлагууд Австрали улсад туршлага судалсан
6	Ажил, мэргэжилд бэлтгэх хөтөлбөр	0.61	Орон нутгийн 251 иргэдийг сургалтад хамруулж Австралийн болон үндэсний стандартад нийцсэн гэрчилгээ олгосон

7	Мэргэжил олгох хөтөлбөр	1.7	Өмнөговь аймгийн иргэдийг Австралийн Гэрчилгээ II түвшинд сургаж, Цахилгаанч, Механикч, Гагнуурчны мэргэжлийн гэрчилгээ олгодог. Дараагийн III түвшний сургалт болох ОТ дадлагажигч хөтөлбөрт суралцах боломж олгодог хөтөлбөрт 190 иргэн хамрагдсан
8	Pilot program	0.02	
9	ЗД хөтөлбөр	1.54	Даланзадгад, Дархан, Дорнодын Политехникийн Коллеж хамрагдсан.
10	Дэлхийн ур чадварын тэмцээний дэмжлэг	0.139	Дэлхийн ур чадварын тэмцээний бэлтгэлд 10 хүн хамрагдаж 2017 онд Жанлав-Ойдов МУ-ыг төлөөлж Абу Даби болсон тэмцээнд гагнуурын төрөлд өрсөлдөж анх удаа Тусгай байранд шалгарсан.
	Нийт	79.809	

Эх сурвалж: ОТ ХХК

ОТ компанийн зүгээс мэргэжлийн сургалтыг боловсронгуй болгон хөгжүүлэхэд оруулж байгаа нэг чухал хувь нэмэр бол техник мэргэжлийн жишиг ЗД сургууль төслийг санаачлан хэрэгжүүлсэн явдал юм. Энэхүү төслийн үр дүнд Дархан, Дорнод, Даланзадгадын Политехникийн коллежид мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх ажилд үнэтэй хувь нэмрээ оруулж байна. Төслийн хүрээнд үлгэр жишээ болохуйц олон ажлыг зохион байгуулж, хүрсэн үр дүн, амжилтуудаас дурдвал:

- Герман улсын хөгжлийн зөвлөхийг эдгээр сургуульд ажиллуулж, багш нарыг өдөр тутмын зөвлөгөөгөөр хангасан.
- Багш нарын онолын болон мэргэжлийн дадлага хичээлийн заах арга зүй сайжирч суралцагсдыг олон улсын стандартын дагуу бэлтгэх чадвар эзэмшсэн.
- Эрэлтэд тулгуурлан богино хугацааны сургалтуудыг аж ахуйн нэгж, МБСБ-ын багш нар, иргэдэд зориулан зохион байгуулах боломжтой болсон.
- Суралцагсдыг үйлдвэр дээр ажиллахад урьдчилан бэлтгэх зорилгоор үйлдвэрлэлийн дамжлагын тоног төхөөрөмжийг сургалтын зориулалтаар тусгайлан загварчилсан төхөөрөмжийг суурилуулах орчин нөхцөлийг бэлтгэхэд ОТ компани дэмжлэг үзүүлсэн.
- Австралийн улсын III түвшний гэрчилгээтэй хөтөлбөрт дээрх 3-н сургуулийн 43 багш хамрагдаж аюулгүй ажиллагааны нэгдсэн ойлголт, мэдлэг олж авсан ба олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшлийн гэрчилгээ гардан авчээ.
- ОТ компани Дорнодын Политехникийн коллежид OHSAS8001 стандартыг хэрэгжүүлж Аюулгүй ажиллагааны сургалтын жишиг төвийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээр аюулгүй ажиллагааны стандартыг нэвтрүүлсэн анхны сургалтын байгууллага болсон.
- ЗД төслийн хүрээнд ОТ багш солилцооны хөтөлбөр хэрэгжсэнээр сургалтын шилдэг туршлагаудыг харилцан солилцох, хуваалцах замаар багш нарын чадавхийг бэхжүүлж байна.

Дэлхийн ур чадварын тэмцээнд оролцох оролцогч нарын бэлтгэлд зориулж 139.0 мянган ам.долларын дэмжлэг үзүүлж, бэлтгэл хийх орчныг хангаж өгснөөр 2017 онд Жанлав-Ойдов МУ-ыг төлөөлж Абу Даби болсон тэмцээнд гагнуурын төрөлд өрсөлдөж анх удаа Тусгай байранд шалгарсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монголын ажиллах хүчний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ялангуяа уул уурхай, барилгын салбарт мэргэшсэн техникийн сургалт явуулдаг болоход дэмжлэг үзүүлсэн.

ОТ компанийн зүгээс оюутан, залууст зориулсан тэтгэлэгт хөтөлбөрт зориулан 2010 оноос хойш 4.3 сая ам.долларыг зарцуулснаар 2097 оюутан, залуусын мэргэжил, ур чадварыг сайжруулахад хөрөнгө оруулсан. Мөн Говийн тэтгэлэг болон шинэ төгсөгчийн хөтөлбөрт 641 оюутан, залуусыг хамруулжээ. Эдгээр хөтөлбөрт хамрагдсан оюутнуудаас 75 нь ОТ компанийн үндсэн ажилтан болж сурч мэдсэн эрдэм мэдлэгийнхээ үр шимийг хүртэж байгаа бол бусад оюутнуудын хувьд өөр өөрийн хамаарах салбарт ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Хүснэгт 4.4. Оюутан залууст зориулсан тэтгэлэгт хөтөлбөр

№	Хөтөлбөр	Санхүүжилт, мянган ам.доллороор	Хамрагдсан оюутан, залуусын тоо	ОТ компанийн үндсэн ажилтан болсон
1	Залуусын хөгжлийн хөтөлбөр (2013-2020)	264.3	1170	-
2	Дотоодын тэтгэлэг (2010-2020)	833.4	345	23
3	Гадаадын тэтгэлэг (2012-2020)	2809.7	39	21
4	Дадлагажигч оюутны хөтөлбөр (2010-2020)	425.1	543	31
5	Говийн тэтгэлэг (2005-2020)	-	527	-
6	Шинэ төгсөгчийн хөтөлбөр (2015-2017)	-	114	-
	Нийт	4,332.5	2738	75

Эх сурвалж: ОТ

ОТ компани залуусын хөгжлийн хөтөлбөрийг 2013 оноос хойш хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр нь дунд сургуулиас нь эхлээд хөгжүүлэх зорилготой бөгөөд энэ нь хувь хүний хөгжилд шууд нөлөөлж байгаагаараа онцлог юм. Залуусын хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан оюутан, сурагчдаас 15 нь гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан нь энэхүү хөтөлбөрийн үр дүнг илтгэхээр байна.

Дотоодын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ШУТИС-д 247, МУИС-д 75, ХААИС-д 6, АШУҮИС-д 4, үлдсэн 13 нь бусад сургуулиас тэтгэлэгт хөтөлбөр хамрагджээ. Суралцаж буй чиглэлээр авч үзвэл уул уурхай инженер, цахилгааны инженер, барилгын инженер, геологи, геотехнологийн инженер, химийн шинжлэх ухаан, уул уурхайн ашиглалтын технологи, механик инженер, байгаль орчны инженер зэрэг мэргэжилтэн бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Дотоодын тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын 7 хувь нь ОТ компанийн үндсэн ажилтан бол эдгээр оюутнуудаас 12 нь дахин ур чадвараа сайжруулахаар гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.

Гадаадын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Канадын Бритиш Колумбын их сургуульд 9, Торонтогийн их сургуульд 1, МакГиллийн их сургуульд 1, АНУ-ын Колорадогийн уул уурхайн сургуульд 1, Ютагийн их сургуульд 5, Висконсин Мадисоны их сургуульд 1, Иллинойсийн их сургуульд 2, Калифорнийн Бэрклэй их сургуульд 1, Австралийн Кортины их сургуульд 3, Квинсландын их сургуульд 4, Аделейдийн их сургуульд 1 оюутан уул уурхай, инженер, технологийн чиглэлээр нэн шаардлагатай мэргэжлээр суралцсан байна. Гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутны 53.8 хувь нь ОТ компанийн үндсэн ажилтан болжээ.

Дадлагажигч оюутны хөтөлбөрөөр 543 оюутнууд сурч буй мэргэжлийн чиглэлээрээ ОТ компанид дадлагажин ажиллаж, 5.7 хувь нь ОТ компанийн үндсэн ажилтан болжээ. Эдгээр оюутнуудаас 8 оюутан гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж өөрийн мэдлэг чадвараа улам ахиулсаар байна.

ОТ компани нь оюутан, залуусын ур чадварыг сайжруулахаар зарладаг эдгээр хөтөлбөрийн хүрээнд Монгол улсад уул уурхай, инженерийн чиглэлээр суралцаж буй олон оюутан, залуус үр шимийг хүртэж байна. Цаашлаад энэ салбар шинжлэх ухаанаар сурах хүслийг өдөөх, Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжилтэн бэлтгэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж буй томоохон компанийн нэг төлөөлөл болж байна.

ОТ компани оюутан, залуусыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр зарлахаас гадна сургалтын байгууллагуудтай хамтран уул уурхайн нэн шаардлагатай мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулах чиглэлээр ажилладаг. Оюу Толгой, Рио Тинто болон ШУТИС-тай хамтран хэрэгжүүлэх Уул уурхайн геотехникийн мэргэжил олгох, олон улсын судалгааны төв байгуулах төслийн хүрээнд 2.75 сая ам.долларын санхүүжилт гаргахаар болсон. Одоогоор энэ хөтөлбөрөөр 25 оюутан суралцаж байна. Энэхүү хамтарсан хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад дэлхийн их сургуулиудын нэгэн адил сургалт явуулах орчин үеийн лабораторид мэргэжилтнүүдээ бэлтгэх боломж бүрдлээ.

Ажиллагсдыг чадавхижуулах чиглэлээр хийгдсэн сургалт

Хувь хүний хөгжил байгууллагын хөгжилд нөлөөлдөг гэдэг утгаараа ажиллагсдын ур чадвар, мэдлэг боловсрол дээшилснээр ОТ компанийн хөгжилд шууд нөлөө үзүүлж байна.

ОТ компанийн эрхэм зорилго болон үнэт зүйлсийг харахад аюулгүй ажиллагаанд анхаарч ажилладаг бөгөөд эрсдэлтэй ямар ч ажлын шууд зогсоодог. Үүний үр дүнд ОТ компани нь аюулгүй ажиллагаагаараа “Рио Тинто” группийн хэмжээнд тэргүүлэх уурхайн байр сууриа хадгалж, гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлтээ 0.15 хүртэл бууруулсан.

ОТ-д ажил гүйцэтгэж буй бүх байгууллага, хувь хүмүүс аюулгүй ажиллагааны сургалтад хамрагддаг бөгөөд 2013-2020 оны хооронд давхардсан тоогоор ОТ компанийн 8233, гэрээт компанийн 52,066 ажиллагсад аюулгүй ажиллагааны сургалтад хамрагджээ.


Зураг 4.23. Аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан ажиллагсдын тоо



Эх сурвалж: ОТ ХХК

2016-2020 оны хооронд ОТ компани аюулгүй ажиллагааны сургалтад 3,652.0 мянган ам.долларыг зарцуулсан бөгөөд 2020 онд 800 мянган ам.долларын зардал гаргасан нь дээрх хугацаан дахь нийт зардлын 21.9 хувийг эзэлж байна. Сургалтын үр дүнд ОТ компанийн аюулгүй ажиллагааны үзүүлэлтээрээ Рио Тинто групп дотроо тэргүүлэхээс гадна ажиллагсдын амьдралын хэв маягт аюулгүй ажиллагаа ямар чухал зүйл гэдгийг ойлгуулж чадсан. ОТ-н ажиллагсдаас авсан судалгаагаар ОТ-д ажиллаж эхэлснээс хойш таны амьдралд гарсан эерэг өөрчлөлтийг асуухад 5.7 хувь нь аюулгүй ажиллагаа гэж хариулжээ.

Зураг 4.24. Аюулгүй ажиллагааны сургалтын зардал, мянган ам.доллороор



Эх сурвалж: ОТ

ОТ компанийн ил уурхайн сургалтад 2013 оноос хойш 9,383 ажилтан хамрагдсан бол гүний уурхайн сургалтад 2015 оноос хойш 26,993 ажилтан хамрагджээ.

Зураг 4.25. Ил болон гүний уурхайн сургалтад хамрагдсан ажилтны тоо



Эх сурвалж: ОТ ХХК

2015 оноос хойш ил уурхайн сургалтад 9.074 сая ам.доллар, 2016 оноос хойш гүний уурхайн сургалтад 9.848 сая ам.долларын зарцуулсан. 2015 оноос хойш ил болон гүний уурхайн 18.922 сая ам.долларыг сургалтад 34,750 ажилтныг хамруулсан нь нэг ажилтанд дунджаар 544.5 ам.долларын сургалтад хамрагджээ.


Зураг 4.26. Ил болон гүний уурхайн сургалтын зардал, мянган ам.доллар



Эх сурвалж: ОТ ХХК

Ажиллагсдын ур чадварыг сайжруулах зорилгоор мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан бөгөөд 2013 оноос хойш 230 ажилтанд 4.816 сая ам.долларыг зарцуулсан нь нэгж ажилтанд дунджаар 20,939 ам.долларыг зарцуулжээ.

Зураг 4.27. Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажиллагсдын тоо



Эх сурвалж: ОТ ХХК

ОТ компани ажиллагсдын аюулгүй байдлыг хангах зорилгоор гүний уурхайн аврах ангийг байгуулан ажиллуулж 2015-2020 оны хооронд давхардсан тоогоор 113 хүн хамруулжээ.

ОТ компани нь 2013 оноос хойш ажиллагсдын ур чадварыг сайжруулах чиглэлээр аюулгүй ажиллагаа,

ил болон гүний уурхай, мэргэшүүлэх, гүний уурхайн аврах ажиллагааны сургалтад давхардсан тоогоор 97,008 ажилтныг хамруулж, 27.39 сая ам.долларыг зарцуулсан нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх мэргэжилтэй Монгол ажиллагсдын бэлтгэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсаар байна. Мөн Ковид-19 цар тахлын үед ч сургалтын энэхүү тогтолцоогоо зогсоолгүй тасралтгүйгээр үргэлжлүүлж чадсан.


4.3. ДЭЛХИЙН ЗЭСИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Байгалийн баялаг ихтэй орнуудын хувьд уул уурхайн салбарын нөөц баялгаа зөв ашиглаж чадвал ядуурлыг бууруулан, эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэсгэх бололцоотой. АНУ, Швед, Канад, Австрали зэрэг орнууд уул уурхайн нөөц баялгаа ашиглан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж, хүний хөгжлийн индексээрээ дээгүүрт бичигдэх болсон. Канад болон Австрали улсын хувьд уул уурхайн салбар нь сүүлийн зуу гаруй жилийн хугацаанд эдийн засгийн хөгжлийн гол тулгуур салбар хэвээр байна. Хөгжиж буй орнуудаас байгалийн баялгаа ашиглан хурдацтай хөгжиж буй Ботсвана улс нь Сахарын хэсгийн Африкийн уул уурхайгаас хамгийн их хамааралтай улс бөгөөд сүүлийн арваад жилд дэлхийд хамгийн хурдацтай хөгжиж буй орнуудын нэг төдийгүй өөрийн бүсдээ хүний хөгжлийн индексээрээ тэргүүлж байна. Өмнөд Америкийн уул уурхайн хамааралтай орон болох Чили сүүлийн хориод жилд өөрийн бүсдээ хамгийн хурдацтай хөгжиж буй улс болсон. Мөн л тухайн бүсдээ хүний хөгжлийн индексээрээ тэргүүлж байна (McMahon & Moreira, 2014). 2019 оны байдлаар хүний хөгжлийн үзүүлэлтээр Чили улс дэлхийд 43, бүсдээ 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна. (UNDP, 2020).

Перу, Бразил улсын хувьд 1990-2019 оны хооронд хүний хөгжлийн үзүүлэлт 26.8, 24.8 хувиар нэмэгдэж, дийлэнх өөрчлөлт нь 1990-2000 оны хооронд явагдсан бол Чили улсын хувьд тогтвортойгоор өсжээ.

Монгол Улс нь Хүний хөгжлийн үзүүлэлтээрээ 1993 оноос хойш тасралтгүй өсөж 2019 оны байдлаар хүний хөгжлийн индекс 0.737 болж, дэлхийн 189 улсаас 99 дүгээр байранд эрэмбэлэгдэж байна.

Зураг 4.28. Монгол Улсын хүний хөгжлийн индекс, 1990-2019



Эх сурвалж: НҮБХХ. 2020. Хүний хөгжлийн илтгэл

1990-2019 оны хооронд Монгол Улсын хүний хөгжлийн индекс 0.578-аас 0.737 болж 27.5 хувиар өссөн. Энэ хугацаанд хүний хөгжлийн индексийн бүрэлдэхүүн үзүүлэлт болох төрөлтөөс тооцсон дундаж наслалт 9.6 жилээр, сургуульд суралцсан дундаж хугацаа 2.6 жилээр, сургуульд суралцаж хугацаа 4.0 жилээр, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 134.5 хувиар өсжээ.³⁰ Удаа дараа бичигдсэн хүний хөгжлийн илтгэлээс авч үзвэл Монгол Улс нь Хүний хөгжлийн индексээр ихээхэн дэвшилд хүрч 2015 онд анх удаа хүний хөгжлийн түвшин өндөртэй орнуудын эгнээнд шилжсэн. Хүмүүст мэдлэг боловсрол эзэмших боломжийг олгох, урт удаан, эрүүл саруул амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь хүний хөгжлийн 2 чухал хэмжүүр юм. ОТ компани хүний хөгжлийг дэмжин хөгжүүлж байдгийн нэг тод илрэл

нь ажиллагсдын ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд байнга анхаарч үндэсний боловсон хүчнийг олон улсын түвшинд хүртэл хөгжүүлж чадаж байгаа явдал юм.

Зэсийн томоохон уурхайтай Чили, Перу, Бразил, Казакстан улсуудтай хүний хөгжлийн ахиц, дэвшлийг харьцуулж харвал 1990-2019 оны хооронд Монгол Улсын хүний хөгжлийн үзүүлэлт 27.5 хувиар өссөн нь хамгийн өндөр байна. Монгол Улсын хүний хөгжилд гарсан ахиц дэвшлийн дийлэнх хувь нь 2000-2010 оны хоорондох хугацааг хамаарч, 18.4 хувиар нэмэгдсэн.

Хүснэгт 4.5. Хүний хөгжлийн индексийн өөрчлөлтийн хувь, сонгосон улсаар

Улс	1990-2000	2000-2010	2010-2019	1990-2019
Монгол	1.7	18.4	5.9	27.5
Чили	7.1	6.2	6.0	20.5
Перу	10.8	6.2	7.8	26.8
Бразил	11.7	6.1	5.2	24.8
Казакстан	-0.7	11.5	8.0	19.6

Эх сурвалж: НҮБХХ. 2020. Хүний хөгжлийн илтгэл

Хөгжиж буй ихэнх орнуудын үндэсний нийт орлогын ихээхэн хувийг уул уурхайн салбар нь бүрдүүлдэг хэдий ч их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байдгаас болоод шууд томоохон ажил олгогч болж чаддаггүй. Уул уурхай ба металлын олон улсын зөвлөлийн судалгаагаар уул уурхайн салбар нь аливаа улсын нийт хөдөлмөр эрхлэлтийн 1-2 хувийг дангаараа бүрдүүлдэг³¹ гэсэн тооцоог гаргасан.

Зэсийн салбараас эдийн засагт оруулж буй 100 ам.доллар бусад салбарт 36 ам.доллар нэмж бүтээх боломж бүрдүүлж, нэг ажлын байр нь бусад салбарт 3.7 ажлын шинэ байр бүтээдэг гэсэн тооцоог Олон улсын зэсийн холбооноос гаргажээ.

Уул уурхайн салбарын оршин тогтнох чадвар нь тогтвортой, таамаглаж болохуйц зах зээлийн нөхцөл байдал болон байнгын ханган нийлүүлэлтийн сүлжээн дээр тогтдог. Дэлхийн эдийн засагт ямар нэг томоохон доголдол гарахад тэр даруйд тодорхойгүй байдалд орж, үйлдвэрлэл ба үр бүтээмжтэй байдалд саад учирч, ажиллагсад, ханган нийлүүлэгчид, орон нутгийн эдийн засагт ихээхэн хохирол учирдаг.

Ковид-19 цар тахлын тархалтыг бууруулахын тулд ихэнх улсын засгийн газрууд улс даяар гэнэтийн хөл хорио тогтоож байгаа нь зах зээл, ханган нийлүүлэлтийн сүлжээ, хөдөлмөр эрхлэлтэд шууд нөлөөлж байна. Ковид-19 цар тахлын ажлын байр, цалинд үзүүлж буй нөлөөллийг ажлын байрны нөхцөлөөр нь харвал:

- Зарим уурхайн ажиллагсад “чухал хэрэгцээт ажилтан”-д тооцогддог. Учир нь тэд уурхайн үйл ажиллагаа тогтвортой явуулахад нэн шаардлагатай ажил үүргийг гүйцэтгэдэг. Эдгээр ажиллагсад өөрсдийн ажлын байр ба цалингаа хадгалж үлдэнэ.
- Алсын зайнаас ажиллах боломжтой ажиллагсад мөн ажлын байр болон цалингаа хамгаалан үлдэнэ.
- Дээрх хоёр ангилалд багтаагүй ажиллагсад түр хугацаагаар ажлаасаа халагдаж байна. Хэрэв тэднийг энэ нөхцөлд хамгаалах ямар нэг гэрээ хэлэлцээр байхгүй бол орлогоосоо салах эрсдэл хамгийн өндөр байна.

ОУХБ-ын судалгаагаар Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд дэлхийн хэмжээнд ажлын цаг 8.8 хувиар багассан нь 255 сая бүтэн цагийн ажиллагсадтай дүйцэж байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарт үзүүлж буй эрсдэлийн үнэлгээгээр уул уурхай, олборлох салбар нь дундаж эрсдэлтэй гэж

үнэлэгдсэн бөгөөд 2020 оны 2 болон 3 дугаар улиралд ажлын цаг 2.4, 1.6 хувиар багассан ч хөдөлмөр эрхлэлт 3.6, 2.8 хувиар нэмэгдсэн эерэг хандлагатай байна.³²

Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээлэнгээс уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлтэд Ковид-19 цар тахлын нөлөөллийн талаар хийсэн судалгаанд бүтээн байгуулалтын үе шат эрсдэл өндөртэй, харин олборлолт болон боловсруулалтын үе шат дунджаас дээш эрсдэлтэй гэж үнэлсэн. Уурхайн үйл ажиллагаанаас хамаарч бүтээн байгуулалтын үед гэрээт байгууллагын ажиллагсад өндөр эрсдэлтэй байна. Гүний уурхай нь олон тооны ажиллагсдыг лифтээр зөөх нь вирусийн хурдан тархах орчныг бүрдүүлдэг тул өндөр эрсдэлтэй байна. Өмнөд Африкийн зарим уурхайнууд эхний ээлжид ажиллагсдыг хамгаалах үүднээс гүний уурхайн үйл ажиллагааны арчилгаа, үйлчилгээнд анхаарал хандуулж ажиллахыг тусгасан. Польш улсад уурхайн талбар дээр илэрсэн тохиолдлын дараа гүний уурхайн бүтээн байгуулалтын ажлыг түр хугацаагаар зогсоосон.

Хүснэгт 4.6. Уул уурхайн компаниудын ажиллагсдын эрсдэлийн зураглал

	Хайгуул	Бүтээн байгуулалт	Олборлолт/ үйл ажиллагаа	Уул уурхайн боловсруулалт	Хаагдалт ба ашиглалтаас гарах
Ажиллах хүчний шаардлага	Өндөр технологи шаардсан бага ажлын байр	Бага технологи шаардсан их ажлын байр	Өндөр өртөгтэй хөрөнгө хариуцсан ажлын байр	Дундаас дээгүүр технологи шаардсан дунд зэрэглэлийн ажлын байр	Дундаас дээгүүр технологи шаардсан бага ажлын байр
Шууд ажиллагсад					
Өндөр ур чадвартай					
Техникийн ур чадвартай					
Бага ур чадвартай					
Гэрээт ажиллагсад					
		Бага	Дундаас доош	Дундаас дээш	Их

Хэдийгээр улс орнууд уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хориг тавиагүй ч хүмүүсийн хөдөлгөөн, ханган нийлүүлэлтийг хорьсон нь төсөл хөгжүүлэлтэд саад учруулж байна. Перу улсад 15 хоногийн хөл хорио тогтоох үед ажиллагсдыг хамгаалахын тулд нийт 10,000 барилгын ажиллагсдын 8,000 орчмыг түр халж, төсөл хөгжүүлэлтийг дахин эхлүүлэх аюулгүй нөхцөл бүрдэхийг хүлээснээр Англо Американы Квилавеко зэсийн төслийн ажил нилээд удааширсан.

Чили улсад Ковид-19 цар тахлаас сэргийлсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ нэг 7 хоног ажиллаад нэг 7 хоногийн хорионы журам гаргажээ. Түүнчлэн гэрээгээр ажиллагсад болоод ханган нийлүүлэгчидтэй шууд харилцахаас татгалзах ажиллагсдыг гэрээсээ ажиллах боломжоор хангах чиглэлд анхаарч байна. Чилийн уул уурхайн салбарт цар тахлын улмаас ажлын байр их хэмжээгээр буурч байгааг бүртгэжээ.

Монгол Улсад Рио Тинтогийн ОТ гүний уурхайн төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа албан хаагчид, барилгын ажиллагсад, техникийн мэргэжилтнүүдтэйгээ харилцахад саад учирснаас үүдэн удаашраад байна³³ гэж тэмдэглэсэн ч гүний уурхайн бүтээн байгуулалтын ажлыг тасалдалгүй үргэлжлүүлж, гүний уурхайн төслийг хариуцдаг хариуцдаг "Ворлей" компанийн технологийн дэвшлийг ашиглан алсын зайнаас харилцан ажлаа гүйцэтгэж байна.

Цар тахлын нөлөөгөөр хөдөлмөр эрхлэлтэд дараах эрсдэл шууд учирч байна. Үүнд:

- Хөл хорио тогтоох нь хөдөлмөр эрхлэлт, бүтээмж, ирээдүйн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд

32 ILO (2021). ILO Monitor: COVID-19 and the world of work (7th edition)

33 IISD (2020). The impact of Covid-19 on employment in mining

- сөрөг нөлөө үзүүлэх;
- Вирусийн шинэ давалгааны тархалтаас үүдэн эдийн засгийн өсөлтийг хязгаарласан бодлогууд гарах, шинээр хөл хорио тогтоох;
- Бага дунд оврын уул уурхайн компаниуд зээлийн хязгаарлалттай тулгарч, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт нь буурах;
- Жижиг дунд үйлдвэрийн дампуурал нь орон нутгийн ханган нийлүүлэлтийн сүлжээ эрсдэлд орж, ажлын байранд нөлөөлөх;
- Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвт хөрөнгө оруулагчдын итгэл буурах;
- Дэлхийн эрэлт хэрэгцээ болон түүхий эдийн ханган нийлүүлэлтийн тодорхойгүй байдлаас шалтгаалж өргөн хүрээний барааны үнэ эрс буух;

Ковид-19 цар тахал нь хөдөлмөрийн зах зээлд буй алдаа дутагдлыг илүү тод томруун харуулж чадсан. Австрали улсад вирусийн тархалтыг хумихын тулд улс доторх шилжин явах хөдөлгөөнийг хязгаарласнаас үүдэн уул уурхайн олон компаниуд ирж, буцан ажилладаг гэрээт ажиллагсдын тоогоо багасгах шаардлагатай болсон. Энэ байдал нь хөдөлмөр эрхлэлтийн одоогийн хэв загварт дараах хоёр өөрчлөлтийг авчирч байна. Үүнд:

- Орон нутгаас авах ажиллагсдын тоо нэмэгдэх;
- Зарим ажлын байрыг автоматжуулж ажиллах хүчнийг багасгах шаардлагатай болсон.

Бүлгийн дүгнэлт

Монгол Улсын уул уурхайн салбар нь нийт ажиллагсдын 3.9 хувийг бүрдүүлж байна. 2020 оны 12 дугаар сарын байдлаар ОТ-н хүрээнд 12,364 ажилтан ажиллаж байна. Энд Өмнөговь аймгаас 2,852 иргэн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 26.8 хувийг бүрдүүлж байна. ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээний 8.4 дэх заалтыг давуулан биелүүлж, нийт ажиллагсдын 95.42 хувийг Монгол Улсын иргэд бүрдүүлж байна. ОТ төсөлд ажиллаж буй 25-34 насны залуучуудын эзлэх хувийн жин уул уурхайн дундажтай харьцуулахад өндөр байна.

ОТ хөдөлмөр эрхлэлтэд Ковид-19 цар тахлын үзүүлэх нөлөөг илрүүлэх түүвэр судалгаанд үндсэн болон гэрээт компанийн 1720 оролцсон. Судалгаагаар нийт ажиллагсдын 86.2 хувь нь мэргэжилтэй, чадварлаг ажиллагсад байна. Газарзүйн байршлаар авч үзвэл, ажиллагсдын 73.3 хувь нь Улаанбаатар хот, 12.1 хувь нь Өмнөговь аймаг, 5.8 хувь нь Дархан-Уул аймаг, 4.1 хувь нь Орхон аймаг, үлдсэн нь бусад аймгийн харьяалалтай. Нийт ажиллагсдын 52.9 хувь нь дангаараа хөдөлмөр эрхэлж өрхөө ганцаараа тэжээж байна. Эдгээр ажиллагсад дунджаар өөрөөсөө гадна 3 хүнийг цалингийн орлогоороо тэжээж байна.

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй ажиллагсдын дундаж цалин 1328.1 мянга, Улаанбаатар хотын дундаж цалин 1423.2 мянга, Өмнөговь аймгийн 1395.0 мянган төгрөг байна. ОТ-н нийт ажиллагсдын 73.9 хувь нь улсын дунджаас дээш буюу 1.5 сая төгрөгөөс дээш цалин авч байна. ОТ-д ажиллахаас өмнөх ажлын цалин болон одоогийн ажлын цалингийн хоорондын хамаарлыг шалгахад корреляцийн коэффициент 0.349 буюу эерэг, сул хамааралтай буюу өмнөх цалингийн хэмжээ нь одоогийн цалинтай сул хамааралтай байна.

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хүн ардын амьдралын хэмнэлт өөрчлөлт орж, энэхүү өөрчлөлттэй дасан зохицож ажил амьдралаа зохицуулах шаардлага үүссэн. ОТ-д ажиллаж буй ажиллагсдын өрхийн орлого 2019 онтой харьцуулахад 2020 онд өссөн. Мөн байгууллагын зүгээс ажиллагсдын урамшуулал, дэмжлэг үзүүлсэн нь өрхийн орлого тогтвортой байхад нөлөөлсөн.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ОТ-д ажиллагсдын өрхийн бусад гишүүдийн 60.8 хувийн ажлын цаг багасаж, 25.3 хувийн цалин буурснаар өрхийн амьжиргааны түвшин буурсан.

ОТ-н ажиллагсдын 65.3 хувь мэргэшүүлэх сургалтад хамрагдаж мэргэжил, ур чадвараа ахиулсаар байна. 2020 онд нэг ажилтан хамгийн ихдээ 4 сургалтад хамрагдсан.

Монгол Улсын хөдөлмөр эрхлэлт Ковид-19 цар тахлын нөлөөгөөр буурсан боловч ОТ компанийн ажиллагсдын тоо нэмэгдэж, цар тахлын нөлөөнд автахгүйгээр 2020 онд тогтвортой ажилласан. Үүний нэг нотолгоо бол талбай дээр байгаа ажилтан, дэлхийн өөр өнцөгт байгаа мэргэжилтнүүдтэй шууд харилцаж, бодит орчинд зааварчилгаа авах боломжтой болсон бөгөөд олон мянган долларын хэмнэлтийг бодитоор хийж чадсан. Үүний үр дүнд гүний уурхайн чухал байгууламжууд болох 1300 метрийн гүнд байрлах бутлуурын байгууламж, гүний уурхайгаас хүдэр гадарга руу тээвэрлэх, материал зөөвөрлөх туузан дамжуургын байгууламжуудын барилга угсралтын ажил, гүний уурхайн олборлолтын малтлага, бэхэлгээний ажлууд гэх зэрэг олон чухал хэтдээ Монгол улсын эдийн засагт том хувь нэмэр оруулах ажлууд эрчээ алдалгүй урагшилсан.

Оюу Толгой хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсын боловсролын салбарт хуримтлагдсан дүнгээр 120 сая ам.долларын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээс мэргэжлийн боловсролын салбарт 79.8 сая ам.долларын дэмжлэг үзүүлсэн. Дэлхийн ур чадварын тэмцээнд оролцох оролцогч нарын бэлтгэлд зориулж 139.0 мянган ам.долларын дэмжлэг үзүүлж, ОТ компанийн зүгээс оюутан, залууст зориулсан тэтгэлэгт хөтөлбөрт зориулан 2010 оноос хойш 4.3 сая ам.долларыг зарцуулснаар 2097 оюутан, залуусын мэргэжил, ур чадварыг сайжруулахад хөрөнгө оруулсан. Мөн Говийн тэтгэлэг болон шинэ төгсөгчийн хөтөлбөрт 641 оюутан, залуусыг хамруулжээ. Оюу толгой, Рио Тинто болон ШУТИС-тай хамтран хэрэгжүүлэх Уул уурхайн геотехникийн мэргэжил олгох, олон улсын судалгааны төв байгуулах төслийн хүрээнд 2.75 сая ам.долларын санхүүжилт хийхээр болсон.

2016-2020 оны хооронд ОТ компани аюулгүй ажиллагааны сургалтад 3,652.0 мянган ам.долларыг зарцуулсан. 2020 онд 800 мянган ам.долларын зардал гаргасан нь Ковид-19 цар тахлын өмнөх жилээс 15.8 хувиар өссөнийг харуулж байна.

ОТ компани Монгол ажиллагсдын ур чадварыг сайжруулах чиглэлээр олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсний үр дүнд Ковид-19 цар тахлын үед гүний уурхайн бүтээн байгуулалт тасалдалгүй үргэлжилж чадсан. Монгол ажиллагсад хүнд үед бие даан шийдвэр гарган амжилттай ажиллаж байна. Баяжуулах үйлдвэрийн ээлжит засвар үйлчилгээг аюул осолгүй, чанартай, хугацаанд нь гүйцэтгэж байгаа нь Монгол ажиллагсдын ур чадвар, дадлага туршлага сайжирсаар байгааг илтгэн харуулж байна. Гүний уурхайн бүтээн байгуулалт эхэлснээр Монгол ажиллагсад блокчлон олборлох технологи нэвтрүүлэн, шинэ ур чадвар эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэн ажиллаж байна.

Ковид-19 цар тахлаас хамаарч хөл хөдөлгөөнийг хязгаарласан нь эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, хөдөлмөр эрхлэлтэд сөргөөр нөлөөлж байгааг Чили, Перу зэрэг зэсийн үйлдвэрлэлээр тэргүүлж байгаа орнуудын жишээ харуулж байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тооцоолсноор хөдөлмөр эрхлэлт буурах хандлага ажиглагдаж байна. Иймээс эрсдэлийг тодорхойлох, хариу арга хэмжээ авах замаар үйлдвэрлэлийг тогтвортой үргэлжлүүлэхэд Ковид-19 цар тахлын эсрэг авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, нөлөөллийг багасгахад чиглэсэн арга хэмжээ авах, улмаар ажлын байрыг баталгаажуулах явдал чухал болж байна. Чили улсад цар тахлын улмаас ажлын байр их хэмжээгээр буурч байна. Перу улсад ч мөн адил ажиллагсдын тоог бууруулж байгаа нь цар тахлын үзүүлж буй нөлөө юм.

Цаашдын хандлага

ОТ компани нь Ковид-19 цар тахал болон зах зээлийн сорилтуудтай зохицон ажилласаар цар тахлын дараах хэвийн нөхцөлд шилжин ажиллах болно.

ОТ компанид ажиллаж байгаа монгол ажиллагсад 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт

ажиллагсдын 95.4 хувийг эзлэж байгаа бөгөөд ажиллахын зэрэгцээ мэдлэг ур чадвар, мэргэжлийн шаардлагын түвшинд дээшлүүлж, гадаад ажилтнуудыг орлон ажиллаж, бие даан шийдвэр гарган, аюулгүй ажиллагааг мөрдлөг болгон ажиллаж байгаа сайн туршлагыг ч бусад уул уурхайн компаниуд хэрэгжүүлэх боломжтой.

ОТ компанийн Монгол Улсын хүний хөгжилд оруулж байгаа хувь нэмэр нь тус компанийн ажиллагсдаар хязгаарлагдахгүйгээр орон нутгийн болон үндэсний хэмжээнд нөлөө үзүүлж байна. Ийнхүү хүний хөгжлөөр дамжуулан ОТ компани Монгол Улсын урт хугацааны хөгжил дэвшилд дэмжлэг үзүүлэх хандлага тогтворжих нь хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх эерэг нөлөөг хадгалахад туслах юм.

ОТ компанийн хөдөлмөр эрхлэлт Ковид-19 цар тахлын үед хэвийн явагдаж байна. Халдварын тархалтыг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээлэл түгээх, харилцаа холбоо тогтоох, цаг үеийн талаар мэдрэмжтэй ажиллаж байгаа бөгөөд ажлын байрыг хадгалж үлдсэнээр уг халдварын нийгэм, эдийн засгийн нөлөөг бууруулахад тустай юм. Ажиллагсад, ажил олгогчид хамтран ажиллагсдынхаа чадавхийг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа нь олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэмжээг мөрдүүлэх боломжийг олгож байна.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хөдөлмөр эрхлэлтийн одоогийн загварт орон нутгаас авах ажиллагсдын тоог нэмэгдүүлэх эсвэл зарим ажлын байрыг автоматжуулж, ажиллах хүчнийг багасгах чиглэлээр өөрчлөлт орох хандлагатай байна. Энэхүү өөрчлөлтөд зохицон орон нутаг болон дотоодын ажиллагсдын чадварыг сайжруулахад дахин анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн байдал Ковид-19 цар тахлын нөлөөгөөр буурсан бол ОТ компани цар тахлын нөлөөнд авталгүй 2020 онд тогтвортой ажиллаж чадсан.

V. ОЮУ ТОЛГОЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

5.1. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДНБ-Д ОЮУ ТОЛГОЙН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨЛӨЛ

Оюу Толгойн гэрээг 2009 он байгуулснаас хойшхи хугацаанд олон сая ам долларын хөрөнгө оруулалт хийсэн нь Өмнөговь аймгийн эдийн засгийн бүтцэд томоохон өөрчлөлт оруулж, уул уурхайн салбар өндөр хувь эзэлж байсан боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тогтворжиж эхлэхтэй холбоотойгоор бусад салбаруудын эзлэх хувийн жин нэмэгдэх болсон.

ОТ төсөл хэрэгжиж эхэлсэн эхний жилүүдэд уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин өндөр байсан ч цаашид буурч эхлэхэд мал аж ахуй, цахилгаан, барилга, худалдаа, тээвэр, санхүү, бусад үйлчилгээний салбарууд тасралтгүй өссөн. Энэ нь тодорхой хугацааны дараа үржүүлэгчийн нөлөөгөөр дамжин бусад салбаруудад жигд тархсан гэж үзэж болох юм.


Хүснэгт 5.1. Өмнөговь аймгийн ДНБ-ий салбарын бүтэц, хувиар

Салбар	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020*
Хөдөө аж ахуй	14.6	12.8	17.8	19.3	28.5	32.8	22.5	14.7	19.8	17.61	21.91
Газар тариалан	0.2	0.1	0.1	0.2	0.4	0.6	0.5	0.2	0.3	0.21	
Мал аж ахуй	14.1	12.7	17.7	19.1	28.1	32.1	21.9	14.5	19.6	17.4	
ХАА-н бусад	0.3	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	
Үйлдвэрлэл	71.7	67.7	56.6	59.9	33.8	20.9	42.9	57.5	48.1	46.62	43.61
Уул уурхай, олборлох	69.5	64.	38.9	47.	13.6	7.7	37.2	52.4	29.7	23.93	
Боловсруулах	1.9	4.2	14.2	9.6	14.2	6.	4.2	4.2	8.7	5.1	
Цахилгаан, хий, уур, усан хангамж;	0.1	-0.6	3.3	3.2	4.6	5.5	0.7	0.5	1.3	0.74	
Барилга	0.2	0.2	0.2	0.2	1.4	1.7	0.9	0.4	8.4	16.85	
Үйлчилгээ	13.7	19.5	25.6	20.8	37.6	46.3	34.7	27.8	32.1	35.77	34.48
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	3.5	3.4	4.	3.6	6.3	7.4	6.6	4.8	5.1	8.41	
Тээвэр, мэдээлэл, холбоо	1.3	8.6	9.7	4.9	7.7	7.7	5.2	3.4	7.4	8.19	
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	3.8	3.3	5.6	5.5	8.3	10.2	7.6	10.6	8.	7.52	
Бусад үйлчилгээ	5.1	4.1	6.3	6.8	15.4	21.1	15.3	9.	11.5	11.65	

*Эх сурвалж: ҮСХ * Өмнөговь аймгийн 2020 оны салбаруудын өсөлт бууралтыг ашиглан тооцсон судлаачийн тооцоо.*

Дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд аймгийн ДНБ-д тодорхой өөрчлөлт гарсан нь ажиглагдаж байна. Энд Монгол Улсад тогтоосон хөл хорио, хилийн хаалттай байдал зэргээс шалтгаалан аж үйлдвэрийн салбар, үйлчилгээний салбаруудын бүтэц өмнөх жилээс буурсан байхад, Ковид-19 цар тахлын нөлөө харьцангуй бага нөлөө үзүүлэх хөдөө аж ахуйн салбарын бүтцийг нэмэгдүүлж, 2016 оны ОТ гүний уурхайн хөрөнгө оруулалт хийгдэхээс өмнөх түвшинд хүрсэн.

Зураг 5.1. Өмнөговь аймгийн ДНБ, сая төгрөг



Эх сурвалж: УСХ, * Өмнөговь аймгийн 2020 оны салбаруудын өсөлт бууралтыг ашиглан тооцсон судлаачийн тооцоо.

Оюу Толгойн хөрөнгө оруулалтын бууралттай холбоотойгоор Өмнөговь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2013-2015 онуудад буурсан ч цаашид гүний уурхайн төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эрчимтэй өсөх болсон.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Өмнөговь аймгийн ДНБ нь 23.2 хувиар агшихаар байгаа нь улсын дүнгээс даруй 4 дахин өндөр байна. Үүнийг гол шалтгаан нь ДНБ-ий бүтцэд өндөр хувь эзэлдэг аж үйлдвэрийн дүн 62.9 хувь болж 37.1 хувиар буурсантай холбоотой байна.

Өмнөговь аймгийн төсвийн орлогод Оюу Толгойн оруулсан хувь нэмрийг харуулахдаа гуравдугаар баганад Өмнөговь аймгийн төсвийн орлогоос Оюу Толгойгоос Өмнөговь аймагт төлсөн татварын дүнг хассан үзүүлэлт; дөрөвдүгээр баганад Оюу Толгойгоос Өмнөговь аймагт төлсөн татварын дүнг Оюу Толгойгүй үеийн Өмнөговь аймгийн төсвийн орлогод харьцуулсан харьцааг, тавдугаар баганад Оюу Толгойн Өмнөговь аймагт төлсөн татвар болон Оюу Толгойгүй үеийн Өмнөговь аймгийн төсвийн орлогын харьцааг харуулсан.

Өмнөговь аймгийн төсвийн орлого 2018 он хүртэл тасралтгүй өсөж байсан боловч 2019, 2020 онд буурсан. Хэдийгээр Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд төсвийн орлого буурсан байж болох боловч Оюу Толгойн татвар, төлбөр хураамж хэлбэрээр аймгийн төсөвт төлсөн дүн тасралтгүй нэмэгдэж иржээ. Оюу Толгойн аймгийн төсөвт оруулсан татвар хураамжийн дүн жил болгон нэмэгдэж эзлэх хувийн жин 2018, 2019, 2020 онд харгалзан 31 хувь, 43 хувь, 47 хувь болжээ. Энэ хэвээр үргэлжилбэл 2021 онд аймгийн төсвийн 50 хувийг Оюу Толгой дангаар бүрдүүлэх түвшинд хүрэхээр байна.

Хэрэв Оюу Толгой хэрэгжээгүй бол 2010-2020 оны дунджаар Өмнөговь аймаг төсвийн орлогынхоо 46³⁴ хувийг алдахаар байна. ОТ хэрэгжээд хэрэв томоохон хөрөнгө оруулалт хийгдээгүй байсан бол 2013-2017 оны дунджаар Өмнөговь аймаг төсвийн орлогынхоо 55³⁵ хувийг алдахаар байжээ. Энэ үзүүлэлтийг Ковид-19 цар тахлын өмнөх 2019 оноо авч үзвэл 77 хувь байгаа бол 2020 онд 88 хувь байгаа нь Оюу Толгойн аймгийн төсөв оруулж байгаа хувь нэмэр маш өндөр болохыг харуулж байна.

34 $(6\%+6\%+14\%+51\%+42\%+69\%+53\%+59\%+45\%+77\%+88\%)/11=46\%$

35 $(51\%+42\%+69\%+53\%+59\%)/5=55\%$

Хүснэгт 5.2. Өмнөговь аймгийн төсвийн орлогод ОТ компанийн оруулсан хувь нэмэр, сая төгрөг


Он	Өмнөговь аймгийн төсвийн орлого, сая төг (I)	ОТ компаниас Өмнөговь аймагт төлсөн татварын дүн, сая төгрөг (II)	ОТ компанигүй үеийн Өмнөговь аймгийн төсвийн орлого, сая төг (III)=(I)-(II)	Хувийн жин (I)/(II) (IV)	Харьцаа (II)/(III) (V)
2000	794		794	0%	0%
2001	1,250		1,250	0%	0%
2002	1,536		1,536	0%	0%
2003	893		893	0%	0%
2004	1,646		1,646	0%	0%
2005	2,255		2,255	0%	0%
2006	4,211		4,211	0%	0%
2007	7,911		7,911	0%	0%
2008	13,672		13,672	0%	0%
2009	24,862		24,862	0%	0%
2010	40,858	2,236	38,622	5%	6%
2011	108,963	6,235	102,728	6%	6%
2012	109,453	13,642	95,811	12%	14%
2013	102,514	34,649	67,865	34%	51%
2014	107,951	31,775	76,176	29%	42%
2015	94,645	38,722	55,923	41%	69%
2016	114,508	39,475	75,033	34%	53%
2017	147,722	54,876	92,846	37%	59%
2018	163,718	50,891	112,827	31%	45%
2019	135,630	58,997	76,633	43%	77%
2020	128,900	60,221	68,679	47%	88%

Эх сурвалж: Өмнөговь аймгийн статистик, ОТ ХХК

Оюу Толгой хэрэгжээгүй тохиолдолд Өмнөговь аймгийн ДНБ ямар байх байсан төсөөллийг гаргахдаа ДНБ-д нөлөөлөх хүчин зүйлсийг сонгон авч регрессийн загварыг үнэлж судлаачийн зүгээс тооцооллыг хийж гүйцэтгэлээ.

Зурагт цэнхэр өнгийн шугам нь Өмнөговь аймгийн нэрлэсэн ДНБ, ягаан шугам нь регрессийн загвараас Оюу Толгойн нөлөөг оруулаагүй үеийн нэрлэсэн ДНБ-ийг илэрхийлж байгаа болно.

Зураг 5.2. Өмнөговь аймгийн ДНБ, ОТ нөлөөтэй, нөлөөгүй үеийн харьцуулалт



Эх сурвалж: ҮСХ, ОТ ХХК, * Өмнөговь аймгийн 2020 оны салбаруудын өсөлт бууралтыг ашиглан тооцсон судлаачийн тооцоо. Оюу Толгойгүй үеийн ДНБ судлаачийн тооцоо

Гүний уурхайн бүтээн байгуулалт эрчимжиж эхэлсэн 2017 оноос аймгийн ДНБ-д үзүүлсэн Оюу Толгойн нөлөө нэмэгдэж эхэлсэн болох нь харагдаж байна. Оюу Толгойн нөлөө байгаагүй бол 2017-2020 оны хооронд ДНБ нь дунджаар 1.8 дахин бага байхаар байв.

Ковид-19 цар тахлын өмнөх жил болох 2019 онд Оюу Толгойн нөлөөг тооцоогүй тохиолдолд аймгийн ДНБ нь 2.18 дахин бага байхаар байсан бол Ковид-19 болсон жил болох 2020 онд 1.76 дахин бага байхаар байжээ.

Хүснэгт 5.3. Оюу Толгойтой болон Оюу Толгойгүй үеийн эдийн засгийн өсөлт

Он	Өмнөговь аймгийн эдийн засгийн өсөлт	ОТ төсөл хэрэгжээгүй үеийн Өмнөговь аймгийн эдийн засгийн өсөлт
2001	0.6%	-4.1%
2002	-20.4%	-22.4%
2003	3.2%	16.1%
2004	44.7%	17.2%
2005	26.6%	22.1%
2006	3.5%	11.8%
2007	20.5%	14.0%
2008	9.1%	-2.4%
2009	23.1%	7.5%
2010	19.1%	2.6%
2011	27.5%	16.5%
2012	-11.3%	27.1%
2013	19.2%	14.6%
2014	-37.5%	-22.5%
2015	-19.4%	-26.2%
2016	34.0%	19.7%
2017	47.6%	2.3%
2018	-15.08%	-0.58%
2019	14.65%	-22.34%
2020	-26.70%	-12.69%
Дундаж	8.15%	2.9%

Эх сурвалж: ҮСХ, Судлаачийн тооцоо

Урт хугацаанд Оюу Толгойн оролцоогүй байх тохиолдолд Өмнөговь аймгийн эдийн засгийн өсөлт 20 жилд 2.9 хувь байхаар байсан бол Оюу Толгойн төсөл хэрэгжиж эхэлснээр аймгийн эдийн засгийн өсөлт 8.15 хувьд хүрсэн. Эдгээрийг гэхдээ дотор нь хугацаагаар нь задалж хугацааны үечлэлээр авч үзвэл ялгаатай гарна.

5.2. ОЮУ ТОЛГОЙН БҮС НУТАГТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Өмнөговь аймаг нь бүсийн хувьд Монгол Улсын Төвийн бүсэд харьяалагддаг. Оюу Толгойн оруулсан хөрөнгө оруулалт, худалдан авалт, төлсөн татвар, хураамж, төлбөрийн дүнгээр Өмнөговь аймгийн ДНБ болон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг нэмэгдүүлж энэ нь эргээд бүс нутагт эзлэх Өмнөговь аймгийн цар хүрээг нэмэгдүүлж байна гэж үзэж тооцоог хийв. Төвийн бүсийн ДНБ-д Өмнөговь аймгийн ДНБ-ий эзлэх хувийн жин 2000 онд 10.73 хувь буюу Говьсүмбэр, Дундговь аймгийн өмнө орж байсан бол 2019 он гэхэд Төвийн бүсдээ тэргүүлэх эдийн засагтай аймаг болж чадсан.


Хүснэгт 5.4. Төвийн бүсийн аймгуудын бүсийн ДНБ-д эзлэх хувь

Аймаг	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019
Төвийн бүс	11.63	9.8	12.09	10.14	10.19	10.3	9.74	10.13
Дорноговь	11.45	9.56	8.98	11.13	11.16	10.31	11.67	10.78
Дундговь	9.11	12.79	5.89	10.12	9.27	8.99	10.4	10.15
Өмнөговь	10.73	16.07	20.23	11.98	16.57	24.89	20.84	21.84
Сэлэнгэ	25.36	19.59	33.5	24.47	22.77	20.84	21.85	21.25
Төв	22.48	20.07	15.02	23.11	20.93	17.78	18.83	17.97
Дархан-Уул	18.01	18.42	13.88	15.64	15.88	14.27	13.58	15.03
Говьсүмбэр	2.86	3.5	2.49	3.57	3.42	2.92	2.82	2.99

Эх үүсвэр: YCX

Оюу Толгойн хөрөнгө оруулалт хийгдэж эхэлсэнтэй холбоотойгоор Өмнөговь аймгийн эдийн засгийн өсөлт хурдсаж Төвийн бүсийн ДНБ-д эзлэх хувьд 2011 оныг дуустал нэмэгдэж ирсэн боловч тодорхой хугацаанд энэ хувь буурч, 2017 оноос далд уурхайн бүтээн байгуулалт эхэлсэнтэй холбоотойгоор өсөж байгаа нь зургаас харагдаж байна.

Зураг 5.3. Өмнөговь аймгийн Төвийн бүсийн ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: YCX

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг харвал 2019 оны Ковид-19 цар тахлын өмнөх жилд улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар хотын дараа гуравдугаарт Өмнөговь аймаг (20316.9, 16960.1, 11870.5) орж байна.


Хүснэгт 5.5. Төвийн бүсийн нэг хүнд ногдох ДНБ (мянган төгрөг)

Аймаг	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	522.2	1223.0	3697.6	7810.3	7910.0	8999.1	10259.8	11680.6
Төвийн бүс	321.7	694.0	2688.9	4927.8	5033.2	5772.0	6223.1	7423.4
Дорноговь	322.9	545.8	1838.9	4127.7	4197.8	4392.0	5347.8	5840.9
Дундговь	253.1	831.9	1759.6	5375.6	5041.0	5618.8	7044.6	8199.1
Өмнөговь	327.5	930.0	3988.4	4647.9	6463.1	11050.8	9762.2	11870.5
Сэлэнгэ	362.9	613.1	4156.4	5472.2	5254.7	5553.3	6325.7	7398.9
Төв	322.9	703.0	2121.8	6034.9	5592.8	5450.8	6272.1	7241.7
Дархан-Уул	293.5	626.4	1815.4	3766.1	3921.9	4061.4	4157.3	5499.6
Говьсүмбэр	333.1	872.3	2269.6	5200.3	5015.0	4890.7	5110.4	6463.8
Улаанбаатар	884.9	1852.4	5398.5	11251.7	11519.7	12940.7	15031.0	16960.1

Эх үүсвэр: УСХ

Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох ДНБ нь Оюу Толгойн хөрөнгө оруулалттай холбоотойгоор нилээд хэлбэлзэлтэй байсан.

Зураг 5.4. Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох ДНБ (мянган төгрөг)




Эх сурвалж: УСХ

Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох ДНБ нь Төвийн бүсийн дундажтай харьцуулахад 2015 оноос бусад тохиолдолд өндөр явж ирсэн бөгөөд улсын дундажтай харьцуулахад улсын дундаж орчим буюу түүнээс дээш байж иржээ.

5.3. ЦАР ТАХЛЫН ҮЕД ОТ-Н ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Өмнөговь аймагт манай улсын томоохон уул уурхайн төслүүд хэрэгжиж байгаатай холбоотойгоор тус аймаг нийгэм, эдийн засгийн хөгжлөөрөө улсдаа дээгүүр байранд орж байна. Манай улсын нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 онд 4,9 сая төгрөг байсан бол 2019 онд 11,7 сая төгрөг болон өссөн. Харин Өмнөговь аймгийн хувьд 2011 онд 5,8 сая төгрөг байсан бол 2019 оны байдлаар 11,9 сая төгрөг болон өссөн үзүүлэлтийг харахад Өмнөговь аймгийн хувьд улсын дундаж өсөлттэй ойролцоо өсөлттэй байна.

Зураг 5.5. Өмнөговь аймаг болон Монгол Улсын нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ, 2011-2019




Эх сурвалж: Судлаачид, ҮСХ-ны өгөгдлийг ашигласан.

Томоохон уул уурхайн төслийг хэрэгжүүлснээр тухайн улс, орон нутаг төсвийн орлого, засгийн газрын эзэмших хувь, орон нутгийн худалдан авалт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлт болон орон нутгийн оролцоогоор дамжуулан үр ашиг хүртдэг туршлага олон улсад бий.

Орон нутгийн худалдан авалт болон орон нутгийн оролцоогоор дамжуулан Өмнөговь аймгийн уул уурхайн бус бизнесийн салбарт ОТ компанийн үзүүлж буй нөлөөг хоёрдогч болон анхдагч өгөгдөлд суурилан тооцооллыг гаргахаар зорив. Өмнөговь аймагт уул уурхайн төслүүдийг даган, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих бараа, үйлчилгээ нийлүүлэгч компани, АНН-ийн тоо 2011 эхлэн огцом нэмэгдсэн. Өмнөговь аймагт бүртгэлтэй компани тоо сүүлийн 5 жилд 1063 - 1750 хүртэл нэмэгдсэн. Эдгээр компанийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарыг авч үзэхэд бөөний болон жижиглэн худалдаа - 683, Боловсруулах үйлдвэрлэл - 141, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа - 165, барилгын- 71 компани³⁶ байна.

Орон нутгийн хөгжлийг зөвхөн нэг хүнд ноогдох ДНБ-ээр хэмжихээс гадна микро эдийн засгийн үзүүлэлтээр хэмждэг. Үүнд: тухайн орон нутгийн эдийн засгийн салбаруудад үйл ажиллагаа явуулж буй компанийн тооны өсөлт, тухайн салбарт ажиллаж буй ажиллагсдын тооны өсөлт болон тэдгээрийн дундаж цалингийн өсөлтөөр амьдралын чанарын үзүүлэлтийг харуулж байна. Үйл ажиллагаа явуулж буй компанийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор Өмнөговь аймгийн ДНБ-д эдийн засгийн үйл ажиллагаанд харьцангуй өөрчлөлт ажиглагдсан. Сүүлийн жилүүдэд санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа тэлж байгаа хэдий ч Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бага зэрэг агшсан.

Зураг 5.6. Өмнөговь аймгийн ДНБ-ийг бүрдүүлэгч эдийн салбарын бүтэц, 2011-2019

Эх сурвалж: www.1212.mn


ҮСХ нь нийт 11 дэд салбарын хэмжээнд зах зээлийн үнэд суурилан аймгуудын үйлдвэрлэл, үйлчилгээг харуулж байгаад тулгуурлан Өмнөговь аймгийн эдийн засгийн салбарын бүтцийг авч үзвэл, 2011-2019 оны хооронд голлох салбар болох уул уурхайн салбарын үйлдвэрлэлээс гадна МАА-н салбарын ДНБ-д үзүүлэх нөлөөлөл ихэссэн. Үйлчилгээний салбарт багтах санхүү, бизнесийн үйлчилгээ, тээвэр, мэдээлэл, холбоо болон худалдаа, зочид буудал, зоогийн газар гэсэн дэд салбаруудын үйлдвэрлэл харьцангуй тогтвортой өсөлттэй байгаа бөгөөд Өмнөговь аймгийн ДНБ-д 5-10 хувийг эзэлж байна. Ковид-19 цар тахлын өмнөх үед аймгийн ДНБ-д голлох нөлөөтэй уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурсан бол барилгын салбарын үйлдвэрлэлийн өсөлт хэвээр хадгалагдсан³⁷.

Өмнөговь аймгийн эдийн засгийн салбарын жилийн нийлмэл өсөлтийн хувийн (CAGR) дундаж утга 15 хувь³⁸ байна. Өөрөөр хэлбэл, тус аймгийн эдийн засгийн салбарууд 2015-2019 онуудад жилд дунджаар 15 хувийн өсөлттэй байсан. Зураг 5.7-д Өмнөговь аймгийн ДНБ-д эзлэх салбарын хувийг босоо тэнхлэгт 2019 оны байдлаар, харин хэвтээ тэнхлэгт 2015-2019 онуудад салбаруудад гарсан жилийн нийлмэл өсөлтийг харуулсан ба бөмбөлгийн хэмжээгээр 2019 оны байдлаар салбаруудын үйлдвэрлэлийн хэмжээг дүрслэн үзүүлэв. Тус аймгийн хүрээнд барилгын салбарт хамгийн өндөр 88 хувь (CAGR) байгаа бөгөөд аймгийн ДНБ-д 17 хувийг эзэлж байна. Уул уурхайн салбарын жилийн нийлмэл өсөлтийн хувь 50; худалдаа, үйлчилгээний салбар 23 хувь; тээвэр, мэдээлэл, холбоо 21 хувийн динамик өсөлттэй байна. Харин МАА болон газар тариалан салбарын өсөлтийн хувь 6 хувийн үзүүлэлттэй байна. Мөн цахилгаан эрчим хүчний салбарын өсөлт -20 хувьтай байгаа нь анхаарал татаж байна. Дээрх шинжилгээг хийхдээ ҮСХ-ны жил бүрийн статистик мэдээллээс Өмнөговь аймгийн ДНБ-ийг зах зээлийн үнээр 3 салбар, 11 дэд салбарын хүрээнд гарах өгөгдөлд суурилсан. Энэхүү шинжилгээнд инфляцийн нөлөөг арилгах зорилготойгоор 2015 оныг суурь он болгон аймгийн хэрэглэгчийн үнийн индексээр засварласан болно.

37 Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

38 Christian Ketels, Clusters, Cluster Policy, and Swedish Competitiveness in the Global Economy, 2012

Зураг 5.7. Өмнөговь аймгийн ДНБ-ийг бүрдүүлэгч эдийн засгийн салбаруудын динамик өөрчлөлт, 2015-2019




Эх сурвалж: Судлаач

Цаашид тээвэр, мэдээлэл, холбоо; санхүү, бизнесийн үйл ажиллагаа; худалдаа, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ нь жилийн дундаж өсөлтөөрөө нэмэгдэх хандлагатай байна.

Дээрх зурагт аймгийн хэмжээн дэх эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг үйлдвэрлэлийн хэмжээгээр илэрхийлсэн бол тухайн салбарт үүсэж буй ажлын байр болон ажиллагсдын тоо орон нутгийн хөгжлийг харуулах дараагийн үзүүлэлт бол салбарын хөдөлмөр эрхлэлт юм. Өмнөговь аймгийн хувьд 2019 оны байдлаар манай улсын нийт хөдөлмөр эрхэлж байгаа ажиллах хүчний 2,66 хувь буюу 30517 хүн ажил эрхэлж байна. 2019 оны байдлаар нийт хөдөлмөр эрхлэлтийн 31 хувь ХАА, 14 хувь уул уурхай, 10 хувь бөөний болон жижиглэн худалдаа, 7,3 хувь тээвэр болон агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг салбарт ажиллаж байна. Харин жилийн нийлмэл өсөлтийн хувийг авч үзэхэд барилгын салбарын хөдөлмөр эрхлэлт 14 хувь, уул уурхайн 12 хувь, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа 13 хувь, тээвэр болон агуулахын үйл ажиллагаа 8 хувийн өсөлттэй байна. Мөн ажиллагсдын тоо 2009-2019 оны байдлаар жилийн нийлмэл өсөлтийн хувь нь ХАА, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий уур, агааржуулалт гэсэн салбаруудад тэгтэй ойролцоо буюу өсөлтгүй байна. Жилийн нийлмэл өсөлтийн хувь жижиглэн болон бөөний худалдааны салбарт -5 хувь, мэдээлэл, холбооны салбарт -24 хувь, удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт -25 хувийн өөрчлөлттэй байна.


Зураг 5.8. Өмнөговь аймгийн эдийн засгийн салбаруудад ажиллаж буй ажиллагсдын жилийн нийлмэл өсөлтийн хувь, 2009-2019



Эх сурвалж: Судлаач

Сүүлийн арван жилд Өмнөговь аймгийн кластерын хөгжлийн түвшинг төрөлжилтийн (Location Quotient (LQ)) коэффициентийг ашиглан тогтсон, өөрчлөгдөж буй, үүсэж буй, од кластерын ангиллаар үзүүлэв.

Зураг 5.9. Өмнөговь аймгийн эдийн засгийн төрөлжилт, кластерын шинжилгээ, 2000-2019



Эх сурвалж: Судлаач

Өмнөговь аймагт 2009-2019 оны хооронд барилгын кластер шинээр үүсэн хөгжиж байна. Харин өсөлтийн хурд болон ажиллах хүчний шингээлтээрээ ХАА, уул уурхай, тээвэр, агуулах, зочид буудал, нийтийн хоол болон эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбар нь аймгийн түвшинд “од” кластерын

ангилалд багтаж байна. Эдгээр салбарт ажиллагсдын тоо хангалттай, тиймээс өрсөлдөх чадварыг илүү бэхжүүлэх стратегийг хэрэгжүүлж болох юм. Харин өөрчлөгдөж буй кластерт эдийн бусад салбар орж байгаа бөгөөд бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн цахилгаан, хий, уур, усан хангамж гэсэн салбарууд багтаж байна. Эдгээр салбарын хөдөлмөр эрхлэлт тогтворжих түвшинд хүрээгүй байгаа тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шаардлагатай.

LQ нь тухайн бүс нутаг, эсвэл кластерыг улсын хэмжээтэй харьцуулахад тухайн бүс нутаг дахь эдийн засгийн үйл ажиллагааны түвшинг ($LQ \geq 1$) илэрхийлж, 2019 оны хувьд Өмнөговь аймгийн эдийн засгийн салбаруудын үйлдвэрлэл өрсөлдөх түвшинд (шараар илэрхийлсэн мөрүүдэд) байгаа эсэхийг харуулна. Энэ утга нэг рүү дөхөхөд аймгийн эдийн засгийн үйл ажиллагаа нь бүс нутаг болон үндэсний эдийн засгийн үйл ажиллагаа руу хүрэх юм.

Хүснэгт 5.6. Өмнөговь аймгийн эдийн засгийн үйл ажиллагаа, 2019

Салбар	Дорноговь	Өмнөговь	Говьсүмбэр	Орхон
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.17	1.22	1.18	0.21
Уул уурхай, олборлолт	0.89	2.93	3.09	3.88
Боловсруулах үйлдвэрлэл	0.82	0.34	0.55	1.58
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.06	1.49	2.03	0.70
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, ХХМ	1.49	1.42	1.58	1.43
Барилга	0.18	0.27	0.28	1.00
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1.12	0.71	0.76	1.22
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.62	1.38	1.16	0.89
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.74	1.08	0.47	0.91
Мэдээлэл, холбоо	0.00	0.02	0.19	0.68
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.52	1.02	1.03	0.44
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.00	0.00	0.00	0.00
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.00	0.58	0.53	0.11
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.02	0.04	0.13	0.90
Төрийн удирдлага ба батлан хамгаалах ҮА, нийгмийн хамгаалал	0.61	0.90	1.09	0.90
Боловсрол	0.59	0.94	0.98	1.57
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.31	1.12	0.12	0.56
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.49	0.56	0.00	0.60
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.29	1.09	2.02	1.39
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	7.51	0.00	1.83	0.00

Эх сурвалж: Судлаач

Өмнөговь аймгийн эдийн засгийн үйл ажиллагаа ОТ компани бүтээн байгуулалттай холбоотойгоор орон нутгийн худалдан авалтыг олон улсын түвшний шаардлагын дагуу дэмжсэн. Үүний үр дүнд аймгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын бараа, үйлчилгээний чанар, стандарт сайжирч, үйл ажиллагаа өргөжин, улмаар ААНБ-ын өрсөлдөх чадвар сайжирсаар байна. Аймгийн хэмжээнд ОТ ханган нийлүүлэгч компаниудын өрсөлдөх чадвар сайжирснаар орон нутгийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн, амьжиргааны түвшин болон төрөлжилтийн түвшинд эерэг нөлөө үзүүлдэг.

Бүлгийн дүгнэлт

Өмнөговь аймгийн ДНБ, төсвийн орлогын өсөлт бууралт нь Оюу Толгойн үйл ажиллагаатай нягт холбоотой байна. Судалгааны үр дүнгээс харвал Оюу Толгойн нөлөө байгаагүй бол 2017-2020 оны хооронд аймгийн ДНБ нь дунджаар 1.8 дахин бага байхаар байв.

Ковид-19 цар тахлын өмнөх жил болох 2019 онд Оюу Толгойн нөлөөг тооцоогүй тохиолдолд аймгийн ДНБ нь 2.18 дахин бага байхаар байсан бол Ковид-19 болсон жил болох 2020 онд 1.76 дахин бага байхаар байжээ.

Өмнөговь аймагт Оюу Толгой төсөл хэрэгжээгүй бол 2010-2020 оны дунджаар Өмнөговь аймагт төсвийн орлогынхоо 46³⁹ хувийг алдахаар байна. Энэ үзүүлэлтийг Ковид-19 цар тахлын өмнөх 2019 оноор авч үзвэл 77 хувь байгаа бол цар тахлын үеийн 2020 онд 88 хувь байгаа нь Оюу Толгойн аймгийн төсөвт оруулж байгаа хувь нэмэр маш өндөр байгааг харуулж байна.

Өмнөговь аймгийн эдийн засгийн салбаруудын хөгжлийг авч үзэхэд ХАА-н салбар манай улсын бусад аймгуудын адил томоохон байр суурь эзэлж байгаа боловч үйлдвэрлэлийн болон ажиллагсдын тоо төдийлөн нэмэгдэхгүй байгаа бөгөөд энэхүү салбараас ажиллах хүчин гадагшилж байгааг харуулж байна. Харин уул уурхай, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, нийтийн хоол болон тээвэр, агуулахын салбар өндөр өсөлттэй байна. Боловсруулах үйлдвэрлэлийн өсөлт дундаж байна.

Өмнөговь аймгийн кластержилтийн үйл явцыг харахад уул уурхайн үйлдвэрлэлийн дагасан барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон зочид буудал нийтийн хоолны гэх зэрэг аж үйлдвэрлэлийн туслах салбаруудын хөгжил түвшин өндөр байна.

Өмнөговь аймагт манай улсын томоохон уул уурхайн төслүүд хэрэгжиж байгаатай холбоотойгоор эдийн засгийн төрөлжилтийн түвшин бусад аймагтай харьцуулахад өндөр байгаа бөгөөд ирээдүйд томоохон бүс нутгийн боловсруулах үйлдвэрлэл, тээвэр, логистикийн хөгжлийн төв болох эх тавигдаж байна.

Цаашдын хандлага

Өмнөговь аймгийн үйлдвэрлэлийн хэмжээ болон хүн амын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор цахилгаан, эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Уул уурхайн үйлдвэрлэлийн дэмжих боловсруулах үйлдвэрлэлийн хөгжлийг цаашид дэмжин, орон нутагт уул уурхайн тоног төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгслийн үйлдвэрлэл, оёдлын үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэлийг кластерын хөгжлийн загвараар хөгжүүлэх боломжтой юм.

Салбар дундын хөгжлийг үйл ажиллагаа нь тэлж буй тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон зочид буудал, нийтийн хоолны салбарын хөгжилд суурилан нутгийн иргэдийн оролцоог хангасан аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх боломжтой.

Өмнөговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй компанийн тоо нэмэгдэж буй боловч, бичил, жижиг бизнес эрхлэгчид зонхилж байгаа тул тэдгээрийг чадавхижуулах, хамтын ажиллагааг сайжруулах, орон нутгийн боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүжилт, татварын хөнгөлөлт зэрэг эдийн засгийн хөшүүргийг ашиглах боломжтой.


Зарим салбарын хөдөлмөр эрхлэлт тогтвортой түвшинд хүрээгүй байгаад анхаарал хандуулж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх салбарын хөдөлмөр эрхлэлтийг нэн тэргүүнд дэмжих шаардлагатай.

VI. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ОТ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

6.1. ОТ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Ковид-19 цар тахлын ОТ компани ба ханган нийлүүлэгчдийн хамтын үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг илрүүлэхээр онлайн түүвэр судалгааг явууллаа. Түүвэр судалгаагаар ОТ-н ханган нийлүүлэгчдийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй шууд, шууд бус, дам нөлөөлөл Ковид-19 цар тахлын үед тодорхойлох зорилготой байсан. ОТ-той хамтран ажилладаг нийт 156 аж ахуй нэгж байгууллага түүвэр судалгаанд хамрагдсан. Үүнээс 2 байгууллага хариулт өгөхөөс татгалзсан тул 154⁴⁰ байгууллагын мэдээлэлд боловсруулалт хийв.


Зураг 6.1. Ханган нийлүүлэгчдийн байгуулагдсан он



Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 11 хувь (17 ААНБ) нь 2000 оноос өмнө, 36.4 хувь (56 ААНБ) нь 2001-2010 оны хооронд, 33.1 хувь (51 ААНБ) нь 2011-2015 оны хооронд, 19.5 хувь (30 ААНБ) нь сүүлийн таван жилд байгуулагджээ. Хамтран ажиллагч байгууллагуудаас анхдагч нь 1936 онд байгуулагдсан “боловсруулах үйлдвэрлэл” буюу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж бол хамгийн залуу нь 2020 онд байгуулагдсан дотоодын, бөөний ба жижиглэнгийн худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж байгууллага байна.

ОТ-н хамтын ажиллагааны ерөнхий зүй тогтлыг харвал хамтран удаан хугацаанд ажилласан байгууллагатайгаа илүү урт хугацаанд түншлэх хандлага ажиглагдаж байна. Урт хугацаанд үйл ажиллагаа явуулсан туршлагатай байна гэдэг нь ОТ-той хамтран ажиллах тодорхой хүчин зүйл болдог.

Зураг 6.2. Ханган нийлүүлэгчдийн байгуулагдсан он, хамтран ажиллаж буй жил



40 Судалгааг санамсаргүй түүврийн аргаар авсан ба зайлшгүй шаардагдах түүврийн хэмжээ 90 байв. Түлхүүр үзүүлэлтээр нийт ААН-үүдийн ажиллагсдаа цомхотгохгүй байх хувийг сонгосон ба ҮСХ-ны “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд корона вирус (Covid-19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл 3 дахь шатны тандалт судалгаа”-ны дүнг ашигласан. Мөн судалгаанд оролцогчдын асуулгад хариулахгүй байх магадлалыг 20 хувь байхаар тооцож, 99 хувийн итгэх магадлалтайгаар алдааны хязгаар 9 хувиас хэтрэхгүй байхаар тооцоог хийсэн.


1936 онд байгуулагдсан аж ахуй нэгж ОТ-той 5 жил хамтран ажиллаж байна. ОТ-той 5 жилээс дээш хугацаанд ханган нийлүүлэлт хийж байгаа 96 компани байгаа бөгөөд эдгээрийн 33-тай нь 10 жил ба түүнээс урт хугацаанд хамтарч ажиллаж байна. ОТ ханган нийлүүлэгчдийнхээ хувьд урт хугацааны тогтвортой ажлын байртай байхад нөлөөлдөг. ОТ-той 10 ба түүнээс дээш жил хамтран ажиллаж байгаа ханган нийлүүлэгчдийн нийлүүлдэг бүтээгдэхүүн үйлчилгээний төрлүүдийг жилээр эрэмбэлэн харуулав.

Хүснэгт 6.1. Ханган нийлүүлдэг бүтээгдэхүүн үйлчилгээ болон хамтран ажиллаж буй хугацаа

Байгаль орчны мониторинг, геологи	24 жил
Автомашин, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийн нийлүүлэлт, засвар	23 жил
Харуул хамгаалалтын үйлчилгээ	16 жил
Цахилгаан, дулаан болон ус хангамжийн бүх төрлийн үйлчилгээ	15 жил
Барилга угсралт түүнтэй холбоотой үйл ажиллагаа	15 жил
Хүнсний бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт	10 жил
Цахилгаан бараа болон тавилга ханган нийлүүлэлт	11 жил
Био жорлонгийн үйлчилгээ	12 жил
Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн нийлүүлэлт	10 жил
Санхүү, даатгалын үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ	10 жил

Ханган нийлүүлэгчдийн байршлыг авч үзвэл Өмнөговь болон Ханбогд суманд бүртгэлтэй байгууллагууд нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудын 23 хувийг бүрдүүлж байгаа бол Улаанбаатар хотод харьяалалтай компаниуд дийлэнх нь буюу 73 хувь байна. Түүнчлэн ханган нийлүүлэгч 4 байгууллага тутмын 1 нь орон нутагт харьяалалтай байна.

Зураг 6.3. Ханган нийлүүлэгчдийн татварын бүртгэлтэй газар /хувиар/




Хариуцлагын хэлбэрээр авч үзвэл 1 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1 нь төрийн бус байгууллага гэж бүртгүүлсэн бол үлдэх 152 нь компани гэсэн хариуцлагын хэлбэртэй байна. Уг байгууллагуудын 92.3 хувь буюу 142 нь дотоодын, 5.1 хувь буюу 8 нь гадаадын, 2.6 хувь буюу 4 нь хамтарсан хөрөнгө оруулалтын хэлбэртэй байна.


Хүснэгт 6.2. Ханган нийлүүлэгчдийн хариуцлага болон хөрөнгө оруулалтын хэлбэр

	Гадаад	Дотоод	Хамтарсан	Нийт
Компани	8	140	4	152
Төрийн бус байгууллага	0	1	0	1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	0	1	0	1
Нийт	8	142	4	154

Үйл ажиллагааны төрлөөр нь ангилбал бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг болон үйлчилгээний бусад үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хамгийн олон давтагдаж байна. Түүнчлэн цахилгаан, ус хангамж, мэргэжлийн шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа, барилга, уул уурхайн олборлолт, тээвэр агуулахын салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд судалгаанд түлхүү хамрагджээ. Судалгаанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч нь орчуулгын үйлчилгээ үзүүлдэг бол ТББ нь хэвлэл мэдээллийн хяналтын үйлчилгээ болон орчуулгын үйлчилгээ ханган нийлүүлдэг.

Зураг 6.4. Ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагааны төрөл /давхардсан тоон утгаар/

Ханган нийлүүлэгч байгууллагуудыг үйл ажиллагааны хүрээгээр нь авч үзвэл зөвхөн нэг төрлийн үйл ажиллагаа явуулдаг 93 байгууллага - 61 хувь, 2 төрлийн үйл ажиллагаа явуулдаг 33 байгууллага - 22 хувийг эзэлж байгаа бол 6, 7, 12 төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага тус бүр нэг нэг байна. 12 төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь ОТ-д зөвлөх үйлчилгээ болон инженерийн зураг төслийн үйлчилгээ үзүүлдэг байна.

Зураг 6.5. Үйл ажиллагааны хүрээний төрөл


Эдгээр 154 ханган нийлүүлэгчдийн ОТ-д нийлүүлдэг гол гол бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг нэгтгэн давтагдах байдлаар нь хамгийн их нийлүүлдгээс бага нийлүүлдэг рүү нь эрэмбэлэн үзүүлье. Үүнд:

1. Автомашин, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийн нийлүүлэлт, засвар үйлчилгээ
2. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн нийлүүлэлт
3. Санхүү, даатгалын үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ
4. Цахилгаан, дулаан болон ус хангамжийн бүх төрлийн үйлчилгээ
5. Хүнсний бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт
6. Судалгаа болон сургалтын үйлчилгээ
7. Барилга угсралт түүнтэй холбоотой үйл ажиллагаа
8. Мэдээлэл, харилцаа болон сервисийн үйлчилгээ
9. Байгаль орчны мониторинг
10. Хүний нөөц бүрдүүлэлт
11. Цахилгаан бараа болон тавилга ханган нийлүүлэлт
12. Хог хаягдал, бохир ус, био жорлонгийн үйлчилгээ
13. Уул уурхайн компаниудын шатахууны хангалт
14. Хэвлэх үйлчилгээ
15. Химийн бодис, урвалжийн нийлүүлэлт
16. Гадаад худалдаа, бүтээгдэхүүний худалдаа
17. Тээвэр, логистикийн цогц үйлчилгээ
18. Рестораны үйлчилгээ, бүх төрлийн хүлээн авалт
19. Харуул хамгаалалтын үйлчилгээ
20. Үсчин гоо сайхны үйлчилгээ гэсэн эдгээр зүйлс багтаж байна.
21. Зорчигч тээврийн үйлчилгээ
22. Цэвэрлэгээ үйлчилгээ

Эдгээр аж ахуйн нэгжийн хувьд давхардсан тоогоор бүтээгдэхүүн үйлчилгээгээ 120 нь Улаанбаатарт, 93 нь тухайн орон нутагтаа, 42 нь зэргэлдээ болон бүсийн аймгуудад, 14 нь гадаад зах зээлд, 5 нь Монгол улсын хэмжээнд, харин зөвхөн 7 нь ОТ-д нийлүүлж байна. Бүтээгдэхүүн үйлчилгээгээ зөвхөн ОТ-д нийлүүлдэг 7 аж ахуй нэгжийн 4 нь тоног төхөөрөмж, металл бүтээгдэхүүн, эд материал ханган нийлүүлдэг бол үлдсэн нь цэвэрлэгээ үйлчилгээ, хүний нөөц бүрдүүлэлт, геологийн зураглалын үйлчилгээ ханган нийлүүлдэг.


Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 50 хувь нь өөрсдийн борлуулалтаа нэмэгдүүлэх зорилгоор бусад компаниудтай байнгын эсвэл ихэнхдээ холбоотой ажилладаг гэсэн бол 44 хувь нь хааяа, үе үе гэж холбоотой ажилладаг. Харин огт хамтран ажилладаггүй гэж хариулсан нь зөвхөн ОТ-д бүх бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлдэг байгууллагууд болон хувиараа хөдөлмөр эрхлэгч байна.

Зураг 6.6. Бүтээгдэхүүний борлуулалтаа нэмэгдүүлэхээр өөр бусад компанитай холбоотой ажиллаж буй байдал /хувиар/



Ханган нийлүүлэгчдийн 49 хувь нь өөрийн үйл ажиллагаа явуулдаг салбарын бусад компаниудтай сүүлийн 1 жилийн хугацаанд хамтран ажиллаагүй гэсэн бол байнгын хамтын ажиллагаатай байдаг (дандаа, ихэнхдээ) гэж хариулсан нь 37 хувь байна. Ижил чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын ажиллагаа сул, хоорондын хамаарал хамаарал бага байна.

Зураг 6.7. Сүүлийн 1 жилийн хугацаанд өөрийн салбарын бусад компанитай холбоотой ажилласан байдал /хувиар/



ОТ-той сүүлийн 3 жилийн хугацаанд хамтран ажилласан нийт 131 аж ахуй нэгжийн борлуулалтын орлогын мэдээлэлд⁴¹ үндэслэн ханган нийлүүлэгчдийн борлуулалтын орлогын өөрчлөлтийг харвал, 10 сая хүртэлх борлуулалтын орлоготой байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь үндсэндээ хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, орчуулгын үйлчилгээ, үсчний үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ зэргийг багтааж байна. 50 тэрбумаас дээш орлоготой ханган нийлүүлэгчийг авч үзвэл тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь тоног төхөөрөмжийн сэлбэгийн нийлүүлэлт, барилга угсралтын бүтээгдэхүүн тоног төхөөрөмж, далд уурхайн бэхэлгээний төмөр бүтээгдэхүүний нийлүүлэлт, геофизикийн судалгаа, үйлчилгээ байна.

Хүснэгт 6.3. Ханган нийлүүлэгчдийн ОТ-гоос олсон борлуулалтын орлого


Орлогын хэмжээ /төгрөг/	2018 он	2019 он	2020 он
10 сая хүртэл	12	13	17
10-100 сая хүртэл	13	11	16
100-500 сая хүртэл	28	37	39
500- 1 тэрбум хүртэл	10	8	7
1 тэрбум - 10 тэрбум хүртэл	34	31	37
10 тэрбум - 50 тэрбум хүртэл	10	11	9
50 тэрбумаас дээш	5	5	6
Нийт байгууллагын тоо	112	116	131

Ханган нийлүүлэгчдийн ОТ-гоос олсон сүүлийн 3 жилийн орлогыг харьцуулж үзвэл жилийн орлого нь 100 саяас 500 сая болон 1 тэрбумаас 10 тэрбум байдаг аж ахуй нэгжүүд 60 орчим хувийг эзэлж байна. 100 сая хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуй нэгжүүдийн сүүлийн 3 жилд эзлэх хувь нь өссөн. 2020 онд ОТ-гоос олох орлого нь буурсан 50 байгууллага байгаа бол 68 байгууллагын орлого нь өмнөх жилийнхээсээ өссөн. Борлуулалтын орлого нь буурсан аж ахуй нэгжүүд нь ОТ-той 2-18 жилийн хугацаанд хамтран ажиллаж байгаа байгууллагууд бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг харвал ямар нэгэн хамааралгүй байна. Орлого нь 2019 оныхоос даруй 2 ба түүнээс олон дахин өссөн 15 ханган

41 Хамтран ажиллаад 1 эсвэл 2 жил болж буй байгууллагуудын эхний 2 оны борлуулалтын орлогын мэдээлэл байхгүй тул үүнийг мөн тухайн тухайн оноос нь хасаж тооцсон.


нийлүүлэгч байна. Эдгээр байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь эрчим хүчний засвар угсралт, байгаль орчны аудитын үйлчилгээ, геологийн зөвлөх үйлчилгээ, цахилгаан тоноглол сэлбэг хэрэгсэл, даацын шуудайн ханган нийлүүлэлт зэрэг байна.

Зураг 6.8. ОТ-гоос олсон борлуулалтын орлого, төгрөгөөр, хувиар /2018-2020/



Судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд сүүлийн 2 жилийн хугацаанд хамгийн их өсөлттэй байсан зардлын 3 төрөл нь түүхий эд материал, цалин болон тээврийн зардал байна. Доллар, юанийн ханшийн өсөлтөөс шалтгаалан түүхий эдийн үнэ дотоодын зах зээлд өссөн.


Зураг 6.9. Сүүлийн 2 жилийн хугацаанд хамгийн их өсөлттэй байсан зардлын төрөл /давхардсан тоон утгаар/



Ханган нийлүүлэгчдийн 30 хувь нь 2020 онд бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний нэр төрөл огт өөрчлөгдөөгүй гэсэн бол 29.5 хувь бага зэрэг өөрчлөгдсөн, 40 хувь маш их, их, хангалттай их өөрчлөгдсөн гэж үзсэн. Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахлын улмаас сүүлийн 1 жилийн хугацаанд хөл хориотой байсан, улсын хил хаалттай байсан зэргээс шалтгаалан байгууллагуудын 70 хувь нь бүтээгдэхүүн үйлчилгээндээ ямар нэгэн байдлаар өөрчлөлт оруулжээ.

ОТ ханган нийлүүлэгчдийн ажиллагсдын тоог 2019 болон 2020 оноор харьцуулахад дийлэнх нь (121 байгууллага) 50 хүртэлх ажиллагсадтай байгаа бол 100-гаас дээш тооны ажиллагсадтай 21 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 6.10. Ажиллагсдын тоо



2019 – 2020 оны хооронд ажиллагсдынхаа тоог нэмэгдүүлсэн 66 байгууллага, багасгасан 44 байгууллага, өөрчлөлт оруулаагүй 44 байгууллага байна. Ажиллагсдынхаа тоог багасгасан байгууллагуудыг үйл ажиллагааны төрлөөр нь нарийвчлан авч үзвэл барилга угсралт, цахилгаан тоног төхөөрөмжийг нийлүүлэлт, худалдаа, харуул хамгаалалт, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч байгууллагууд байна.


Хүснэгт 6.4. Байгууллагын үйл ажиллагааны төрөл, ОТ-д нийлүүлдэг бараа үйлчилгээ, ажиллагсдын тоо

Үйл ажиллагааны төрөл	ОТ-д нийлүүлдэг бараа үйлчилгээ	2019	2020	Ажиллагсдын тооны өөрчлөлт
Уул уурхай, олборлолт, Цахилгаан, ус хангамж, Барилга	Барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгч	500	430	-70
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Харуул хамгаалалтын үйлчилгээ	380	345	-35
Боловсруулах үйлдвэр	Ган хайлах	210	180	-30
Бөөний ба жижиглэнгийн худалдаа	Шатахууны нийлүүлэлт	234	210	-24
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Хүний нөөц	440	350	-90
Барилга, Бөөний ба жижиглэнгийн худалдаа	Барилга угсралт	400	300	-100
Барилга	Инженерийн үйл ажиллагаа	86	42	-44
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа,	Мэргэжлийн баталгаат орчуулгын үйлчилгээ	50	20	-30
Цахилгаан, ус хангамж	Цахилгааны угсралт	130	40	-90

Бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилга, сургалтын болон, зөвлөх үйлчилгээ, харуул хамгаалалтын үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд ажиллагсдын тоогоо бууруулсан.

Ханган нийлүүлэгчдийн бараг тал хувийнх (63 ААНБ) нь ажиллагсдын цалин 1 – 2 сая төгрөгийн интервалд багтаж байна.

Зураг 6.11. ОТ ханган нийлүүлэгчдийн сарын дундаж цалингийн хэмжээ /төгрөгөөр/




ОТ ханган нийлүүлэгчдийн дундаж цалин 2019 онд 1930561 төгрөг байсан бол 2020 онд 1750685 төгрөг болж, 179876 төгрөгөөр багассан. Гэхдээ Монгол Улсын дундаж цалингаас өндөр байна.

Хүснэгт 6.5. Ханган нийлүүлэгчдийн ажиллагсдын цалингийн талаарх мэдээлэл /төгрөгөөр/


	2019	2020
Хамгийн бага цалин	420000 ₮	420000 ₮
Хамгийн их цалин	18028521 ₮	19501726 ₮
Моод цалин	1200000 ₮	1500000 ₮
Дундаж цалин	1930561 ₮	1750685 ₮

Зураглал, геологи, геотехникийн хэмжилт, бичиглэлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын ажилтны цалин хамгийн өндөр байна. 2020 онд моод цалин мөн нэмэгдсэн байгаа бол дундаж цалин буурсан дүнтэй байна.

Зураг 6.12. Цалингийн тархалт 2019, төгрөгөөр



Зураг 6.13. Цалингийн тархалт 2020, төгрөгөөр




Цалингийн хэмжээ нь абсолют дүнгээрээ буурсан 11, өөрчлөгдөөгүй 48, өссөн 68 байгууллага байна. ОТ ханган нийлүүлэгчдийн ажиллагсдын цалинд Ковид цар тахал төдийлөн нөлөөлөөгүй байна. ОТ-той хамтран ажилласнаар ханган нийлүүлэгчдийн 92,9 хувь нь ажиллагсдын ур чадвар ахихад нөлөө үзүүлсэн гэсэн бол 7,1 хувь нь мэдэхгүй гэжээ. Эндээс харахад ОТ нь ханган нийлүүлэгчдийнхээ ажиллагсдын ур чадвар ахихад тодорхой эерэг нөлөө үзүүлж байна. Ханган нийлүүлэгчдийн тал хувь нь ажиллагсдаа мэргэжил дээшлүүлэх сургалтад байнга хамруулдаг гэсэн бол 32,1 хувь нь хааяадаа хамруулдаг, 9,6 хувь түр хугацаагаар, 5,8 хувь санамсаргүй байдлаар хамруулдаг гэсэн. 2020 онд ханган нийлүүлэгчид ажиллагсдаа:

- Аюулгүй ажиллагааны сургалт /104 байгууллага/
- Чанарын стандартын сургалт /68 байгууллага/
- Мэргэжлийн сургалт /119 байгууллага /
- Аудитын сургалт /11 байгууллага /
- Хувь хүний хөгжлийн сургалт /6 байгууллага /
- Гадаад хэлний сургалт /1 байгууллага /
- Ковидтой холбоотой сургалт /1 байгууллага /-нд тус тус хамруулсан.

2019 онд ханган нийлүүлэгчид дунджаар 55.6 сая төгрөгийн НДШ, 2020 онд 41.9 төгрөгийн НДШ төлсөн. 2020 онд байгууллагуудын төлсөн НДШ буурсан шалтгаан нь Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ буюу байгууллага болон ажиллагсдаас авах шимтгэлийг тус бүр 5 хувь болгон бууруулсан явдал юм. 2020 онд 47 байгууллагын төлдөг НДШ-ийн хэмжээ өссөн. Харин НӨАТ-ыг авч үзвэл 75 байгууллагын (49 хувь) 2020 онд төлсөн хэмжээ нэмэгджээ. ААНБ-ын орлогын албан татварын хувьд 66 ханган нийлүүлэгч байгууллагын төлсөн хэмжээ абсолют утгаараа өсжээ.


Ковид 19 цар тахлын үед ханган нийлүүлэгчдийн 75 хувь ОТ-н худалдан авалтад маш их, их, хангалттай их өөрчлөлт орсон гэсэн бол 19 хувь нь бага зэрэг, 6 хувь нь мэдэхгүй байна гэжээ. ОТ худалдан авалтад маш их өөрчлөлт орсон гэж хариулсан 37 ханган нийлүүлэгчдийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл бөөний болон жижиглэнгийн худалдаа, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд байна. Эдгээр байгууллагуудын 32 хувийнх нь орлого буурсан, 40 хувийнх нь орлого өсжээ.

Зураг 6.14. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ОТ худалдан авалтад гарсан өөрчлөлт, хувиар




Ковид-19 цар тахлын үед бизнесийн хэвийн үйл ажиллагааг явуулахад сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсээс хил гааль хаагдсан, тээвэрлэлтэд хязгаарлалт тавигдсан нь хамгийн том сөрөг үзүүлжээ. Түүнчлэн хол хорионоос үүдсэн сул зогсолт, ОТ-н төсөв буурсан, төслүүд цуцлагдсан, түүхий эдийн үнийн өсөлт, ээлж солигдож чадахгүй болсны улмаас ажиллах хүчний хомсдолд орсон гэх мэт асуудлыг хүчтэй нөлөөлсөн гэж үзжээ.

Зураг 6.15. Ковид-19 цар тахлын үед бизнест хамгийн их нөлөө үзүүлсэн хүчин зүйлс /давхардсан утгаар/



Цар тахлын үед ажиллагсдад үзүүлсэн дэмжлэг (нийт хариултын 62.8 хувь), хамгааллын хэрэгслийн зардал (54.5 хувь), эрүүл мэндийн хэрэгслийн зардал (41,7 хувь)-тай үйл ажиллагааны зардал хамгийн их өссөн. Түүнчлэн түүхий эд материалын үнэ, зээлийн хүүгийн төлбөр цар тахлын нөлөөллийн улмаас өсжээ.

Зураг 6.16. Ковид-19 цар тахлын үед хамгийн их нэмэгдсэн зардлын төрөл /хувиар/



Цар тахлын үед ОТ-той байгуулсан ханган нийлүүлэлтийн гэрээний 84 хувь (130 байгууллага)-д ямар нэг өөрчлөлт ороогүй. Харин 16 хувь буюу 24 байгууллагын гэрээнд ямар нэг байдлаар өөрчлөлт орсон.

Хүснэгт 6.6. Гэрээнд өөрчлөлт орсон шалтгаан /тоогоор/

Шалтгаан	Байгууллагын тоо
Гэрээний хугацаанд өөрчлөлт орсон	8
Гэрээ цуцлагдсан	4
Гэрээнд заасан ажил үйлчилгээний хэмжээ буурсан	4
Гэрээнд тусгагдсан бараа бүтээгдэхүүний үнэнд өөрчлөлт орсон	4
Гэрээний тоо багассан	2
Шинээр хамтарч ажиллах гэрээ хийсэн	1
Хэлэх боломжгүй	1

Ковид 19 цар тахлын үеэр ОТ-той хамтран ажиллахад нийт ханган нийлүүлэгчдийн 81 хувьд нь сөрөг нөхцөл байдал үүсээгүй гэж хариулжээ. Харин сөрөг нөхцөл байдал үүссэн байгууллагуудын хувьд:

1. Хөл хорио, хязгаарлалт тогтоосноос тээврийн үйл ажиллагаа доголдож, захиалсан бараа бүтээгдэхүүнийг хугацаанд нь нийлүүлж чадахгүй хугацаа хоцроох явдал их гарсан.
2. Гэрээт ажил хойшилсон, мөн гэрээ цуцлагдсан нь байгууллагын санхүүг доголдуулсан.
3. Сул зогсолт, нислэг хүлээлт зэрэг гэрээнд тусгагдаагүй шинэ нөхцөл байдал үүссэнээс гарсан

зардлыг байгууллагаас төлсөн.

4. Уурхайн ажиллагсдын ажлын хуваарь тогтвортой бус болсон.
5. Зайнаас ажиллах болсон.
6. Уурхайн талбайд очиж ажиллах болон орон нутгийн иргэдтэй уулзалт хийх боломжгүй болж ажлын гүйцэтгэл хойшилсон зэрэг асуудал гарсан.

ОТ-той хамтран ажиллах болсноор түүвэр судалгаанд оролцогч байгууллагуудын 85 хувь үйл ажиллагаанд нь эерэг үр нөлөө гарчээ. Үүнийг хариултын эзлэх хувиар эрэмбэлэн үзүүллээ. Үүнд:

- Үйл ажиллагааны чанар, стандарт нэмэгдсэн;
- Борлуулалтын цар хүрээ болон орлого нэмэгдсэн;
- Ажиллагсдын тоо нэмэгдэж, ур чадвар, амьжиргаа дээшилсэн;
- Компанийн үйл ажиллагаа өргөжиж, нэр хүнд өссөн, үйлдвэрлэлийн төрөл ба бүтээмж нэмэгдэн дотоодын зах зээлийн хөгжилд нөлөө үзүүлж байна;
- Тогтвортой ажлын байртай болсон;
- Хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг чанд сахин ажиллах болсон;
- Бизнесийн ёс зүй дээшилсэн;
- Орон нутгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна;
- ОТ-д ажилласан туршлагаараа бусад уул уурхайн компанид үйлчилгээ үзүүлдэг болсон.

ОТ-той хамтран ажиллах болсноор гарсан сөрөг үр нөлөөг нээлттэй байдлаар тодруулахад дараах хариултыг өгсөн. Үүнд:

1. Төлбөрийн хоцрогдол буюу төлбөр төлөлтийн хугацаа хэт урт байгаа нь зээл, хүүгийн зардлыг нэмэгдүүлж байна.
2. “Тендерт тавьж буй шалгуур ойлгомжгүй”, “тендерийн хариу удаан гардаг”, “яагаад сонгогдоогүй гэдгээ мэдэхгүй өнгөрдөг”, “тендерийн сонгон шалгаруулалт зарим үед шударга бус санагддаг”,
3. Оюу Толгойтой урт хугацааны гэрээ байгуулж чадахгүй байна,
4. “Худалдан авах үйл ажиллагааны систем хэт олон ханган нийлүүлэгчийн хичээл зүтгэлийг үр дүнгүй, ажиллагаа ихтэй зохион байгуулдаг”, “нэг үнийн саналд хэт олон нийлүүлэгч ажилладаг ба түүний цаана цалин, хангамжтай холбоотой өндөр зардал бага ашиг авдгийг тооцоолдоггүй”;
5. 1 үйлдвэрлэгчээс авах, олон нэр төрлийн бараатай үнийн саналд бид үнэ өгөхдөө бараа тус бүр дээр үнийн тооцоолол хийдэг ч зарим жижиг, үнэ бага барааны үнийг дундаж өртгийн аргаар тооцоолдог. Гэтэл хамгийн бага өртөгт үнэтэй жижиг барааг салгаж РО гаргадаг. 1 үйлдвэрлэгчээс авах барааг /ИТЕМ/салгахгүйгээр РО гаргаж байвал худалдан авч буй болон нийлүүлж буй компанидаа илүү үр өгөөжтэй байна;
6. Урт хугацааны гэрээтэй худалдан авалтын тендерт 1 брэндийн бараа бүтээгдэхүүнийг салгаж олон компаниудад өгдөг нь тухайн барааны үнэ нэмэгдэх, нийлүүлж чадахгүйд хүргэдэг.

6.2. ҮРЖҮҮЛЭГЧИЙН НӨЛӨӨНИЙ ШИНЖИЛГЭЭ

ОТ-н үйл ажиллагааны үр дүнд үүссэн үржүүлэгчийн нөлөөллийг тооцоходоо 2012 онд гүйцэтгэсэн “Монгол Улсын эдийн засагт Оюу Толгойн үзүүлж буй үржүүлэгчийн нөлөө” судалгаанд ашигласан аргачлалын дагуу гүйцэтгэв.

Шууд нөлөө

Энэ судалгаанд ОТ-н шууд нөлөөллийг улсын төсөвт төвлөрүүлсэн орлого ба ОТ-н ажиллагсдын цалин хөлсний өөрчлөлтийн нийлбэрээр тодорхойлсон. ОТ-н шууд нөлөөллийг 2019, 2020 онд улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, төлбөр, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зардлуудад үндэслэн тооцоолов.

Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Хүний хөгжлийн сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрддэг. ОТ компани 2020 онд улсын төсөвт 394.1 тэрбум төгрөгийн татвар, хураамж төлсөн нь өмнөх онтой харьцуулахад 2.22 хувиар буурчээ. Цар тахлын нөлөөгөөр ОТ компанийн орлогын албан татвар, гадаад төлбөрөөс суутгасан татвар, нэмэгдсэн өртгийн орлогын албан татварууд буурсан. 2020 онд орон нутагт төвлөрүүлсэн татварын хэмжээ 2.9 хувиар буурч 82.1 тэрбум төгрөг болсон.

Хүснэгт 6.7. Улсын төсөвт төвлөрүүлж буй татвар, хураамж, сая төгрөгөөр

Татвар, хураамж	2019	2020
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	188,722.7	195,599.6
Орлогын албан татвар	1,201.5	608.4
Гадаад төлбөрөөс суутгасан татвар	37,053.0	23,641.3
НӨАТ /оршин суугч бусаас суутгасан/	64,761.9	49,912.3
Гаалийн татвар хураамж, НӨАТ	63,368.9	72,168.3
Хайгуул, ашиглалтын лицензийн төлбөр	595.9	633.2
Татварын бусад төлбөр, хураамж	47,332.7	51,536.8
Улсын төсөвт төлсөн татвар	403,036.6	394,099.9

ОТ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр олон хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хуулиар хүлээсэн үүргийн дагуу төлбөр төлдөг. Харин Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зорилго нь зах зээлд ажлын байр нэмэгдүүлэх, ажиллагсдын ур чадварыг хөгжүүлэх, ажилгүй иргэдэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. ОТ-н хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оруулсан хувь нэмрийг үнэлэхдээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн төлбөр болон мэргэжлийн боловсролын дэмжих чиглэлээр оруулсан шууд бус хөрөнгө оруулалт болно гэж таамаглав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн төлбөрийг ажиллагсдын зөвшөөрөл, виз болон ажлын байрны хөтөлбөрийн төлбөрийн нийлбэрээр тооцсон.

Хүснэгт 6.8. Орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй татвар, хураамж, сая төгрөгөөр

Татвар, хураамж	2019	2020
Газар, ус, зам, элс ашигласны төлбөр	18,869.8	16,180.9
Үл хөдлөх хөрөнгийн татвар	19,280.8	21,214.1
Тээврийн хэрэгслийн татвар	91.7	61.9
ХХОАТ - цалин, иргэдээс суутгасан	46,074.2	44,586.5
Татварын бусад төлбөр, хураамж	218.7	6.7
Орон нутгийн төсөвт төлсөн татвар	84,535.2	82,050.1

ОТ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2020 онд нийтдээ 6.5 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд 2019 онтой харьцуулахад 31.7 хувиар өсжээ. Бүрэлдэхүүн хэсгээр нь авч үзвэл Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн мөнгөн дүн 22.4 хувиар нэмэгдэж, 4.6 тэрбум төгрөгт хүрсэн. Харин

мэргэжлийн боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалт 61.6 хувиар нэмэгдэж, 1.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 6.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оруулсан төлбөр, хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр

Төлбөр, хөрөнгө оруулалт	2019	2020
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн төлбөр	3,744.0	4,583.0
Мэргэжлийн боловсролын салбарын хөрөнгө оруулалт	1,164.1	1,880.7
Нийт дүн	4908.1	6,463.7

ОТ нь 2020 онд ажиллагсдынхаа эрүүл мэнд болон нийгмийн даатгалын төлбөрт 83.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 2019 онтой харьцуулахад 26.2 хувиар өссөн дүнтэй байна. Түүнчлэн ОТ-н хувьд төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн хэмжээ нь нийт дүнгээрээ 566.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1.3 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 6.10. Төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн дүн

	2019	2020	Нийт
Улсын төсөвт төлсөн татвар	403,036.6	394,099.9	797,136.5
Орон нутгийн төсөвт төлсөн татвар	84,535.2	82,050.1	166,585.3
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хийсэн төлбөр, хөрөнгө оруулалт	4908.1	6,463.7	11,371.8
Нийгмийн болон Эрүүл мэндийн даатгал	66,151.9	83,451.7	149,603.6
Нийт дүн	558,631.8	566,065.4	

Цар тахлын нөлөөгөөр ОТ компанийн улсын төсөв, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн өссөн төдийгүй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хийсэн хөрөнгө оруулалт болон нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийн нэмэгдсэн. ОТ компанийн төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийг төлбөрийн бүтцэд бага зэрэг өөрчлөлт орсон ч ерөнхий дүр зургаараа цар тахлын үед тогтвортой үйл ажиллагаа явуулжээ.

2019 оны жилийн эцсийн байдлаар ОТ-д 3113 дотоод, гадаадын ажилтан ажиллаж байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар ажилтны тоо 2.9 хувиар буурч 3023 болсон. ОТ нь 2019 онд Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд 66.2 тэрбум төгрөг, 2020 онд 83.5 тэрбум төгрөгийн төлсөн. Цалингийн санг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд үндэслэн тооцов.

Хүснэгт 6.11. ОТ компанийн шууд нөлөө

		2019	2020
Татварын нөлөө, сая төгрөгөөр	Улсын дүн	487,571.8	476,150.0
	Ажиллагсдын тоо	3113	3023
Хөдөлмөр эрхлэлтийн нөлөө	Цалингийн сан	264,607.6	333,806.8

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон боловч нийгмийн даатгалын шимтгэл нь хувь хүнээс 10 хувь, байгууллагаас 11-13 хувь, Эрүүл мэндийн даатгал хувь хүнээс 2, байгууллагаас 2 хувь нийт дүндээ 25-27 хувийн төлбөрийг суутгадаг үзвэл 2019 онд цалингийн сан 264,607.6 сая төгрөг, 2020 онд 333,806.8 сая төгрөг болохоор байна.

Шууд бус нөлөө

ОТ-н шууд бус нөлөөг ханган нийлүүлэгчдийнтөлсөн татвар болон тухайн байгууллагын ажиллагсдын цалингийн зардлаар тодорхойлсон. Судалгаанд хамрагдсан ханган нийлүүлэгчдийн төлсөн татварын хэмжээ нь зөвхөн ОТ-той хамтран ажилласантай холбоотой гэх таамаглал тавьсан. Мөн ханган нийлүүлэгчдийн нийт ажиллагсдыг ОТ-той хамтран ажиллахад оролцдог гэж үзэн шууд бус нөлөөллийг тооцсон.

Судалгаанд хамрагдсан 154 байгууллага ОТ-той хамтран ажилласнаар олсон борлуулалтын орлогоо бичээгүй, эхний жилдээ ажиллах гэж байгаа болон хамтран ажилласан жил нь 1-ээс дээш мөртлөө 3 жил дараалан 0 гэж бичсэн зэрэг шалтгаантай улмаас нийт 23 байгууллагын мэдээллийг хасан үржүүлэгчийн тооцоололд 131 байгууллагын тоон өгөгдлийг ашиглав.

Хүснэгт 6.12. Ханган нийлүүлэгчдийн борлуулалтын орлого, сая төгрөгөөр, 2019

№	Борлуулалтын орлого	Ханган нийлүүлэгчдийн тоо	Судалгааны түүвэрт эзлэх хувь
1	10 сая хүртэл	26	19.8 хувь
2	10-100 сая хүртэл	11	8.4 хувь
3	100-500 сая хүртэл	36	27.5 хувь
4	500- 2 тэрбум хүртэл	26	19.8 хувь
5	2 тэрбум - 10 тэрбум хүртэл	18	13.7 хувь
6	10 тэрбум - 50 тэрбум хүртэл	11	8.4 хувь
7	50 тэрбумаас дээш	3	2.3 хувь
	Нийт	131	100 хувь

ОТ-той хамтран ажилласан байгууллагуудыг борлуулалтын орлогоор нь ангилбал судалгаанд хамрагдсан ханган нийлүүлэгчдийн 75.6 хувь нь хоёр тэрбум хүртэл борлуулалтын орлоготой байна. Харин 10.7 хувь нь 10 тэрбумаас дээш борлуулалтын орлоготой ханган нийлүүлэгчид байна. ОТ-той хамтран ажилласан ханган нийлүүлэгчдийн борлуулалтын орлого нь 2018 онд 648.2 тэрбум төгрөг байсан, 2019 онд 616.5 тэрбум төгрөг болон буурсан бол 2020 онд 5.2 хувиар өсөн 648.2 тэрбум төгрөг болсон.

ОТ ханган нийлүүлэгчдийн төлсөн НДШ, НӨАТ болон орлогын албан татварын (ОАТ) нийлбэрээр нийт татварын нөлөөллийг тооцов. 2019 онд судалгаанд хамрагдсан ханган нийлүүлэгчид нийт 109.2 тэрбум төгрөгийн татвар төлсний 23.5 хувь нь НДШ, 44.5 хувь НӨАТ, 32.0 хувь нь ОАТ байна.

Хүснэгт 6.13. Ханган нийлүүлэгчдийн төлсөн татвар, шимтгэл, сая төгрөгөөр

	2019	Эзлэх хувь	2020	Эзлэх хувь
НДШ	25,643.3	23.5 хувь	25,163.9	26.4 хувь
НӨАТ	48,632.3	44.5 хувь	42,232.1	44.2 хувь
ОАТ	34,909.6	32.0 хувь	28,073.1	29.4 хувь
Нийт	109,185.2	100 хувь	95,469.2	100 хувь

Судалгаанд хамрагдсан ханган нийлүүлэгч байгууллагууд 2020 онд 95.5 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсний 26.4 хувь нь НДШ, 44.2 хувь нь НӨАТ, 29.4 хувь нь ОАТ байна. Цар тахлын нөлөөгөөр ханган нийлүүлэгчдийн 2020 онд төлсөн нийт татвар, шимтгэлийн хэмжээ өмнөх оныхоосоо 12.5 хувиар буурсан.

ОТ ханган нийлүүлэгчдэд 2019 оны байдлаар 8001 хүн ажиллаж байсан бол 2020 онд нийт 7,955 ажиллагсад болж ялимгүй буурчээ. Ханган нийлүүлэгчдийн цалингийн санг байгууллага тус бүрийн нийт ажиллагсдын тоо болон дундаж цалингийн тоон мэдээлэлд үндэслэн тооцоолон гаргасан.

Хүснэгт 6.14. Ханган нийлүүлэгчдийн цалингийн зардал, сая төгрөгөөр

	2019	2020
Цалингийн сан	147,150.8	159,866.1

Ханган нийлүүлэгч бүрийн нийт ажиллагсдын тоог тус бүрийн сарын дундаж цалингийн дүнгээр үржүүлэн сарын нийт цалингийн зардлыг олж жил рүү шилжүүлэн нийт цалингийн санг тооцов.

Хүснэгт 6.15. ОТ компанийн шууд бус нөлөө

	Сая төгрөг	2019	2020
Татвар	НДШ	25,643.3	25,163.9
	НӨАТ	48,632.3	42,232.1
	ОАТ	34,909.6	28,073.1
	Нийт	109,185.2	95,469.2
Хөдөлмөр эрхлэлт	Ажиллагчдын тоо	8,001	7,955
	Цалингийн сан	147,150.8	159,866.1

ОТ ханган нийлүүлэгчид 2019 онд нийт 147.2 тэрбум төгрөгийн цалинг ажиллагсдадаа олгосон бол 2020 онд 159.9 тэрбум төгрөгийн цалин олгожээ.

Дам (далд) нөлөө

ОТ компанийн дам нөлөөг нь ханган нийлүүлэгчид ОТ-гоос олсон орлогоо дотоодын эдийн засагт зарцуулах үед гарч буй хэрэглэгчийн зардал, ханган нийлүүлэгчдийн төлж буй татвараар тооцоолсон. Энэхүү судалгаанд ОТ ханган нийлүүлэгчдийн төлж буй НӨАТ-аар татварын дам нөлөөг, зөвхөн ОТ-д бүтээгдэхүүн үйлчилгээгээ нийлүүлдэг аж ахуйн нэгжүүдийн цалингийн зардлаар цалингийн дам нөлөөг тодорхойлсон.

ОТ-н өрхийн хэрэглээнд үзүүлэх нөлөө нь НӨАТ-ын үр дүнд өссөн улсын төсвийг нэмэгдүүлэх замаар эдийн засагт дам нөлөөллийн үр дагаварт хүргэдэг гэж таамаглав.

Хүснэгт 6.16. Ханган нийлүүлэгчдийн төлсөн НӨАТ, сая төгрөгөөр

	2019	2020
НӨАТ	48,632.3	42,232.15

Энэхүү дам нөлөөг тодорхойлохын тулд татварыг ОТ ханган нийлүүлэгчдийн төлсөн НӨАТ-ын мэдээлэлд үндэслэн тооцсон.

ОТ-н хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй дам нөлөөг зөвхөн ОТ-д бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзүүлдэг ханган нийлүүлэгчдийн хувьд ажиллагсдын тоо болон цалингийн зардалд тулгуурлан тооцоолсон.

Хүснэгт 6.17. Зөвхөн ОТ-д бүтээгдэхүүн үйлчилгээгээ нийлүүлдэг ханган нийлүүлэгчдийн төлсөн цалингийн зардал, сая төгрөгөөр

	2019	2020
Цалингийн сан	5,344.3	7,989.9

Зөвхөн ОТ-д бүтээгдэхүүн үйлчилгээгээ нийлүүлэн хамтран ажилладаг 7 аж ахуйн нэгжийн хувьд 2019 онд нийт 239 хүн ажиллаж байсан бол 2020 оны байдлаар 307 хүн ажиллаж байв.

Хүснэгт 6.18. ОТ компанийн дам нөлөө

		2019	2020
Татвар	НӨАТ	60,661.9	54,777.6
Хөдөлмөр эрхлэлт	Ажиллагсдын тоо	239	307
	Цалингийн сан	5,344.3	7,989.9

Эдгээр байгууллага 2019 онд нийт 5.3 тэрбум төгрөгийн цалинг ажиллагчдаа олгосон бол 2020 онд 7.9 тэрбум төгрөгийн цалинг олгожээ.

Оюу Толгойн эдийн засгийн үржүүлэгчийн нөлөөлөл

Шууд, шууд бус, дам нөлөөний нийлбэрээр ОТ-н Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй үржүүлэгчийн нөлөөг тооцов. ОТ нь 2019 онд шууд, шууд бус, дам байдлаар нийт 11353 ажлын байрыг, 2020 онд 11285 ажлын байрыг хадгалж, мөн шинээр үүсгэжээ. 2019 оны байдлаар нийт 417.1 тэрбум төгрөгийн, 2020 онд 501.7 тэрбум төгрөгийн цалинг ажиллагсдад олгосон. Нийт 657.5 тэрбум төгрөгийн татварыг 2019 онд, 626.5 тэрбум төгрөгийн татварыг 2020 онд улсын төсөвт шууд, шууд бус, дам байдлаар төвлөрүүлсэн.

Хүснэгт 6.19. Эдийн засагт үзүүлэх нийт нөлөө

Тэрбум төгрөг		2019				2020			
		Шууд	Шууд бус	Дам	Нийт	Шууд	Шууд бус	Дам	Нийт
Татвар	Нийт	487.6	109.2	60.7	657.5	476.2	95.5	54.8	626.5
Хөдөлмөр эрхлэлт	Ажиллагсдын тоо	3113	8001	239	11353	3023	7955	307	11285
	Цалингийн сан	264.6	147.2	5.3	417.1	333.8	159.9	8.0	501.7
Нийт		752.2	256.3	66.0	1074.5	810.0	255.3	62.8	1128.1

ОТ-н эдийн засагт шууд оруулж буй 1 төгрөг нь шууд бус болон дам байдлаар нийт хэдэн төгрөг болон эдийн засагт үржигдэж байгааг харуулав.

Хүснэгт 6.20. Монголын эдийн засагт ОТ-н үржүүлэгчийн нөлөө

		2019				2020			
		Шууд	Шууд бус	Дам	Нийт	Шууд	Шууд бус	Дам	Нийт
Татвар	Нийт	1.0	0.22	0.12	1.35	1.0	0.20	0.12	1.32
Хөдөлмөр эрхлэлт	Ажиллагсдын тоо	1.0	2.57	0.08	3.65	1.0	2.63	0.10	3.73
	Цалингийн сан	1.0	0.56	0.02	1.58	1.0	0.48	0.02	1.50
Нийт		1.0	0.34	0.09	1.43	1.0	0.32	0.08	1.39

ОТ-н үржүүлэгчийн нөлөөлөл нь 2019 онд 1.43 байна. ОТ-н Монголын эдийн засагт шууд оруулж буй 1 төгрөг нь худалдан авалт, татварын зарцуулалт, шинэ ажлын байрыг үүсгэх замаар буюу шууд бус болон дам байдлаар 1.43 төгрөгийн үнэ цэнийг бүтээжээ. Харин цар тахлын үед буюу 2020 онд ОТ-н үржүүлэгчийн нөлөө нь 1.39 болон буурсан дүнтэй байна.

ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй нөлөө

Жилийн борлуулалтын орлого нь 2 тэрбум төгрөгөөс бага аж ахуйн нэгжүүдийг сонгон авч жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч гэж үзвэл үржүүлэгчийн нөлөө нь дараах байдалтай байна.

Хүснэгт 6.21. Эдийн засагт үзүүлэх нийт нөлөө

Тэрбум төгрөг		2019				2020			
		Шууд	Шууд бус	Дам	Нийт	Шууд	Шууд бус	Дам	Нийт
Татвар	Нийт	487.6	55.8	23.3	566.7	476.2	58.4	21.6	556.2
Хөдөлмөр эрхлэлт	Ажиллагсдын тоо	3113	6766	130	10009	3023	6780	194	9997
	Цалингийн сан	264.6	135.7	4.9	405.2	333.8	146.5	7.5	487.8
Нийт		752.2	191.5	28.2	971.9	810.0	204.9	29.1	1044.0

ОТ-гоос олсон борлуулалтын орлого нь хоёр тэрбум хүртэлх аж ахуйн нэгжүүдэд 2019 онд шууд бус байдлаар нийт 191.5 тэрбум төгрөгийн, дам байдлаар 28.2 тэрбум төгрөгийн нөлөөг үзүүлсэн бол 2020 онд шууд бус байдлаар нийт 204.9 тэрбум төгрөгийн, дам байдлаар 29.1 тэрбум төгрөгийн нөлөөллийг үзүүлсэн.

Хүснэгт 6.22. ОТ-н үржүүлэгчийн нөлөө

Тэрбум төгрөг		2019				2020			
		Шууд	Шууд бус	Дам	Нийт	Шууд	Шууд бус	Дам	Нийт
Татвар	Нийт	1.0	0.11	0.05	1.16	1.0	0.12	0.05	1.17
Хөдөлмөр эрхлэлт	Ажиллагсдын тоо	1.0	2.17	0.04	3.22	1.0	2.24	0.06	3.31
	Цалингийн сан	1.0	0.51	0.02	1.53	1.0	0.44	0.02	1.46
Нийт		1.0	0.25	0.04	1.292	1.0	0.25	0.04	1.288

ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй үржүүлэгчийн нөлөө нь 2019 онд 1.29 буюу ОТ-н эдийн засагт оруулж буй 100 төгрөг нь нийтдээ 129 төгрөг болон үржигдэж нэмэгдэл үнэ цэнийг бүтээсэн бол 2020 онд үржүүлэгч нь 0.04 нэгжээр буурч 1.288 болжээ.

Бүлгийн үр дүн

ОТ ханган нийлүүлэлтэд автомашин, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нийлүүлэлт, засвар үйлчилгээ; ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн нийлүүлэлт; Санхүү, даатгалын үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ; цахилгаан, дулаан болон ус хангамжийн бүх төрлийн үйлчилгээ; хүнсний бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт; судалгаа болон сургалтын үйлчилгээ; барилга угсралт түүнтэй холбоотой үйл ажиллагаа; мэдээллийн технологи болон сервисийн үйлчилгээ; байгаль орчны мониторинг; хүний нөөц бүрдүүлэлтийн үйл ажиллагааны хүрээ илүү тэлж байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд ОТ-гоос 100-500 сая болон 1-10 тэрбум төгрөгийн жилийн орлого олж буй ханган нийлүүлэгчид 60 орчим хувийг эзэлж байна. 100 сая хүртэлх борлуулалтын орлоготой ханган нийлүүлэгчдийн тоо сүүлийн 3 жилд өссөн.

2020 онд ОТ-гоос олох орлого нь буурсан 50 байгууллага байхад 68 байгууллагын орлого нь өмнөх жилийнхээсээ өссөн. Борлуулалтын орлого нь буурсан аж ахуй нэгжүүд нь ОТ-той 2-18 жилийн хугацаанд хамтран ажиллаж байгаа байгууллагууд байсан нь үйл ажиллагааныхаа чиглэлийн хувьд ОТ-той шууд хамааралгүй байна. Орлого нь 2019 оныхоос даруй 2 ба түүнээс олон дахин өссөн 15 ханган нийлүүлэгч байна. Эдгээр байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь эрчим хүчний засвар угсралт, байгаль орчны аудитын үйлчилгээ, геологийн зөвлөх үйлчилгээ, цахилгаан тоноглол сэлбэг хэрэгсэл, даацын шуудайн ханган нийлүүлэлт зэрэг байна.

Цар тахлын үед ажиллагсад үзүүлсэн дэмжлэг (нийт хариултын 62.8 хувь), хамгааллын хэрэгслийн зардал (54.5 хувь), эрүүл мэндийн хэрэгслийн зардал (41,7 хувь)-тай үйл ажиллагааны зардал хамгийн их өссөн. Түүнчлэн түүхий эд материалын үнэ, зээлийн хүүгийн төлбөр цар тахлын нөлөөллийн улмаас өсжээ.

ОТ компани ханган нийлүүлэгчдийнхээ өдөр тутмын үйл ажиллагаанд ажиллагсдын сургалт,

байгууллагын соёл, хамтран бизнес эрхлэх байдал, ажлын байрыг тогтвортой хадгалахад эерэг нөлөө үзүүлсээр байна.

Ковид 19 цар тахлын улмаас ОТ ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаа хязгаарлагдахад хамгийн их нөлөө үзүүлсэн хүчин зүйлс нь хил гааль хаагдсан болон хөл хорио тогтоосноос болж тээврийн хязгаарлалт тавигдсан явдал болжээ. Энэ нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ тогтсон хугацаанд нь хүргэж чадахгүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүйд хүрэх нөхцөл үүсгэсэн.

Цар тахлаас шалтгаалан ОТ-той байгуулсан ханган нийлүүлэгчдийн гэрээнүүдэд хугацаа хойшлуулах, бараа бүтээгдэхүүний үнэд өөрчлөлт орох, тохиролцсон ажил, үйлчилгээний хэмжээнд өөрчлөлт орох зэрэг асуудал тулгарсан.

Ковид-19 цар тахлын үед ОТ-н үйл ажиллагаа хэвийн явагдаагүй бол бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг тэр дундаа уул уурхайн техник тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдаалдаг аж ахуй нэгжүүд, хүний нөөцөөр түр болон бүр хангадаг үйлчилгээний байгууллагууд, хүнсний бүтээгдэхүүнээр хангадаг боловсруулах үйлдвэрлэл, техник тоног төхөөрөмжийг засвар үйлчилгээ үзүүлдэг салбарын үйлдвэрлэл эрхлэгчдэд хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх байжээ.

2019 онд ханган нийлүүлэгчид дунджаар 55.6 сая төгрөгийн НДШ, 2020 онд 41.9 төгрөгийн НДШ төлсөн ч 2020 онд байгууллагуудын төлсөн НДШ буурсан шалтгаан нь Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ буюу байгууллага болон ажиллагсдаас авах шимтгэлийг тус бүр 5 хувь болгон бууруулсантай холбоотой. 2020 онд 47 байгууллагын төлдөг НДШ-ийн хэмжээ өссөн. Харин НӨАТ-ыг авч үзвэл 75 байгууллагын (49 хувь) 2020 онд төлсөн хэмжээ нэмэгджээ. ААНБ-ын орлогын албан татварын хувьд 66 ханган нийлүүлэгч байгууллагын төлсөн хэмжээ абсолют утгаараа өсжээ.

ОТ-н шууд, шууд бус болон дам нөлөөллөөр улсын төсөвт 2019 онд нийт 657.5 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлжээ. Харин цар тахалтай байсан 2020 оны хувьд ОТ компани болон ханган нийлүүлэгчид нийт 626.5 тэрбум төгрөгийн татвар төлжээ.

ОТ-н манай улсын нийт эдийн засагт оруулж буй үржүүлэгчийн нөлөө нь 2019 онд 1.43 байсан бол 2020 онд үржүүлэгчийн нөлөө нь 1.39 болжээ. Харин ОТ-той хамтран ажилладаг ЖДҮ-ийн хувьд тооцсон үржүүлэгчийн нөлөө нь 2019 онд 1.292 байсан ба 2020 онд бага зэрэг бууран 1.288 болжээ.

Цаашдын хандлага

Ковид-19 цар тахлын үед ханган нийлүүлэгчдийн 30 хувь нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний нэр төрлийг огт өөрчлөөгүй, 29.5 хувь бага зэрэг өөрчлөгдсөн, харин 40 хувь нь маш их, их, хангалттай их өөрчлөгдсөнөөс харахад ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаа савласан. Тиймээс ханган нийлүүлэгчид хэвийн нөхцөл байдал руу шилжихэд шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай болж байна.

Ковид 19 цар тахлын үед ханган нийлүүлэгчдийн 75 хувь ОТ-н худалдан авалтад маш их, их, хангалттай их өөрчлөлт орсон гэсэн бол 19 хувь нь бага зэрэг, 6 хувь нь мэдэхгүй байна гэжээ. ОТ худалдан авалтад маш их өөрчлөлт орсон гэж хариулсан 37 ханган нийлүүлэгчдийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл бөөний болон жижиглэнгийн худалдаа, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд байна. Эдгээр байгууллагуудын 32 хувийнх нь орлого буурсан, 40 хувийнх нь орлого өсжээ.

Цар тахлын үед ОТ-н ханган нийлүүлэгчид харьцангуй тогтвортой ажилласныг бататгаж, ханган нийлүүлэгчидтэй харилцах харилцаанд үүсэж буй зарим хүндрэл, саад тотгорыг хамтран даван туулах боломж нээлттэй.

Оюу Толгой Монгол Улсын төсвийн орлого, нийгмийн даатгалын шимтгэлд тогтвортой хувь нэмэр оруулж байгаагийн хэрээр ханган нийлүүлэгчдийн чадавхи сайжирч бэхжих нь орон нутаг, бүс нутаг, үндэсний эдийн засгийн сэргэлт, үнэт зүйлс бүтээгдэхэд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны баг “Ковид-19 цар тахлын үед ОТ-н Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөө” судалгааны хүрээнд макро эдийн засагт үзүүлэх нөлөөг ДНБ, ГШХО, экспорт, татвар төлбөр, хөдөлмөр эрхлэлт; бүс нутагт болон орон нутагт үзүүлэх нөлөөг ОТ компанийн хөдөлмөр эрхлэлт, Өмнөговь аймгийн ДНБ, эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа, ОТ ханган нийлүүлэгчдийн эдийн засгийн үйл хөдлөлийг шинжилснээр харуулж байна. “Ковид-19 цар тахлын үед ОТ-н Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөө”-г авч үзэхдээ судалгааны баг дискрептив болон түүвэр статистик, индекс тооцоолол, эдийн засгийн шинжилгээний холбогдох аргуудыг ашиглан шууд, шууд бус, далд нөлөөллийг илрүүлэхийг зорьсон.

Дэлхийн зэсийн эрэлт хэрэгцээ нь сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон гибрид машин, хотжуулалт, цахилгаанжуулалт, эрүүл мэндийн салбарын өсөлттэй уялдан тасралтгүй өсөх хандлагатай байгаа; дэлхийн нөөцтэй харьцуулахад, Монгол Улсын нөөц нь тийм их биш боловч цаашид Оюу Толгойн гүний уурхай, Цагаан Суварга болон хайгуулын шатанд байгаа бусад төслүүдийн манай улсын зэсийн салбарт чухал нийлүүлэгч болох боломж нь бүрдэж байгаатай холбоотойгоор; уул уурхайн салбарын үндэсний эдийн засагт оруулж байгаа хувь нэмрээрээ Монгол Улс дэлхийд 3-рт орж байгаа; Олон улсын хөдөлмөрийн байгуулагын судалгаагаар нийт хөдөлмөр эрхлэлтэд уул уурхайн салбарын ажлын байр бүтээж байгаа хувиараа Монгол улс дэлхийд 2-рт эрэмбэлэгдсэн гэх зэргээс харахад Монгол Улсын уул уурхайн салбарт илүү эрчимтэй хөгжих нөөц, бололцоо их байгаа тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шинэ ажлын байруудтай болоход тус салбарын хувь нэмэр, ач холбогдол улам өсөх нь тодорхой байна. Иймд үндэсний эдийн засагт уул уурхайн салбарын оруулж байгаа хувь нэмрийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлт, хөгжлийн хөдөлгүүр гэж ашиглах нь чухал бөгөөд тус хувь нэмрийг ашиглан эдийн засгийн бусад салбаруудыг хөгжүүлж, Чили зэрэг улстай адил олон салбарын төрөлжилтийн (диверсификаци) бодлого нэн чухал байгаа юм.

Зэсийн салбарын төсвийн орлогод бүрдүүлэлтэд оруулж буй хувь нэмэр нь өсөх хандлагатай, Ковид-19 цар тахлын үед тогтвортой хадгалагдсан. Монгол Улсын Засгийн газрын нийгэм рүү чиглэсэн хөтөлбөрүүдийг тогтвортой санхүүжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтыг тасралтгүй нэмэгдүүлэхэд ОТ шиг том татвар төлөгчдийн үзүүлэх нөлөө харьцангуй их байна.

Монгол Улсын зэсийн салбарт АМНАТ-ыг жишиг үнээр тооцсон борлуулалтын үнийн дүнгийн 5 хувиар ноогдуулж байгаа нь бусад хөгжиж буй орнуудын зэсийн салбарт ноогдуулж буй татварын хувьтай ижил түвшинд байгаа тул “өрсөлдөх хийгээд арилжааны үндсэн дээр харилцан ойлголцох түвшинд байна” гэж үзэж болно. Борлуулалтад зэсийн үнийн үзүүлэх нөлөө өндөр байгаа тул эрсдэлээс хамгаалах стратеги хэрэгтэй.

2020 оны 12 дугаар сарын байдлаар ОТ 12,364 ажиллагсадтай. ОТ хөдөлмөр эрхлэлтэд Ковид-19 цар тахлын үзүүлэх нөлөөг илрүүлэх түүвэр судалгаанд үндсэн болон гэрээт компанийн 1720 оролцсон. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ОТ-д ажиллагсдын ажлын байр тогтвортой хадгалагдаж, харин өрхийн бусад гишүүдийн цалин орлого хийгээд амьжиргааны түвшин буурахад ажлын цаг багассан, зайнаас ажилласан, бизнес зогсонги байдалд орсон, ашиг буурсан гэх зэрэг хүчин зүйл голлон нөлөөлжээ.

Өмнөговь аймгийн ДНБ, төсвийн орлогын өсөлт бууралт нь Оюу Толгойн үйл ажиллагаатай нягт холбоотой байна. Өмнөговь аймагт Оюу Толгой хэрэгжээгүй бол 2010-2020 оны дунджаар Өмнөговь аймаг төсвийн орлогынхоо 46 хувийг алдахаар байна. Ковид-19 цар тахлын үед Өмнөговь аймгийн төсвийн орлого нийт дүнгээрээ өөрчлөгдөөгүй нь ОТ компанийн төлөлттэй шууд холбоотой.

2020 онд ОТ нь 770 ханган нийлүүлэгчидтэй хамтран ажилласан. Ковид-19 цар тахлын үед ОТ компани ба ханган нийлүүлэгчдийн хамтын үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг илрүүлэх онлайн түүвэр

судалгаанд 154 байгууллага оролцсон. Цар тахлын үед ханган нийлүүлэгчдийн хувьд ажиллагсдадаа үзүүлсэн дэмжлэг, хамгааллын хэрэгслийн зардал, эрүүл мэндийн хэрэгслийн зардал хамгийн их өссөн. Түүнчлэн түүхий эд материалын үнэ, зээлийн хүүгийн төлбөр цар тахлын нөлөөллийн улмаас өсжээ.

ОТ компани ханган нийлүүлэгчдийнхээ өдөр тутмын үйл ажиллагаанд ажиллагсдын сургалт, байгууллагын соёл, хамтран бизнес эрхлэх байдал, ажлын байрыг тогтвортой хадгалахад эерэг нөлөө үзүүлсээр байна. Ковид-19 цар тахлын үед ОТ-н үйл ажиллагаа хэвийн явагдаагүй бол бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг тэр дундаа уул уурхайн техник тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдаалдаг аж ахуй нэгжүүд, хүний нөөцөөр түр болон бүр хангадаг үйлчилгээний байгууллагууд, хүнсний бүтээгдэхүүнээр хангадаг боловсруулах үйлдвэрлэл, техник тоног төхөөрөмжийг засвар үйлчилгээ үзүүлдэг салбарын үйлдвэрлэл эрхлэгчдэд хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх байжээ.

Ковид-19 цар тахлын үед ОТ ханган нийлүүлэгчид нийт 626.5 тэрбум төгрөгийн татвар төлжээ. ОТ-н манай улсын нийт эдийн засагт оруулж буй үржүүлэгчийн нөлөө нь 2019 онд 1.43 байсан бол 2020 онд үржүүлэгчийн нөлөө нь 1.39 болжээ. Харин ОТ-той хамтран ажилладаг ЖДҮ-ийн хувьд тооцсон үржүүлэгчийн нөлөө нь 2019 онд 1.292 байсан ба 2020 онд бага зэрэг бууран 1.288 болжээ.

Дээрх судалгаанаас нэгтгэн харахад, Оюу Толгой Монголын эдийн засагт Ковид-19 цар тахлын үед ихээхэн чухал үүргийг гүйцэтгэж, экспорт, эдийн засгийн өсөлт, татвар бүрдүүлэлтэд томоохон хувь нэмэр оруулан, орон нутгийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтойгоос гадна ирээдүй рүү чиглэсэн боловсон хүчний бэлтгэл, хүний нөөцийг сайжруулахад үр дүнгээ өгч байна. Цаашид дэлхий даяар зэсийн эрэлт өсөх хандлагатай энэ үед Оюу Толгой болон Монголын бусад зэсийн төслүүд манай улсын эдийн засгийн хөгжилд улам их хувь нэмрийг оруулах боломж бүрдэж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол эх сурвалж

БОАЖЯ, НҮБХХ. 2018. Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлал
КПМЖ ТАКС ТМЗ ХХК Хямралын үед баримтлах татварын бодлоготой холбоотой зарим асуудал 2016
МУЗГ, Айвенхоу майнз монголия инк ХХК, Айвенхоу майнз лимитед, Рио тинто интернэшнл холдингс
лимитед. 2009. Хөрөнгө оруулалтын гэрээ
Оюу толгой ХХК. 2019. 2018 оны жилийн тайлан
Оюу толгой ХХК. 2020. 2019 оны жилийн тайлан
Оюу толгой ХХК. 2021. 2020 оны жилийн тайлан
Монголын шилдэг нийтлэгчдийн клубын нийтлэгч Г.Батсүх. 2019. Зэсээр овоглосон Чили орон нийтлэл

Гадаад эх сурвалж

Dominic O'Sullivan, Mubarak Rahamathulla, and Manohar Pawar The Impact and Implications of Covid-19: An Australian Perspective The International Journal of Community and Social development 2020
ICMM. (2016). Role of mining in national economies. 3rd edition
IGF Mining Policy Framework Assessment Kyrgyzstan November 2018
IISD. 2020. Covid-19 response series: The impact of Covid-19 on employment in mining
ILO. (2021). ILO Monitor: COVID-19 and the world of work. Seventh edition
IGF. (2020). The impact of Covid-19 on employment in mining
Jonathan Di John Taxation, Resource Mobilisation and State Performance Crisis States Working Paper Series No.2 2010
McMahon, Gary Joseph Raymond; Moreira, Susana. (2014). The contribution of the mining sector to socio-economic and human development. Extractive industries for development series; no. 30 Washington, D.C.: World Bank Group
OECD Forum on Tax Administration Information Note General Administrative Principles: Corporate governance and tax risk management July 2009
Sebastien Laffitte, Julien Martin, Mathieu Parenti, Baptiste Souillard and Farid Toubal International Corporate Taxation After Covid-19: Minimum Taxation as the New Normal CEPII Policy Brief No.30 April 2020
Simon M. Jowitt Covid-19 and the Global Mining Industry SEG Discovery No.122 July 2020
Stephen Matthews What is "Competitive" Tax System? OECD Taxation Papers No.2
Thomas Moritz, Thomas Ejdemo, Patrik Söderholm & Linda Wårell. 2017. The local employment impacts of mining: an econometric analysis of job multipliers in northern Sweden. Mineral Economics, 2017, vol. 30, issue 1, No 7, 53-65
Responsible Mining Foundation. 2021. Responsible Mining Index
Rio Tinto Group, OT LLC, Perfect Solutions LLC. 2011. The multiplier effect of Oyu tolgoi on Mongolian economy
UNDP. (2020). Human Development Report 2020. The Next Frontier: Human Development and the Anthropocene. New York: United Nations Development Programme
Warwick McKibbin and Roshen Fernando The Global Macroeconomic Impacts of COVID-19: Seven Scenarios
Zambrano, Omar; Robles, Marcos; Laos, Denisse Global boom, local impacts: Mining revenues and subnational outcomes in Peru 2007-2011 IDB Working Paper Series, No. IDB-WB-509

Вэб эх сурвалж

<https://www.1212.mn>

<https://www.ot.mn>

<https://www.uuluurhai.mn>

<https://www.ilo.org>

<https://www.iisd.org/topics/mining>

<https://www.worldbank.org>

<https://www.spglobal.com>

Chilean mining sector expected to be undeterred by 2nd wave of COVID-19

<https://www.ot.mn>

<http://hdr.undp.org/>

<https://www.zolotodb.ru> Горнодобывающая промышленность Перу

<https://www.metalinfo.ru> Горнодобывающая промышленность Перу многое

<https://www.industrialunion.org> Перу: власти ответили на забастовку насилием и ареста

<https://www.metaltorg.ru/> Горнорудной промышленности Перу – MetalTorg.Ru

<https://www.360wiki.ru> Mining Горнодобывающая промышленность в Чили

<https://www.issras.ru>

Наука_Za_rubejom_n55.PDF Оценка перспектив развития горнорудной

<https://www.finmarket.ru> Производство меди в Чили

<https://www.vedomosti.ru> Крупнейшие производители меди в Чили присоединились...

<https://www.metalinfo.ru> Добыча меди в Чили достигла рекордного уровня

<http://www.translom.ru> Добыча меди в Чили – Транслон

<http://news.gorsnab.ru> Горснаб.Ру. Новости горной промышленности.Опубликована статистика по производству базовых и драгоценных металлов в Перу за 2007г

<http://news.gorsnab.ru> Горснаб.Ру. Новости горной промышленности. Руководство британского предприятия Monterrico Metals планирует в течение второго квартала 2008 г.представить обновленные сведения о возможности реализации медного проекта Rio Blanco в перуанском ведомстве Piura.

<http://www.metaltorg.ru> Торговая система MetalTorg.Ru. Новости рынка металлов.

<http://www.metaltorg.ru> Торговая система MetalTorg.Ru. Новости рынка металлов. Jiangxi Copper инвестируетв Перу дополнительно \$ 1.4 млрд.

<http://www.fcx.com> Freeport-McMoRan Copper & Gold. Annual Report 2007 From10-k. 2008

<https://dx.doi.org/10.1787/5kg0h0vmd4kj-en>

https://doi.org/10.1162/asep_a_00796

<http://pubs.geoscienceworld.org/segweb/segdiscovery/article-pdf/doi/10.5382/SEGnews.2020-122.fea-02/5098092/segn-122-3.pdf>

<https://doi.org/10.1007/s10668-020-00934-4>

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1. АЖИЛЛАГСДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН МАЯГТ

МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн (ЭЗХ) нь тус компанийн хүсэлтээр Оюу толгойн эдийн засагт үзүүлж буй дам нөлөөллийг үнэлэх зорилгоор ажилтнуудаас энэхүү судалгааг авч байгаа болно.

Судалгаанд хувийн мэдээлэлтэй холбоотой асуултууд багтсан хэдий ч ЭЗХ Рио Тинтогийн мэдээллийн нууцлалын стандартын дагуу мэдээллийг чанд хадгалах нөхцөлтэй, зөвхөн судалгаанд ашиглах зөвшөөрөлтэйгөөр энэхүү судалгааг авч байна. Та сайн дурын үндсэн дээр доорх судалгааг бөглөж, ажиллаж буй байгууллага тань МУ-ын эдийн засагт ямар хувь нэмэр оруулж буйг тодорхойлоход туслалцаа үзүүлнэ үү. ЭЗХ нь "Монгол Улсын нууцын тухай хууль"-ийг чанд дагаж мөрдөж, хувийн болон бизнесийн мэдээллийг найдвартай хадгалж, гуравдагч этгээдэд мэдээлэхгүй үүрэгтэйгээр ажиллаж байгаа бөгөөд судалгааны нэгдсэн үр дүнг компанид танилцуулна. Судалгаатай холбоотой асуух тодруулах зүйл байвал Ёндонгийн Лхамаатай холбогдоно уу.

Энэхүү судалгааны зорилго нь Оюу Толгой ХХК-ийн ажиллагсдын ажил эрхлэлтийн Улаанбаатар хот, Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, хүн амын амьжиргаанд үзүүлж буй шууд, шууд бус, дам нөлөөллийг Ковид 19 цар тахлын өмнө ба цар тахлын үеэр авч үзэн үнэлэхэд оршино.

Судалгаанд оролцохыг зөвшөөрч байвал доорх хэсэг дээр дарна уу.

1. Тийм
2. Үгүй

→ 101

№	Код	Алхам
СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
101 Нас	1	15-19
	2	20-24
	3	25-29
	4	30-34
	5	35-39
	6	40-44
	7	45-49
	8	50-54
	9	55-59
	10	60-64
	11	65 ба түүнээс дээш
102 Хүйс	1	Эрэгтэй
	2	Эмэгтэй
103 Оршин суудаг газар (Албан ёсны хаягийн бүртгэлээр)	1	Улаанбаатар
	2	Өмнөговь
	3	Ханбогд
	4	Бусад(бичнэ үү)
104 Боловсролын түвшин	1	Бүрэн бус дунд
	2	Бүрэн дунд
	3	Техникийн болон мэргэжлийн/ Тусгай мэргэжлийн дунд
	4	Бакалавр
	5	Магистр/доктор
105 Гэрлэлтийн байдал	1	Гэрлэсэн
	2	Гэрлээгүй
106 Өрхийн нийт ам бүлийн тоо (Нэг орон байранд хамт амьдардаг хүмүүсийнхээ тоог оруулна уу)		<input type="text"/>
107 Хөдөлмөрийн насны өрхийн гишүүний тоо		<input type="text"/> (15 ба түүнээс дээш насны хүн ам)
108 Ажил эрхэлдэг өрхийн гишүүний тоо		<input type="text"/>
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ		
201 Та нийт хэдэн жил хөдөлмөр эрхэлж байна вэ?		<input type="text"/>
202 Үүнээс: Оюу Толгой ХХК-д хэдэн жил ажиллаж байна вэ?		<input type="text"/>

203	Та өөрийн эзэмшсэн мэргэжлийн чиглэлээрээ ажилладаг уу?	1 Тийм 2 Үгүй	
204	Та аль нэгжид ажилладаг вэ?		
205	Таны хөдөлмөрийн гэрээний хугацаа	1 Хугацаатай 2 Хугацаагүй	
206	Таны одоогийн сарын цалин хэдэн төгрөг вэ? (Хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан цалин)	1 1.5 сая хүртэл 2 1.5 саяас 3.5 сая хүртэл 3 3.5 саяас 5.5 сая хүртэл 4 5.5 саяас 8 сая хүртэл 5 8 саяас дээш	
207	Та мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагддаг уу?	1 Байнга 2 Хааяа 3 Түр хугацаагаар 4 Санамсаргүй байдлаар 5 Үгүй	→ 209
208	2020 онд Та ямар сургалтанд хамрагдсан бэ?	A Аюулгүй ажиллагааны сургалт B Ил уурхайн үйл ажиллагааны сургалт C Гүний уурхайн үйл ажиллагааны сургалт D Мэргэжлийн сургалт E Бусад (бичих)	
209	Та Оюу Толгой ХХК-д ажилд орохоосоо өмнө ажил эрхэлж байсан уу?	1 Тийм 2 Үгүй	→ 301
210	Та өмнө нь ямар байгууллагад ажиллаж байсан бэ?	1 Хувиараа хөдөлмөр эрхлэгч 2 Компани 3 Хоршоо 4 Нөхөрлөл 5 ТӨҮГ, ОНӨҮГ 6 Төсвийн байгууллага 7 Төрийн бус байгууллага 8 Бусад	
211	Өмнө нь та сард дунджаар хэдэн төгрөгийн цалин авдаг байсан бэ?	1 1.0 сая хүртэл 2 1.1 саяас 1.5 сая хүртэл 3 1.6 саяас 3.5 сая хүртэл 4 3.6 саяас 5.5 сая хүртэл 5 5.6 саяас 8.0 сая хүртэл 6 8.0 саяас дээш	

№	Код	Алхам
АЖИЛЛАГЧИЙН ӨРХИЙН ОРЛОГЫН МЭДЭЭЛЭЛ		
301	2019	1 1.5 сая хүртэл
		2 1.5 саяас 3.5 сая хүртэл
		3 3.5 саяас 5.5 сая хүртэл
		4 5.5 саяас 8.0 сая хүртэл
		5 8.1 саяас 11.0 сая хүртэл
		6 11.0 саяас дээш
2020		1 1.5 сая хүртэл
		2 1.5 саяас 3.5 сая хүртэл
		3 3.5 саяас 5.5 сая хүртэл
		4 5.5 саяас 8.0 сая хүртэл
		5 8.1 саяас 11.0 сая хүртэл
		6 11.0 саяас дээш

302	Та болон танай өрхийн гишүүд хадгаламжтай юу?	1	Тийм		
		2	Үгүй	→	304
303	Танай өрхийн нэг жилд хийдэг хадгаламжийн хэмжээ 2019 онтой харьцуулахад 2020 онд хэрхэн өөрчлөгдсөн бэ?	1	Өссөн		
		2	Буурсан		
		3	Өөрчлөгдөөгүй		
		4	Хэлж мэдэхгүй		
304	Танай өрхөд цалингийн орлогоос өөр ямар нэгэн орлогын эх үүсвэр (МАА, газар тариалан, өрхийн үйлдвэрлэл гэх мэт) байдаг уу?	1	Тийм		
		2	Үгүй	→	306
305	Тийм бол ямар эх үүсвэр байдаг вэ? (олон сонголттой)	A	Мал аж ахуй		
		B	Газар тариалан		
		C	Өрхийн үйлдвэрлэл		
		D	Хувийн компани		
		E	Түрээсийн орлого		
		F	Хадгаламжийн хүү		
		G	Тэтгэвэр, тэтгэмж		
		H	Бусад		
306	Ковид-19 цар тахлын нөлөөгөөр таны цалингийн орлого 2019 онтой харьцуулахад 2020 онд өөрчлөгдсөн үү?	1	Тийм		
		2	Үгүй	→	308
		3	Мэдэхгүй	→	308
307	Хэрвээ тийм бол ямар шалтгаанаар өөрчлөгдсөн бэ?	A	Ажлын цаг буурсан		
		B	Цалин буурсан		
		C	ХАОАТ-ын хөнгөлөлт эдэлсэн		
		D	НДШ-ийн хөнгөлөлт эдэлсэн		
		E	Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг авсан		
		F	Байгууллагаас цар тахлын үед урамшуулал/дэмжлэг үзүүлсэн		
		G	Бусад(бичнэ үү)		
308	Зөвхөн Ковид-19 цар тахлын нөлөөгөөр танаас бусад танай өрхийн гишүүдийн орлого 2019 онтой харьцуулахад 2020 онд өөрчлөгдсөн үү?	1	Өссөн	→	309
		2	Буурсан	→	310
		3	Мэдэхгүй	→	401
309	Ямар шалтгаанаар өссөн бэ? (Олон сонголттой)	A	Ажлын цаг буурсан		
		B	Цалин буурсан		
		C	ХАОАТ-ын хөнгөлөлт эдэлсэн		
		D	НДШ-ийн хөнгөлөлт эдэлсэн		
		E	Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг авсан		
		F	Байгууллагаас цар тахлын үед урамшуулал/дэмжлэг үзүүлсэн		
		G	Бусад(бичнэ үү)		
310	Ямар шалтгаанаар буурсан бэ? (Олон сонголттой)	A	Ноолуурын үнэ буурсан		
		B	Засгийн газрын шийдвэрээр хил хаасны улмаас хил гарч худалдаа, наймаа эрхлэх боломжгүй болсон		
		C	Хувийн бизнес зогссон, ашиг буурсан		
		D	Ажлын цаг буурсан		
		E	Цалин буурсан		
		F	Ажлын газар хаагдсан, эсвэл цомхтголд орж ажилгүй болсон		
		G	Монгол болон гадаад байгаа хамаатан садангаас мөнгө илгээх боломжгүй болсон, илгээдэг мөнгө буурсан		
		H	Бусад(бичнэ үү)		

№	Код	Алхам			
ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭ, ХУДАЛДАН АВАЛТЫН МЭДЭЭЛЭЛ					
	№	Бараа, үйлчилгээний төрөл	Өссөн	Буурсан	Өөрчлөг деегүй
401	2019 онтой харьцуулахад 2020 онд танай өрхийн худалдан авалт өөрчлөгдсөн үү?	1	Өргөн хэрэглээний бараа		
		2	Эрүүл мэнд		
		3	Боловсрол		
402	Танай өрх боловсролд зориулан жилд дунджаар хэдэн төгрөг зарцуулдаг вэ? (төгрөг)	2019			
		2020			
403	Танай өрх эрүүл мэнддээ зориулан жилд дунджаар хэдэн төгрөг зарцуулдаг вэ? (төгрөг)	2019			
		2020			
404	Оюу толгой компанид ажиллаж эхэлснээс хойш таны амьдралд гарсан өөрчлөлтүүдийн талаар санал бодлоо хуваалцана уу?				

Эерэг

Сөрөг

Судалгаа өгсөн он сар өдөр

сар		өдөр	

Үнэтэй цагаа зарцуулан бидний судалгаанд оролцсонд Танд маш их баярлалаа.

ХАВСРАЛТ 2. ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН МАЯГТ

МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн нь Оюу Толгой төслийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар судалгаа хийж буй бие даасан судалгааны байгууллага бөгөөд энэхүү асуулгаар судалгааны мэдээллийг бүрдүүлэх гэж байгаа болно.

Судалгааны асуулгад хувийн мэдээлэлтэй холбоотой асуултууд багтсан бөгөөд Та эдгээр мэдээллийг өгч, судалгааны санал асуулгад оролцоно уу. МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн нь "Монгол Улсын нууцын тухай хууль"-ийг чанд дагаж мөрдөж, хувийн ба бизнесийн мэдээллийг найдвартай хадгалж, гуравдагч этгээдэд мэдээлэхгүй болно.

Энэхүү судалгааны зорилго нь Оюу толгой төслийн ханган нийлүүлэгчдийн Өмнөговь болон Улаанбаатар хотын нийгэм, эдийн засагт үзүүлэх шууд, шууд бус болон дам нөлөөллийг Ковид 19 цар тахлын өмнө ба цар тахлын үеийн өөрчлөлтөөр үнэлэхэд оршино.

Судалгаанд оролцохыг зөвшөөрч байвал доорх хэсэг дээр дарна уу.

1. Тийм

→ 101

2. Үгүй

№	Код	Алхам
ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
101		Танай байгууллага хэдэн онд байгуулагдсан бэ?
102	1	Танай байгууллага хаана бүртгэлтэй бэ? (Татварын бүртгэлээр)
	2	Улаанбаатар
	3	Өмнөговь
	4	Ханбогд
	4	Бусад(бичих)
103	1	Танай байгууллагын хариуцлагын төрөл
	2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	3	Компани
	4	Хоршоо
	5	Нөхөрлөл
	6	ТӨҮГ, ОНӨҮГ
	7	Төсвийн байгууллага
	8	Төрийн бус байгууллага
	8	Бусад
104	1	Танай байгууллагын хөрөнгө оруулалтын хэлбэр
	2	(Хамтарсан гэдэг нь дотоодын ба гадаад улсын хуулийн этгээдэд хамтран байгуулсан)
	3	Дотоод
	3	Гадаад
	3	Хамтарсан
105		Танай байгууллага Оюу толгой ХХК-тай хэдэн жил хамтран ажиллаж байна вэ?

№	Код	Алхам
ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ		
201	A	Танай байгууллагын үйл ажиллагааны хүрээг тодорхойлбол:
	B	ХАА, ойн аж ахуй
	C	Уул уурхай, олборлолт
	D	Боловсруулах үйлдвэр
	E	Цахилгаан, ус хангамж
	F	Барилга
	G	Зочид буудал, зоогийн газар
	H	Тээвэр, агуулахын АА, холбоо
	I	Бөөний ба жижиглэнгийн худалдаа
	J	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа
	K	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа
	L	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа
	M	Боловсролын салбарын үйл ажиллагаа
	N	Эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа
	O	Урлаг, үзвэр, тоглоом, наадам
	O	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа

202	Танай байгууллагын Оюу толгой ХХК-д үзүүлэх гол 3 төрлийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг нэрлэнэ үү.	1 2 3																																					
203	Танай байгууллага бүтээгдэхүүнээ хаана борлуулдаг вэ?	A Орон нутагт B Зэргэлдээ аймагт C Бүсийн аймгуудад D Улаанбаатарт E Гадаад зах зээлд F Хаашаа (бичих)																																					
204	Бүтээгдэхүүний борлуулгаа нэмэгдүүлэхээр өөр бусад компанитай холбоотой байдаг уу?	1 Дандаа 2 Ихэнхдээ 3 Үе үе 4 Заримдаа 5 Огт үгүй																																					
205	Сүүлийн нэг жилийн хугацаанд өөрийн салбарын бусад компанитай холбоотой ажилласан уу? (жишээлбэл, хамтарсан хөрөнгө оруулалт, хантарсан төсөл, бүтээгдэхүүний хөгжил гэх мэт)	1 Дандаа 2 Ихэнхдээ 3 Үе үе 4 Заримдаа 5 Огт үгүй																																					
206	Танай байгууллагын Оюу Толгой төслөөс олсон борлуулалтын орлого сүүлийн 3 жилд хэд болсон бэ?	<table border="1"> <tr> <td>Он</td> <td>Оюу толгой төслөөс олсон жилийн борлуулалтын орлого, сая төгрөг</td> </tr> <tr> <td>2018</td> <td></td> </tr> <tr> <td>2019</td> <td></td> </tr> <tr> <td>2020</td> <td></td> </tr> </table>	Он	Оюу толгой төслөөс олсон жилийн борлуулалтын орлого, сая төгрөг	2018		2019		2020																														
Он	Оюу толгой төслөөс олсон жилийн борлуулалтын орлого, сая төгрөг																																						
2018																																							
2019																																							
2020																																							
207	Танай байгууллагын хувьд сүүлийн 2 жилийн хугацаанд хамгийн их өсөлттэй байсан зардлын 3 төрлийг тэмдэглэнэ үү (Олон сонголттой)	<table border="1"> <thead> <tr> <th></th> <th>Зардлын төрөл</th> <th>2019</th> <th>2020</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>A</td> <td>Түүхий эд материал</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>B</td> <td>Цалин</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>C</td> <td>Түрээс</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>D</td> <td>Хүү</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>E</td> <td>Тээвэр</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>F</td> <td>Түлш, шатахуун</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>G</td> <td>Элэгдэл</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>H</td> <td>Бусад(бичих)</td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>		Зардлын төрөл	2019	2020	A	Түүхий эд материал			B	Цалин			C	Түрээс			D	Хүү			E	Тээвэр			F	Түлш, шатахуун			G	Элэгдэл			H	Бусад(бичих)			
	Зардлын төрөл	2019	2020																																				
A	Түүхий эд материал																																						
B	Цалин																																						
C	Түрээс																																						
D	Хүү																																						
E	Тээвэр																																						
F	Түлш, шатахуун																																						
G	Элэгдэл																																						
H	Бусад(бичих)																																						
208	Танай байгууллагын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний нэр төрөл 2020 онд хэрхэн өөрчлөгдсөн бэ?	1 Маш их 2 Их 3 Хангалттай 4 Бага 5 Өөрчлөгдөөгүй																																					
№	Код	Алхам																																					
ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ																																							
301	Танай байгууллагын нийт ажиллагчдын тоо	1 2019	<table border="1"><tr><td></td><td></td><td></td><td></td></tr></table>																																				
		2 2020	<table border="1"><tr><td></td><td></td><td></td><td></td></tr></table>																																				
302	Танай байгууллагын сарын цалингийн дундаж хэмжээ хэд вэ? (төгрөгөөр)	1 2019	<table border="1"><tr><td></td><td></td><td></td><td></td></tr></table>																																				
		2 2020	<table border="1"><tr><td></td><td></td><td></td><td></td></tr></table>																																				
303	Оюу толгой ХХК танай байгууллагын ажиллагчдын ур чадвар ахихад хэрхэн нөлөөлсөн бэ?	1 Маш их 2 Их 3 Хангалттай 4 Бага 5 Мэдэхгүй																																					
304	Танай байгууллагад мэргэжил дээшлүүлэх сургалт	1 Байнга																																					

	хэр зэрэг явагддаг вэ?	2	Хааяа						
		3	Түр хугацаагаар						
		4	Санамсаргүй байдлаар						
		5	Бусад					→	401
305	2020 онд танай байгууллага ажиллагчдаа ямар сургалтанд илүү хамруулсан бэ? (олон сонголттой)	A	Аюулгүй ажиллагааны сургалт						
		B	Чанарын стандартын сургалт						
		C	Мэргэжлийн сургалт						
		D	Аудитын сургалт						
		E	Бусад (бичих)						
№	Код	Алхам							
НИЙГМИЙН ДААТГАЛ, ТАТВАРТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ									
401	Нийгмийн даатгалын шимтгэлд сүүлийн 2 жилд хэдэн төгрөгийг төлсөн вэ? (мянган төгрөгөөр)	1	2019						
		2	2020						
402	НӨАТ-т сүүлийн 2 жилд хэдэн төгрөгийг төлсөн бэ? (мянган төгрөгөөр)	1	2019						
		2	2020						
403	Орлогын албан татварт сүүлийн 2 жилд хэдэн төгрөг төлсөн бэ? (мянган төгрөгөөр)	1	2019						
		2	2020						
№	Код	Алхам							
ХУДАЛДАН АВАЛТ БА ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ									
501	Ковид 19 цар тахал Оюу толгой ХХК-ийн худалдан авалтанд хэр хүчтэй нөлөө үзүүлсэн гэж үзэж байна вэ?	1	Маш их						
		2	Их						
		3	Хангалттай						
		4	Бага						
		5	Мэдэхгүй						
502	Ковид 19 цар тахлын үед Таны бизнест хамгийн их нөлөө үзүүлж буй 3 хүчин зүйлийг хэлнэ үү.	A	Ажлын цагийг бууруулах болсон						
		B	Ажиллагчдаа цомхотгоход хүрсэн						
		C	Нийлүүлэх хэмжээ багассан						
		D	Хил гааль хаагдсан						
		E	Тээврийн хязгаарлалт тавигдсан						
		F	ЗГ-ын үр ашиг багатай зохицуулалт						
		G	Бусад (бичих)						
503	Цар тахлын үед танай байгууллагын зардлын төрлөөс хамгийн их нэмэгдсэн 3 төрлийг тэмдэглэнэ үү.	A	Эрүүл мэндийн хэрэгсэл						
		B	Эрүүл мэндийн үйлчилгээ						
		C	Мэдээлэл харилцаа						
		D	Бичиг хэрэг						
		E	Тээвэр логистик						
		F	Ажиллагчдад үзүүлсэн дэмжлэг						
		G	Хамгаалалтын хэрэгсэл						
		H	Бусад (бичих)						
504	Цар тахлын энэ үед танай байгууллагын хувьд Оюу толгой ХХК-ийн ханган нийлүүлэлтийн гэрээнд өөрчлөлт орсон уу?	1	Тийм						
		2	Үгүй					→	506
505	Тийм бол ямар өөрчлөлт орсон бэ?								
506	Ковид19-ийн үеэр Оюу толгой ХХК-тай хамтран ажиллахад ямар нэгэн сөрөг зүйл үүссэн үү?	1	Тийм						
		2	Үгүй					→	508
507	Тийм бол 2020 онд ямар сөрөг зүйл үүссэн бэ?								

--

- 508 Оюу толгой ХХК-тай хамтран ажиллаж эхэлснээс хойш танай компанид өөр ямар өөрчлөлт гарсан бэ?
Жишээ: борлуулалтын өсөлт, салбарын өсөлт, ажилчдын тоо нэмэгдсэн, үйл ажиллагааны стандарт сайжирсан гэх мэт ...

Эерэг

Сөрөг

Үнэтэй цагаа зарцуулан бидний судалгаанд оролцсонд Танд маш их баярлалаа.



14201 Улаанбаатар хот, ш/х-46А430, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-4
Утас/Факс: (976) 7730-7730 (1233), И-хаяг: ei@num.edu.mn